

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 03 дугаар сарын 24-ний өдөр, Даваа гараг
Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-6

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 7-78

1.Сүүлийн өдрүүдэд үүсээд байгаа хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдсан байж болзошгүй гэж үзэж байгаа асуудлын талаар Хууль зүй, дотоод хэргийн сайдын мэдээллийг сонсох 12-56

2.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 03 дугаар дүгнэлт /Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх/ 56-69

3.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 02 дугаар дүгнэлт /Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийн холбогдох зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх/ 71-78

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны
03 дугаар сарын 24-ний өдөр /Даваа гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 22 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 16 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Баттулга, М.Нарантуяа-Нара, У.Отгонбаяр,
Л.Соронзонболд;

Чөлөөтэй: Л.Мөнхбаатар, Х.Тэмүүжин.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням хэлэлцэх асуудлын дарааллын зургаадугаар асуудал болох Сүүлийн өдрүүдэд үүсээд байгаа хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдсан байж болзошгүй гэж үзэж байгаа асуудлын талаар Хууль зүй, дотоод хэргийн сайдын мэдээллийг нэгдүгээр асуудал болгон хэлэлцэх, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир хоёрдугаар асуудал болох Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 03 дугаар дүгнэлтийг нэгдүгээр асуудал болгон хэлэлцэх горимын саналыг тус тус гаргаж, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар нар үг хэлэв.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдиннямын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 6

Бүгд: 16

62.5 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул уг асуудлыг нэгдүгээр асуудал болгон хэлэлцэхээр тогтов.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар дээрх горимын санал дэмжигдсэн тул Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын гаргасан горимын саналыг хоёрдугаар асуудал болгон хэлэлцэхээр санал хураав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 4

Бүгд: 16

75.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул уг асуудлыг хоёрдугаар асуудал болгон хэлэлцэхээр тогтов.

Нэг.Сүүлийн өдрүүдэд үүсээд байгаа хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдсан байж болзошгүй гэж үзэж байгаа асуудлын талаар Хууль зүй, дотоод хэргийн сайдын мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Г.Нарантуяа, мөн Комиссын Гомдол, хяналт шалгалтын хэлтсийн дарга Г.Ууганбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Бат.Баярмаа, М.Отгон, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, Хуулийн газрын референт Г.Нямсүрэн, Хүний эрхийн дэд хорооны ажлын албаны ажилтан С.Хулангаа нар байлцав.

Сүүлийн өдрүүдэд үүсээд байгаа хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдсан байж болзошгүй гэж үзэж байгаа асуудлын талаар мэдээллийг Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Д.Ганбат, С.Эрдэнэболд, Г.Уянгахишиг, Х.Баасанжаргал, Г.Дамдинням, Н.Алтанхуяг, Ч.Лодойсамбуу, С.Цэнгүүн, О.Цогтгэрэл нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Г.Нарантуяа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, О.Номинчимэг, П.Сайнзориг, Д.Ганбат, С.Эрдэнэболд, Г.Дамдинням, Ч.Лодойсамбуу, Д.Цогтбаатар нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Сүүлийн өдрүүдэд үүсээд байгаа хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдсан байж болзошгүй гэж үзэж байгаа асуудлын талаар Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэлийн мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 18 цаг 56 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 03 дугаар дүгнэлт /Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх М.Отгон, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, Хуулийн газрын

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

референт Г.Нямсүрэн, Хүний эрхийн дэд хорооны ажлын албаны ажилтан С.Хулангаа нар байлцав.

Дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Б.Энхбаяр нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Ц.Сандаг-Очир, Д.Ганбат, Б.Энхбаяр, Н.Алтанхуяг, Д.Цогтбаатар нар үг хэлэв.

Д.Цогтбаатар: 1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсэгт “Монгол Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвшихээр бол хийсэн ажлын тайлангаа энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө тарааж болох бөгөөд үүнийг сонгуулийн сурталчилгааны материалд тооцохгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “...тэгш байдал, ...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэснийг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1

Татгалзсан: 15

Бүгд: 16

6.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуягийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 16 гишүүнээс 2 гишүүн дэмжиж, 12.5 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

2.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсэгт “Монгол Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвшихээр бол хийсэн ажлын тайлангаа энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө тарааж болох бөгөөд үүнийг сонгуулийн сурталчилгааны материалд тооцохгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арвандөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэснийг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1

Татгалзсан: 15

Бүгд: 16

6.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсэгт “Монгол Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвшихээр бол хийсэн ажлын тайлангаа энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө тарааж болох бөгөөд үүнийг сонгуулийн сурталчилгааны материалд тооцохгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арвандөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг ...албан тушаал...-оор нь ялгаварлан гадуурхаж үл

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

болно.” гэснийг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1

Татгалзсан: 15

Бүгд: 16

6.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

4.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсэгт “Монгол Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвшихээр бол хийсэн ажлын тайлангаа энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө тарааж болох бөгөөд үүнийг сонгуулийн сурталчилгааны материалд тооцохгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургаадугаар зүйлийн 9 дэх заалтад “...төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй...” гэснийг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1

Татгалзсан: 15

Бүгд: 16

6.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

5.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэгт “Энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой хийсэн уулзалт болон энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “...тэгш байдал,...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэснийг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1

Татгалзсан: 15

Бүгд: 16

6.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

6.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэгт “Энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой хийсэн уулзалт болон энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арвандөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэснийг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2

Татгалзсан: 14

Бүгд: 16

12.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

7.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэгт “Энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой хийсэн уулзалт болон энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арвандөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг албан тушаалаар нь ялгаварлан гадуурхаж үл болно.” гэснийг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1

Татгалзсан: 15

Бүгд: 16

6.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

8.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэгт “Энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой хийсэн уулзалт болон энэ хуулиар хориглоогүй арга хэмжээнд сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургаадугаар зүйлийн 9 дэх заалтад “Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй” гэснийг зөрчсөн байна.” гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2

Татгалзсан: 14

Бүгд: 16

12.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг Улсын Их Хурлын нэгдсэн чуулганд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 19 цаг 49 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 02 дугаар дүгнэлт /Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийн холбогдох зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Бат.Баярмаа, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, Хуулийн газрын референт Г.Нямсүрэн, Хүний эрхийн дэд хорооны ажлын албаны ажилтан С.Хулангаа нар байлцав.

Дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Б.Энхбаяр, Г.Уянгахишиг, С.Эрдэнэболд, Д.Цогтбаатар нар үг хэлэв.

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар Улсын Их Хурлын гишүүдийн ирц хангалтгүй байгааг мэдэгдэж, хуралдааныг хойшлуулав. /20:22/

Уг асуудлыг 20 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 4 цаг 06 минут үргэлжилж, 22 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 72.7 хувийн ирцтэйгээр 20 цаг 22 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 03 дугаар сарын 24-ний өдөр,
Даваа гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
16 цаг 16 минут.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Цогтбаатар: Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаа эхэлье.

Гишүүддээ Байнгын хорооны хуралдаандаа хүрэлцэн ирсэн гишүүддээ юуны өмнө талархал илэрхийлье.

Энэ өдрийн мэндийг дэвшүүлье. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн байгаа тул Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 3 дугаар сарын 24-ний хуралдаан нээснийг мэдэгдье.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Ирц 54.5 хувьтай байна.

Хуралдаанд ирсэн гишүүдийг танилцуулъя. Дамдины Цогтбаатар, Норовын Алтанхуяг, Хүрэлбаатарын Баасанжаргал, Дашдондогийн Ганбат, Одсүрэнгийн Номинчимэг, Салдангийн Одонтуяа, Пүрэвжавын Сайнзориг, Цэндийн Сандаг-Очир, Гончигдоржийн Уянгахишиг, Даваагийн Цогтбаатар, Баттөмөрийн Энхбаяр, Сүхбаатарын Эрдэнэболд гэсэн ийм гишүүдийн ирцтэйгээр ирц бүрэлдсэн байна. Ингээд хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдөр хэлэлцэх 6 асуудал байгаа.

- 1.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 02 дугаар дүгнэлт.
- 2.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 03 дугаар дүгнэлт.
- 3.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төсөл.
- 4.Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төсөл.
- 5.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төсөл.

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

6.Сүүлийн өдрүүдэд үүсээд байгаа хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдсан байж болзошгүй гэж үзэж байгаа асуудлын талаар Хууль зүй, дотоод хэргийн сайдын мэдээллийг сонсоно гэсэн ийм 6 асуудал байгаа.

Энэ дотроос энэ 5 дахь асуудал, 3 дахь, 4 дэх асуудлууд энэ Хууль тогтоомжийн тухай хууль, энэ хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон энэ хуулиуд энэ 3 нь хэлэлцэх эсэх асуудлууд байгаа шүү.

Ингээд хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүд байна уу?

Энэ байнгын, ер нь бол, Дамдинням гишүүний микрофоныг өгье.

Г.Дамдинням: Хууль зүйн байнгын хорооны эрхэм гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе.

Бид нар одоо хэлэлцэх асуудал дээр энэ хамгийн сүүлд орчихсон байгаа poorog.mn гээд энэ залуучуудын хэвлэл мэдээллийн байгууллагуудын эрхэд халдаад байгаа юм шиг харагдаад байгаа боловч нийт Монголын ард түмний мэдэх эрх, эрх чөлөөгөө хамгаалах, чөлөөтэй ярих, өөрийнхөө дархан эрхийг хамгаалах тухай асуудалд халдаж байгаа л асуудал байхгүй юу.

Тэгэхээр Монгол Улсад байгаа төрийн эрх барих дээд байгууллагын хүний эрхтэй холбоотой асуудлыг хэлэлцэх энэ байгууллага нь өөрөө өнөөдөр цаг 4:20 болж байна. 5, 6 асуудлын хамгийн сүүлд оруулж энэ асуудлыг ярихаар дахиад л хүүхдүүдийг хууль зөрчиж шөнөөр барьж аваачаад байцаачихсан юм шиг дахиад шөнөөр хэлэлцэх болчихоод байна л даа. Тэгэхээр нэгэнт нийгмийн анхаарлын төвд байгаа, хүний эрхэд халдчихсан байгаа энэ асуудлыг бол жагсаалтынх нь эхэнд нь оруулчихмаар байгаа байхгүй юу.

Дээрээс нь өнөөдөр Хүний эрхийн Комисс бас дүгнэлтээ гаргачихсан байна. Процессын алдаа гаргасан байна гээд тавьчихсан байна. Хууль зүйн сайд нь Цагдаагийн ерөнхий газрын Хэвлэл мэдээллийн албаны дарга шиг л прокурорын зөвшөөрөл гарсан, үгүй нь мэдэгдэхгүй байгаа энэ нөхцөлд л баахан мөрдөн байцаалтаас мэдэж болох мэдээллүүдийг тавиад л дайрчихсан байна лээ. Хүүхдүүдийг аваачаад үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудлаар яллана гэж баахан мэдүүлэг аваад л, дараа нь хүн амины хэрэгт холбох гэж үзээд л, эцэст нь арай гэж юм тэгээд байгууллагынх нь 1 хүн бэт/bet/ тоглуулсан хэрэгт ороод л ингээд л дуусаж байх шиг байна шүү дээ.

8 хүнтэй байгууллагын 1 хүн нь гэмт хэрэгт орооцолдоод бүтэн байгууллагаар нь шалгадаг юм бол Улсын Их Хурлын 126 гишүүний 1 нь асуудалд орох юм бол үлдсэн 125-ыг нь аваачиж шалгах болчихоод байна шүү дээ. Тэгэхдээ шөнө гүйцэтгэх ажиллагаа явуулаад, хойшлуулшгүй арга хэмжээ авах зайлшгүй шаардлага үүсээгүй байхад хүүхдүүдийг аваачаад ингээд л хорьж шөнөжингөө байцаалт авдаг ийм байдал руу орж болохгүй байхгүй юу.

Тэгэхээр Монгол Улсад байгаа би түрүүн хэллээ төрийн эрх барих дээд байгууллагын хүний эрхтэй холбоотой асуудлуудыг зангидаж нэгдсэн бодлогоор удирдаж явах ёстой энэ байгууллага өнөөдөр энэ хүний эрхийн асуудлыг, монголчуудын мэдэх эрхийн асуудлыг хамгийн 1 дүгээр эгнээнд тавьж байгаад ярьчихъя. Энийг хүмүүс зүгээр хэдэн хэвлэл мэдээллийн байгууллагуудын

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

асуудал гэж хараад байгаа байхгүй юу. Хэвлэлийн эрх чөлөө гэдэг бол Монгол хүн бүрийн эрх чөлөө. Хэвлэн нийтлэх эрх чөлөө гэдэг бол Монгол хүн бүрийн эрх чөлөөг хамгаалах тухай асуудал.

Тэгэхээр энийг бид нар шөнө оройгоор хэлэлцэж болохгүй ээ эрхэм гишүүд ээ. Энийгээ хэдүүлээ 1 дүгээр эгнээнд нь оруулаад ярьчихъя. Хүүхдүүдийг оруулаад ирье энд. Цагдаагийнхан байгууллагуудыг нь оруулаад ирье, тэр Хүний эрхийн Комиссыг нь оруулж ирж байгаад сонсьё л доо. Энэ Монголын ард түмэн энэ гэрэл, гэгээтэй байгаа дээр энэ хүний эрх зөрчсөн, үгүй энэ сэдвийг сонсог л доо. Тэгэхээр Хууль зүйн байнгын хорооны эрхэм гишүүддээ хандаж энэ 6 дугаарт буюу ингээд та бүхэнд 5 асуудал хэлэлцсэний дараа 6 дугаарт орж ирэх асуудал чинь харанхуй шөнөөр хэлэлцэх гээд байна. Тэгэхээр энийгээ больё. Шууд 1 дүгээрт нь аваад хэлэлцээд өгөөч гэдэг хүсэлт гаргая. Ийм горимын санал гаргаж байна. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Санал байгаа юу? Сайнзориг гишүүн, тэгээд дараа нь Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Би сая Дамдинням гишүүний горимын саналыг ерөнхийд нь дэмжиж байна. Тэгээд би нэг зарчмын юмыг бас хэлмээр байна. Бид хэд бас аливаа нийгэмд болж байгаа энэ үйл явдлуудыг бас яг албан ёсны хууль дүрмийн дагуу, тэр хүрээндээ тэр зүйлд оролцдог болмоор байна. Ялангуяа манай Хууль зүйн байнгын хороо, Хүний эрхийн дэд хороо. Тэгэхгүй ингээд бүх зүйлүүд дээр улс төрийн албан тушаалтай нь эхлээд ярина, мэдээллээ авна. Тэгэхгүйгээр шууд ингээд цагдаагийн байгууллага руу довтолдог, үнэн, худал нь мэдэгдэхгүй очиж өөрсдөө ингэж Улсын Их Хурлын гишүүд нь улс төр хийдгээ боль.

Хоёрдугаарт, энэ бүлгийн болоод энэ Байнгын хороо, Дэд хорооны чат дээр албан бус уулзалтуудыг гялс зохион байгуулж өг гээд байгаа. Хэзээ ч Улсын Их Хурлын гишүүд, хууль сахиулах байгууллага шүүх эрх мэдлийн байгууллагатай албан бус уулзалт хийж болохгүй. Протоколтой уулзах ёстой. Албан ёсны энэ хэлэлцэх асуудлынхаа дараалалд оруулж ирж байгаад мэдээллээ авдаг болох ёстой. Ямар горимоороо, хаанаасаа мэдээлэл авчхаад юу хийх гээд байгаа нь мэдэгдэхгүй албан бус уулзалтууд хийж өгөөч гээд тавиад байх юм. Өөрсдөө гүйж очоод байх юм.

Тэгэхээр би бас зарим зүйлүүдийг нөхдөдөө хэлмээр байна. Одоо энэ бас зарим юмнууд чинь хэтрээд байна шүү. Хүний эрх ярьж болно. Хуулийн байгууллага ажлаа хий. Асуудал нь зөрчвөл шат шатанд нь хариуцлагыг нь ярина. Хууль зүйн сайд буюу тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний даваад шууд ингээд хууль сахиулах байгууллагын үүдэнд очиж янз бүр болдгоо болих хэрэгтэй. Энийг чинь ард иргэд ойлгохгүй байна.

Тэгээд сүүлийн үед энэ Хууль зүйн сайд чинь бас маш олон зүйл дээр хууль зөрчиж байгаа шүү дээ. Энийг нь бас сонсчихъё. Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг дураараа эвдсэн, Засгийн газрын бүрэн эрхэд халдсан, дураараа дүрэм, журмуудыг хүчингүй болгосон. Би захиргааны бүртгэлээс хасах эрхтэй гээд өөрт нь хуулиар олгогдоогүй эрхийг хэрэгжүүлж байгаа. Тэгээд ингээд цагдаагийн байгууллагын өмнөөс мэдээлэл хийж, хэргийн материалын юмыг задалдаг. Энийгээ хэдүүлээ яг ном дүрмийн дагуу Улсын Их Хурлын дэгийн тухай хуулиар нь ярьяаа гишүүд ээ.

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

Одоо ингээд тал талд албан бус уулзалтууд миний өрөөнд цагдаагийн даргыг дууд, тэрийг дуудаадах гэдэг энэ мессежүүдийг бүлгийн, энэ Байнгын хорооны болон Хүний эрхийн дэд хорооны юун дээр бичдэгээ больцгоо. Энэ чинь цаана юу яваад байгаа юм бэ? Тийм учраас энэ горимын саналыг дэмжээд эртхэн энэ мэдээллээ сонсчихъё. Бас магадгүй бид хэд бас дутуу ойлголттой Алтангэрэлийг шүүмжлээд байж болно шүү дээ. Энийгээ ингээд сонсчихмоор байгаа байхгүй юу. Тэгээд хэдүүлээ ингэж янз бүрийн байдлаар бүгд ингэж түрүүлж оноо авах гээд нэг л ийм л юмнууд явж байна даа гишүүд минь. Тэгээд жоохон хэдүүлээ зарчимтай, протоколтой төрийн ажлыг ном журмын дагуу хуулийн дагуу хийцгээе.

Д.Цогтбаатар: Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Дарга би энэ хэлэлцэх асуудлын дараалалд өөрчлөлт оруулж өгөөч гэж хүсэх гэж байгаа юм. Яагаад гэхээр Төрийн байгуулалтын байнгын хороо өнөөдөр бас зарлачихсан, одоо ирц үүсэж байгаа. Тэгээд Байнгын хорооны даргыг түр орлож байгаа, Байнгын хорооны дарга гадаадад томилолттой байгаа. Тэгээд миний бие даргалж явуулах ёстой байгаа. Тэгээд Номинчимэг гишүүний энэ Үндсэн хуулийн цэц дээр орсон маргааны асуудал дээр энэ асуудлыг бас хэлэлцье.

Өнөөдөр Цэцээс дүгнэлт ирснээс хойш 7 хоногийн дотор хэлэлцэх хуулийн хугацаа заавал өнөөдөр байх ёстой. Тэгээд Төрийн байгуулалт, Хууль зүй 2 заавал өнөөдөр хэлэлцэх ёстой. Тэгэхээр би Номинчимэг гишүүн бид 2 яг энэ 03 дугаар дүгнэлттэй холбогдуулаад Хууль зүй болоод Төрийн байгуулалт дээр хуульд оролцох болчихоод байгаа учраас эхний хэлэлцэх асуудалд оруулж өгөөд тэгээд бид хоёрыг бас Төрийн байгуулалт руу чөлөөлж өгөөч гэсэн ийм зарчмын санал, горимын санал гаргаж байна.

Д.Цогтбаатар: Ойлголоо. Ингэе энэ хэлэлцэх асуудлын дэс дарааг Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлөөр бид нар шийддэг. Тэгээд үүгээрээ даргын дэргэдэх зөвлөл дээр баталчихсан байгаа юм.

Дамдинням гишүүний юунд би хариулт өгчихмөөр байна. Энэ хурлыг хийе гэж би өөрөө санаачилж хийж байгаа юм шүү. Та манай Байнгын хороон дээр орж ирээд бид нарт юу хийхийг, ямар дэс дараагаар, та явах гээд таны цаг давчуу байж байж болно. Манай Байнгын хороо таны цагт захирагдаж хурлаа хийхгүй. Бид нар өөрөөр хэлбэл энэ юугаа, та аягүй зөв асуудал ярьж байгаа учраас хүлээж сууж байгаад асуудал хэлэлцэгдэх үед нь оролцоод явахыг би танаас хүсэж байна. Би бүүр таныг уриад эндээс суугаад оролцоосой гэж бодож байна.

Г.Дамдинням: Горимын санал гаргах эрх ямар ч гишүүнд байгаа Цогтбаатар дарга аа. Та бас намайг, би Их Хурлын гишүүн шүү. Танай Байнгын хорооны гишүүн биш байж болно. Би Монгол Улсын Их Хурлын гишүүн.

Д.Цогтбаатар: Тийм учраас танд үгийг чинь өгч байна. Тийм, би танд тийм учраас үгийг чинь өгч байна. Тийм, тийм, тэгэхдээ би харин би танд бас хариугаа хэлж байна. Тийм, би Сайнзориг гишүүнд нэг зүйлийг хэлмээр байна. Та ингээд Байнгын хороо руу чиглээд Байнгын хороо энэ цагдаагийн үүдэнд очоод суучихсан юм шиг саяын наад үгнээс чинь олон түмэн тэгээд ойлгочхож байгаа байхгүй юу.

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

Үгүй үгүй, харин таны үг яг тэгээд хэлэгдсэн. Та өөрөө бичлэгээ үзээрэй. Тэгэхлээр харин тийм, харин тийм, тэгэхлээр тэрийгээ та тодорхой яриарай. Тийм тийм тэгэхлээр Сайнзориг гишүүн ээ яг таны ярьж байгаагаар явж байгаа шүү. За за. Тэгэхлээр харин нэг зүйлийг, би тэгэхдээ та нарын хэлсэнд л хариу өгч байгаа шүү.

Хууль зүйн сайдын мэдээллийг энэ Байнгын хороо сонсох эрхтэй. Түүнээс тэр цагдаа эд нар руу бид ороогүй байна. Тэр эхний өдөр бид нар цагдаагаас мэдээлэл авдаг чинь бүр хууль сануулж байгаад бид нар зөвхөн хэвлэлийн эрх чөлөөнд халдсан ийм үйлдэл байна уу, үгүй юү гэдэг дээр тайлбар өгөөч. Өөр бид нар юунд чинь ч орохыг хүсэхгүй байна гээд Баасанжаргал гишүүний бас яг адилхан л энд байгаа гишүүн тавьсан саналын дагуу бид нар хуулийн хүрээнд асуулт асуугаад л, мэдээлэл сонсоод л явуулсан. Өөр тэн дээр ямар нэгэн дараагийн үйлдэл хийгээгүй бөгөөд тэрний дараа одоо бид нар сайдаа авчирч байгаад харин Улсын Их Хурлын гишүүн бөгөөд Хууль зүйн сайдыг авчирч байгаад мэдээллийг нь сонсох гэж байна. Сонсохоос ч өөр аргагүй нөхцөл байдал үүсээд байна шүү дээ. Тэгэхлээр та нар маань бас яг энэ дээр тэр өнцгөөсөө хандаарай.

Сандаг-Очир гишүүн ээ нэгэнт үүгээрээ ингээд батлагдсан байгаа юм чинь миний санал бол ерөөсөө энэ дэс дараагаараа явмаар байна. Тэгэхдээ энэ дээр Дамдинням гишүүн нэгэнт санал гаргасан байгаа болохлоор Дамдинням гишүүний саналаар санал хураая. Тэгээд өөрөөр хэлбэл 6 дугаар асуудлыг 1 дүгээр асуудал болгож өгөөч гэж байна шүү дээ.

Тэгээд үүгээр 6 дугаар асуудлыг 1 дүгээр асуудал болгооч гэснийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураая.

Тэгвэл 6 дугаар асуудлыг 1 дүгээр асуудлаар хэлэлцье гэж байна. Тэгээд 6 дугаар асуудлыг 1 дүгээр асуудлаар болгож байна. Тэгвэл бусад асуудлыг нь ингээд хэвэнд нь, өөрөөр хэлбэл дэс дараагаар нь явъяаа гэсэн.

Сандагаа гишүүний юуг тэгэхлээр чинь наадах чинь тэртээ тэргүй 2 дугаар асуудал болох нь байна шүү дээ.

Тэгье. Тэгвэл Сандагаа гишүүний саналыг 2-оор санал хураая. Сандагаа гишүүний саналыг 2 дугаар санал болгоё гэж санал хураая.

75 хувиар санал дэмжигдлээ.

Тэгээд эхний асуудалдаа оръё. Гэхдээ би энэ дээр нээрээ нэг зүйлийг тодорхой хэлмээр байна шүү. Миний санаачилгаар энэ хурал явж байгаа шүү. Түүнээс бид нар энэ асуудлыг хэлэлцэхгүй гээд бултаад, ширээн доогуур ороод зугтаад, хулгайч царайлаад яваад байгаа юм байхгүй шүү. Би зарим гишүүдэд хэлмээр байна. Би зүгээр өөрийнхөө зарчмын хүрээнд л энэ батлагдсан асуудлаа ярьж байгаа болохоос биш, хүүхдүүдийн эрхийг зөрчсөн асуудлыг хэлэлцье гэж оруулж ирээд хэлэлцэж байгаа юм шүү.

Ингээд сүүлийн өдрүүдэд үүсээд байгаа хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдсан байж болзошгүй гэж үзэж байгаа асуудлын талаар Хууль зүй, дотоод хэргийн сайдын мэдээллийг сонсьё. Мэдээллийг, яг үнэн тэгэхлээр тэр түрүүн би хэлсэн цагдаагийн байгууллагыг бид нар яг хуулийнхаа хүрээнд авах мэдээллээ л

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

авсан шүү. Түүнээс ямар нэгэн бид нар процессынх нь талаар мэдээлэл авах гэж юм уу, тэрэнд нь нөлөөлөх гэж ерөөсөө оролдоогүй. Тэр хүрээндээ бид нар мэдээлэл аваад, гарч ирээд яг энэ дээрээ үндэслээд цагдаагийн байгууллагад эндээс өгсөн мэдээлэл нь танай өгч байгаа мэдээлэл хэвлэлийн мэдээлэл зөрүүтэй байгаад байна шүү. Тийм учраас гарч наад жигдэлсэн мэдээллээ өг өө гэдэг бид нар зөвлөмж өгсөн.

Нөгөө талаасаа бид нар харин гарч ирээд хэвлэлдээ хэвлэлийн эрх чөлөө энэ улсад баталгаатай байгаа шүү. Улсын Их Хурал Үндсэн хуулиар олгогдсон хэвлэлийн эрх чөлөөний талдаа байгаа шүү. Сэтгүүлчид ээ энэнээс айж болохгүй, хэлэх үгээ зоригтой хэлээрэй гэдгийг бид нар хэлээд энэ юун дээр мэдээлэл өгсөн байгаа шүү.

Одоо тэгээд түрүүн цагдаагийн байгууллагаас мэдээлэл сонссон. Энэ хооронд бас нэлээн юм өрнөлөө шүү дээ. Өнөөдөр Хүний эрхийн Комиссын ч бас тайлан, дүгнэлт гарчихлаа. Тэгээд тэртэй холбогдуулаад Хууль зүйн сайдын мэдээллийг сонсьё гэсэн. Энэ яг Хууль зүйн байнгын хорооны бүрэн эрхийн хүрээнд байж байгаа асуудал учраас бид нар Хууль зүйн байнгын хорооныхоо эрх мэдлийн хүрээнд Хууль зүйн сайдын мэдээллийг сонсож байгаа шүү.

Ингээд мэдээллийг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Оюунсайханы Алтангэрэл танилцуулна. Алтангэрэл сайдын мэдээллийг сонсьё.

Энэ бол нээлттэй хэлэлцэж байгаа шүү.

О.Алтангэрэл: Тэгэхээр нээлттэй хэлэлцүүлж байна гэж ойлгож байна уу? Бас нэг зүйл тодруулчихъя. Энд прокурорын байгууллага, цагдаагийн байгууллагаас бас шаардлагатай мэдээлэл өгөх гээд ирчихсэн байгаа. Оролцуулаад эхлэх үү? Мэдээллийн дараа шаардлагатай бол дуудах юм уу?

Д.Цогтбаатар: Тэртээ тэргүй өөрсдөө хуулийнхаа хүрээнд л мэдээллээ өгөх юм чинь оролцуулж болж байна. Хүний эрхийн Комиссоос бид нар бас урьсан байгаа. Хүний эрхийн Комисс ирж амжаагүй. Өнөөдөр дүгнэлтээ хэлчихсэн байгаа. Гэхдээ ирнэ биз дээ? Ирэх ёстой. Бид нар урьчихсан байгаа. Тэгээд оруулъя оруулъя тэд нарыг. Ажлын хэсгээс тэгвэл оруулах хүмүүсээ оруулчих.

Алтангэрэл сайдын микрофоныг өгье. Танай хүмүүс орж ирж байтал та танилцуулгаа эхэлж байх нь зөв байх.

О.Алтангэрэл: Прокурорын байгууллагаас 2025 оны 3 дугаар сарын 19, 20, 24-ний өдөр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 29.3 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу цагдаагийн байгууллагад шалгаж буй гомдол, мэдээлэл, хэрэг бүртгэлтийн дугаар хэрэгт олгосон нийтэд мэдээлэл өгөх зөвшөөрлийн хүрээнд та бүхэнд мэдээлэл өгч байна.

Хэрэг бүртгэлтийн дугаар хэргийн талаар.

Монгол Улсын нэр бүхий иргэд нь цахим орчинд ашиг олох зорилгоор покер платформ, мэдээллийн технологи, бусдын арилжааны банкны дансыг ашиглан үр дүнг нь урьдчилан төсөөлөх боломжгүй, аз туршсан мөрийтэй тоглоомыг тоглохыг

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

иргэдэд сурталчлан зохион байгуулж, гэмт хэргийн замаар олсон хөрөнгийн эх үүсвэрийг нуун далдлах зорилгоор хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө худалдан авч, улмаар бизнесийн үйл ажиллагаа явуулан мөнгө угаасан гэмт хэрэгт 2024 оны 6 дугаар сарын 11-ний өдөр хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна. Мөрдөн шалгах ажиллагаагаар noorog.mn сайтад ажилладаг 1 иргэний арилжааны банкны данснуудаар мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэргийг үйлдэж, 85544 удаагийн үйлдлээр нийт 9.2 тэрбум төгрөгийн, 9430 ам.долларын нийт 9.3 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн тус тус нөхцөл байдал урьдчилан тогтоогдсон байна.

Цаашид Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар хэргийг тал бүрээс нь бүрэн нотлох зорилгоор мөрдөн шалгах ажиллагаа үргэлжлүүлэн явуулж байна.

Хэрэг бүртгэлтийн дугаар хэргийн талаар.

Цагдаагийн байгууллагын 102 тусгай дугаарын утсанд 2024 оны 9 дүгээр сарын 6-ны өдөр тэд дугаарын утаснаас тэдэн настай эмэгтэй тэр нь гэртээ боомилсон байдалтай нас барсан байна гэх дуудлага мэдээлэл ирүүлснийг хүлээн авч, ЧД-ийн Цагдаагийн газрын 1 дүгээр хэлтсээс 2024 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.

Мөрдөн шалгах ажиллагааны явцад амь хохирогчийн хамтран амьдрагчид холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар мөрдөн шалгах ажиллагааг үргэлжлүүлж явуулж байна.

Мөн гомдол, мэдээллийн талаар.

Би энэ дугааруудыг нь зориуд бас орхиж уншаад байна.

Эрүүгийн цагдаагийн албаны Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газарт 2025 оны 3 дугаар сарын 17-ны өдөр танайх ажлаа хийдэг юм уу? noorog фэйсбүүк пэйж/facebook page/ хуудаснаас худал мэдээлэл их оруулах юм. Худал мэдээллээс болж хүмүүс амиа хорлох оролдлого хийлээ шүү дээ гэх гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл ирүүлснийг цахимаар хүлээн авч, цагдаагийн байгууллагын гомдол, мэдээллийн бүртгэлд оруулан шуурхай шалгах шаардлага үүсгэж, хойшлуулшгүй тохиолдолд мөрдөн шалгах ажиллагаа явуулсан байна.

Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газраас мөрдөн шалгах ажиллагааг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 22.4 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэгт заасныг баримтлан БЗД-ийн прокурорын газрын хяналтын прокурорт харилцаа холбооны хэрэгсэл ашиглан мэдэгдэж, БЗД-ийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “Ноорог креатив студио” /Noorog creative studio/ компанийн оффист хойшлуулшгүй тохиолдолд хэргийн газрын үзлэг хийсэн.

Хураан авсан эд зүйлд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 23.1 дүгээр зүйлийн 3, 5 дахь хэсгүүдэд тус тус зааснаар үзлэг хийхэд хувь хүний нууцад халдах, хувь хүний нууцыг задруулах, мөрийтэй тоглоом зохион байгуулах зэрэг баримт мэдээлэл илэрч тухайн мэдээллүүд нь гэмт хэргийн шинжтэй болзошгүй нөхцөл байдал тогтоогдсон тул сэжигт нэр бүхий иргэдийг хойшлуулшгүйгээр баривчлах тухай мөрдөгчийн тогтоол үйлдэн Нийслэлийн

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

прокурорын газарт жижүүрийн прокурорт танилцуулахад тус тогтоолыг хүлээн авахаас татгалзсан.

Дээрх гомдол, мэдээлэл, хэрэгт явуулж байгаа мөрдөн шалгах ажиллагаа нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдсан бөгөөд “Ноорог креатив студио”/Noorog creative studio/ компанитай холбоотой хэвлэн нийтлэх, үгээ хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эрх чөлөөг хөндөөгүй хийсэн контент бичлэг, түүний агуулгатай холбоогүй болно.

Одоо Ноорог креатив студио/Noorog creative studio/ компанийн нэр бүхий ажилчидтай холбоотой 1 гомдол, мэдээлэл, 2 хэрэг бүртгэлтийн хэргийг хуулийн хугацаанд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.2 дугаар зүйлд заасан нотлогдвол зохих байдлыг бүрэн тогтоох чиглэлээр прокурорын хяналтад холбогдох мөрдөн шалгахыг үргэлжлүүлж явуулж байна гэсэн энэ прокурорын зөвшөөрлийн хүрээн дэх цагдаагийн газрын албан ёсны мэдээлэл байна.

Үүн дээр нэмээд мэдээлэл өгөхөд 2025 оны 3 дугаар сарын 17-ны шөнө ийм ажиллагаа явагдлаа. Хойшлуулшгүй ажиллагаа явуулж, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдсан байна гэсэн ийм асуудал үүссэн учраас миний бие өөрийн үүргийн хүрээнд хүний эрхийг хангах чиглэлээр ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа, хууль зөрчсөн үйл ажиллагаа явуулж байгаа эсэх талаар цагдаагийн байгууллагаас тодруулга авсан.

Авсан тодруулгын хүрээнд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байна гэсэн тайлбар өгсөн. Хууль зүй, дотоод хэргийн сайдын хувьд олон нийтийн зүгээс хүний эрх зөрчигдөөд байгаа юм биш үү гэсэн асуудлыг удаа дараалан тавьж байсан учраас та бүхэн энэ асуудлаараа олон нийтэд зохих журмын дагуу мэдээлэл өг өө гэдэг ийм үүрэг чиглэл өгсөн.

Ингээд цагдаагийн байгууллага олон нийтэд мэдээлэл өгсөн. Олон нийтэд өгсөн мэдээлэл дунд тухайлбал сая танилцуулгад уншиж дурдагдсан хууль бус мөрийтэй тоглоом зохион байгуулах зэрэг гэмт хэргүүд хийхэд энэ ямар хэрэг тохоод байгаа юм биш үү, энэ хэргүүд дээр далимдуулан үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдаж байгаа юм биш үү гэсэн асуудал тавьсан учраас Засгийн газрын хуралдаан дээр энэ нөхцөл байдалтай холбоотой зүйлийг танилцуулсан. Энэ бүх үйл ажиллагаа прокурорын зөвшөөрлийн дагуу хийгдсэн. Энэ баримт нь байна.

Ингээд үүний дараагаар энэ үйл явдалтай холбоотойгоор хилс хэрэг тохох гэж байна, хилс хэрэг ярилаа, тогтоогдсон мэтээр ярилаа гээд ийм асуудлууд хөвөрсөн.

Сүүлийн үед өрнөж байгаа нөхцөл байдал гэвэл энэ хэрэгт холбоотой холбогдон шалгагдаж байгаа зарим хүмүүс өөрсдөө мэдээлэл хийж байна. Яг л агуулга энэ 9.3 тэрбум төгрөг гэдэг энэ агуулгыг тойроод л яриад байсан. Тэгээд энэ шалгагдаж байна аа бид нар ингээд шалгагдаж байна. Тэгэхдээ 1 хүн нь байна гэдэг асуудал хөндөгдөж байна. Зарим зүйл, ангиар зарим зүйл хүмүүс нь шалгагдаж байгаа гэсэн асуудал хөндөгдөж байна. Энэ дээр хамгийн гол анхаарах ёстой зүйл бол цагдаагийн байгууллага Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үйл ажиллагаа явуулахдаа хүний эрх зөрчсөн үү гэдэг асуудал дээр л хамгийн гол анхаарал хандуулж байгаа юм.

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

Эдгээр хүмүүсийн гэм буруугийн талаар ямар ч дүгнэлт гараагүй, эцэслэн шийдвэрлээгүй хэрэгт хэнийг ч гэм буруутайд тооцохгүй. Тийм учраас цаашдаа энэ үйл ажиллагааг явуулахдаа прокурорын хяналт дор энэ үйл ажиллагааг хараат бусаар явуул аа гэдэг ийм үүрэг, чиглэл өгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайдын хувьд ажиллаж байгаа.

Нэг зарчим барьж байгаа. Дараа нь асуултууд тавих байх. Нэг зүйлийг бас зориуд тодотгож танилцуулгадаа хэлье. Би Хууль зүй, дотоод хэргийн сайдаар томилогдсоны дараагаар асар олон энэ хууль бус мөрийтэй тоглоомтой холбоотой гомдлууд хүлээж авсан. Энэ гомдлууд дээр үнэхээр амьдралгүй болсон, асар их мөнгө алдлаа гэдэг гомдлууд ирээд би өөрийн биеэр Цагдаагийн ерөнхий газрын даргыг дуудаж, энэ гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр нэн ялангуяа ард иргэдийн тавиад байгаа энэ цахим мөрийтэй тоглоомтой гэмт хэрэгт тэмцэл хийх тэмцлийг идэвхжүүлэх арга хэмжээ ав гэдэг ийм байдлаар үүрэг өгсөн. Энэ талаар холбогдох баримтууд нь ч байгаа.

Ингээд энэ хүрээнд явж байгаа үйл ажиллагаа гэж ойлгосон. Прокурорын бүх зөвшөөрөл бүх юмыг нь агуулгаар бас явж байна. Тэгэхдээ энэ шалгагдаж байгаа хэргийн нэг л хэсэг байгаа. Тэгэхлээр би та бүхэнд тавих хүсэлт бол ийм баланстай хандаасай. Мэдээж алдаа, зөрчил гаргасан энэ талын шүүмжлэл, Их Хурлын гишүүдийн тавьж байгаа шаардлага энэ бүх зүйлүүдийг хүлээж авна. Энэ бол үүрэг.

Нөгөө талаар хууль сахиулах байгууллагын албан хаагчид энэ гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргээ хэрэгжүүлж байгаа шүү. Энэ хууль сахиулах байгууллагын цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг бас хууль журамд заасны дагуу явагдах ёстой. Тэгэхээр та бүхэн, эрхэм гишүүд минь энэ бүхнийг бас анхаарч бодолцож үзээсэй гэж хүсэж байна. Товч танилцуулга хийж дууслаа.

Д.Цогтбаатар: Алтангэрэл сайдад баярлалаа. Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга, Цагдаагийн хурандаа Б.Батзориг хүрэлцэн ирсэн байна. Хүний эрхийн Комиссын гишүүн Нарантуяа гишүүн ирнэ гэсэн байгаа. Энэ арай ирж амжаагүй байх шиг байна. Одоо явж байгаа байх. Гэхдээ хэдүүлээ хурлаа үргэлжлүүлээд явж байя.

Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан асуулт асуух гишүүд, айн? Ийм байна тэгээд Нарантуяа гишүүн удахгүй ороод ирэх байх аа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан асуулттай гишүүд нэрээ өгнө үү. Тусдаа.

Алтанхуяг, Лодойсамбуу гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Сая ингээд өнөөдрийн яах вэ, мэдээж тодорхой хуульд заасны дагуу гэмт хэргийн шинжтэй үйлдлийг шалгаж тогтоох энэ үйл ажиллагаа тодорхой хэмжээнд бас улс төржилтийн гэдэг юм уу, эсвэл бас мэдээллийн

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

зөрүүтэй ч гэдэг юм уу, хаа хаанаасаа алдаа гараад ийм орж ирж байна. Тэгэхээр мэдээж яг энэ гэмт хэргийн шинжтэй үйлдлийг шалгах явцад тэр хэвлэлийн эрх чөлөөнд халдах байдаг юм уу ийм зүйлүүд байж болохгүй байх. Ер нь үнэхээр шалгах ёстой байсан бол шалгаад явна.

Гэтэл бас тодорхой нөхцөл байдлаар анхны мэдээллүүд их буруу өгснөөс болж ийм л нийгэмд уур амьсгал орлоо л доо. Тэгээд би түрүүн хэлэлцэх асуудал дээр хэлээд байгаа зарчим. Би хэн нэгийг ч юм уу энд сууж байгаа хүмүүсээсээ юу ч, хэдүүлээ бас яг ийм асуудлууд гарвал яг тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хүн буюу Хууль зүй, дотоод хэргийн сайдаасаа түрүүлж мэдээллээ авдаг баймаар байгаа юм. Тэгээд ингээд баахан өөрсдөө санаачилгаараа ч юм уу, яг энэ процессын үйл ажиллагаатай зэрэгцээд ингээд цагдаагийн байгууллагыг дуудна ч юм уу иймэрхүү байдлаар хэдүүлээ хандахгүй байя гээд. Тэгэхээр яг энэ сайд нь орж ирээд ийм байна гээд холбооны хүмүүсээсээ ингээд тодруулаад явах нь зөв шүү гэдэг зүйлийг би ярианы эхэнд хэлчихмээр байгаа юм.

Хоёрдугаарт үнэхээр яг энэ хэрэгтэй холбоотойгоор бас их сонин сонин үзэгдлүүд, мэдээллүүд явж эхэллээ. Цагдаагийн байгууллагын албан хаагчид өөрсдөө орооцолдсон гэдэг зүйлүүд явж байна. Өчигдөр иргэн шүгэл үлээсэн гэж ярих уу? Би энэ мөрийтэй тоглоомыг зохион байгуулахад оролцсон хүн байна, зохион байгуулсан хүн байна. Дүүгийнхээ дансыг ашиглаж байсан, энэ дүн маань энэ Ноорогт ажиллаж байсан юм байна. Ажиллаж байгаа. Тийм учраас ийм зүйлүүд байна энэ тэр гээд ярьж байна лээ.

Тэгэхээр энэ тэнд дурдагдаад байгаа цагдаагийн нэр бүхий алба хаагчид, мөнгө төгрөгийн тоо хүртэл яригдаж байна лээ шүү дээ. Тэгэхээр ийм зүйлүүд ингээд дэврээд ингээд явлаа. Энэ дээр бас тодорхой хэмжээний шалгаж байгаа ямар процессын ажлууд хийсэн бэ, хийж байгаа вэ?

Хоёрдугаарт мөрийтэй тоглоомыг Алтангэрэл сайд аа би бас Засгийн газрын гишүүдийнхээ функцийг мэдэхгүй байгаа юм. Уг нь та яриад хориглоно гэж ярих ёстой байтал та ч ярихгүй юм. Өөр сайд нь хориглоно ч гэх шиг, эсвэл спортын бэт/bet/-ийг үлдээгээд бусдыг нь хориглох гэж байгаа гээд. Би мэдээлэл бас ингээд авч чадахгүй байгаа учраас ингэж асууж байгаа юм. Тэгэхээр яг энийг үр дагавар энэ тэрнээс нь сэргийлэхийн тулд Засгийн газар ямар бодлого та хэрэгжүүлэх гэж байна? Энэ дээрээ бас тодорхой хариулт өгөөч.

Тэгээд би бас тантай би хувь өнцөг талаасаа би мэднэ. Хамт зүтгэж байсан хүн. Тэгэхдээ бас эргээд энэ Хууль зүйн сайд, энэ өндөр хариуцлагатай албан тушаал дээрээ бас болгоомжтой байхгүй бол таны яг тухайн өдрийн хэвлэлд өгч байсан тэр хандлага, мэдээлэл яг мөрдөн байцаагч байсан. Хэргийн дотоод мэдээллээс харсан, энэ нөхдүүдийн буруу, булхайг би илчилнэ гэсэн. Энэ хандлага чинь ингээд болж өгөхгүй байгаа байхгүй юу. Тэгэхээр ийм зүйлүүд дээрээ хэдүүлээ бас анхаарч ажилламаар байна. Тэгэхээр энийгээ бас яг өгдөг тэр цагдаагийн.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Алтангэрэл сайд.

О.Алтангэрэл: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Өчигдөр гадаад улсад байдаг гэх иргэн бас мэдэгдэл хийсэн. Тэрийг харсан. Би ганцхан статистик ярианахаа эхэнд хэлчихье. Цагдаагийн байгууллагаас сүүлийн 4 жилд мөрийтэй

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

тоглоом зохион байгуулахтай холбоотой нийт 1360 хэрэг бүртгэлтэй хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас 356 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татан шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт хүргүүлээд 356 хэргээс 299 хэргийг шүүх эцэслээд шийдвэрлэчихсэн байгаа. 299 хэрэг. Энэний хохирол шалгагдсан хэмжээ гэх юм бол маш олон тэрбумаар яригдаж байгаа.

Тэгэхээр энэ дээр цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа явагдаж байгаа гэж ойлгож байгаа. Мэдээж хэрэг энэ дунд холбоотой хүмүүс байхыг огт үгүйсгэхгүй. Тийм ч учраас Хууль зүй, дотоод хэргийн яаман дээр энэ асуудалтай холбоотой бид өнөөдөр асуудлаа судалчихъя. Цагдаагийн албан хаагчдын энэ байж болзошгүй үйлдлийн талаар мэдээлэл бид нар авах ямар арга хэмжээ байж болох вэ, хууль, эрх зүйн хувьд бид нар энэ механизмаа харж байна.

Энэ 299 хэрэг шүүхээр эцэслэн шийдвэрлэгдчихсэн байна гэдэг бол өнөөдөр цагдаагийн байгууллага энэ мөрийтэй тоглоом зохион байгуулах энэ гэмт хэрэгтэй бас тэмцэж үр дүн гарсны илрэл гэж үзэж байгаа. Өнөөдөр явж байгаа ажил ч гэсэн энэ үр дүн гэж үзэж байгаа.

Хэвлэл, мэдээллээр мэдээлэхдээ анхаарах ёстой гэж хэлж байна. Энэ дээр ойлголоо гишүүн ээ би бас саналыг авч байна. Энэ албан хаагчдын талаар, цагдаагийн байгууллагын албан хаагчдын талаар үйл ажиллагаа явуулсан энэ талаар нь авч үзэхдээ би Хууль зүй, дотоод хэргийн сайдын хувьд цахим мөрийтэй тоглоом чинь болохоо байлаа, энэ дээр та нар арга хэмжээ ав гэж шахаад, дараа нь асуудал тавихаар ийм ийм прокурорын зөвшөөрлийн дагуу энэ хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна гэхээр хууль сахиулах байгууллагын албан хаагчдадаа тайлбар өгөх шаардлагатай гэж үзсэн.

Дээрээс нь энэ дээр 2 төрлийн баримт хэлсэн. Үг, өгүүлбэрээр нь хэлэхэд 9.3 тэрбум төгрөгтэй холбоотой мэдээлэл байна гэж хэлсэн. Тэгээд бусдыг амиа хорлоход гэмт хэрэгтэй холбоотой хэрэг шалгагдаж байна гэж хэлсэн. Тэгээд энэ асуудалтай холбогдуулан яг энэ шүүмжлэлтэй байр суурь гаргаж байгаа Сайнзориг гишүүний энэ шүүмжлэлийг бас хүлээж авч байна. Цаашид анхааръя.

Цаашдаа бол, мөрийтэй тоглоом хуулиараа Эрүүгийн хуультай байгаа. Одоо цаашаагаа бид нар анхаарах асуудал энэ мөрийтэй тоглоомоос илүүтэйгээр мөнгөний урсгал явж байгаа энэ бэт/bet/ гэдэг асуудлаа яах вэ гэдэг асуудал. Дээрээс нь бид нар энэ мөрийтэй тоглоом дээр ярьж байх үед гаднын сайт, энэ бүтцүүдийг ашиглаж яваад байгаа. Тэгээд энэ хууль бол та мэдэж байгаа, та энэ хуулийг санаачлаад явж байгаа. Дахиад нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотой зүйл Засгийн газар дээр Учрал сайд толгойлоод ингээд аваад явж байгаа.

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Би яг сүүлийн ийм үр дагаврууд ингээд цаашдаа гараад байх нь. Тэгэхээр гаргахгүй байхын тулд Засгийн газар нь тодорхой бодлогоо боловсруулаад Улсын Их Хуралд ямар концепцоор юу оруулж ирэх гэж байна гэдэг зүйлийг л би тодруулж асуугаад байгаа юм. Тэгээд би бас Засгийн газрын байр суурь нь бүрэн хориглох гээд байна уу, бүрэн хориглох нөхцөл байдал байна уу, үгүй юу гэдэг дээр хүртэл жоохон эргэлзээд байгаа юм. Техник, технологийн юугаар тэр Пи Пи Эн-ээр тойруулаад нэр усаа соливол дахиад л ороод ирэх юм шиг байгаа юм.

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

Гэхдээ би энийг мэдэхгүй байна. Засгийн газар албан ёсоор хуулийн төслийг нь өргөн барихаар харъя гэж бодоод бас харзнаад байж байгаа. Тэгэхдээ би зүгээр энэ зарчимд нь хэдүүлээ бас ер нь юмаа авч явъя гэхээр Хууль зүй, дотоод хэргийн сайд энэ бодлогоо бариад уг нь ингээд манлайлаад явмаар байна. Би ингээд танаас асуухаар та ямар ч бодлого байхгүй Учрал сайд юм хийж байгаа гээд байгаа байхгүй юу. Учрал сайд чинь Хэрэг эрхлэх газрын дарга шүү дээ. Тэгээд ийм ингээд яваад байхаар энэ юмнууд дээр чинь бид нар хурдтай хариу үйлдлүүд хийж чадахгүй байна. Хурдтай хариу үйлдлүүд хийж чадахгүй байна. Тэгэхээр бие биеийнхээ энэ асуудлуудыг өмнөөс нь авах гэхээсээ үүдээд уг нь Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний тухай хуулиараа Засгийн газар ажилламаар байна. Би Хууль зүйн сайдаас л энэ асуудлыг асуумаар байгаа байхгүй юу.

Тэгэхээр сая сайд маань ямар ч хариултгүй байна шүү дээ. Та хууль бичиж байгаа, Учрал сайд юм яана гээд. Тэгэхээр ийм л зүйлүүдийг бас цаашдаа ингэж анхаарахгүй бол хаа хаанаа ингээд хариуцлага нь ч гэдэг юм уу, асуудлаа хэнтэй ярихаа би мэдэхгүй болчихоод ч юм уу, энэ гишүүд чинь ингээд хэнтэй ирж, хэнтэй энэ асуудлаа ярихаа мэдэхгүй байгаад байгаа байхгүй юу. Ингээд бөмбөг пассалж байгаа юм шиг л юм болоод байна шүү дээ. Тэгээд би энийг л хэлж байгаа шүү. Тэрнээс биш их энийг улс төржүүлээд байгаа зүйл алга. Тэгээд хэдүүлээ бөөндөө мэдээллээ албан ёсоор нь сонсдог байхгүй бол тал талд мэдээлэлтэй болчихоод тэр чинь тэгсэн юм байна гээд ингээд бас гишүүд байгаад байж болохгүй л гэдэг зарчмын юм хэлж байгаа шүү. Ингээд асуулт алга.

Д.Цогтбаатар: Алтангэрэл сайдад микрофон өгье.

О.Алтангэрэл: Би тодруулга дээр хариулт өгчихье. Сайнзориг гишүүн бас буруу ойлгосон юм шиг байна. Бодлого байхгүй биш шүү. Ажил авангуутаа би түрүүн хэллээ 2025 оны 8 дугаар сараас авхуулаад энэ цахим мөрийтэй тоглоом дээр яах вэ гээд цагдаагийн байгууллагад анхаарал, чиглэл өгч ажиллаж эхэлсэн. Засгийн газрын үүрэг гэмт хэрэгтэй тэмцэх үүрэгтэй. Тэгээд энэ үүргийнхээ дагуу цагдаагийн байгууллага энэ хэрэг дээр мөрдөн шалгалтын ажиллагаа хийгээд энэ олон хэргүүд шүүх рүү шилжээд явж байгаа. Энэний хүрээнд асуудлууд гарч ирсэн.

Харин ч энэ асуудлыг хөндсөн хүрээнд бэт/bet/ рүү асар их мөнгө урсаж байна гэдэг мөнгөн урсгалыг анх цагдаагийн байгууллага гаргаж ирсэн. Би энэ тухайгаа хуульч гишүүдэд тухайлбал, Сайнзориг гишүүн танд, Номинчимэг гишүүнд ийм хэмжээний мөнгө эргэлдэж байна, энэ дээр бодлого бид нар гаргах ёстой юм байна гээд танилцуулаад явж байсан.

Ингээд тийм тийм, ингээд энэ асуудлуудыг танилцуулж явсны үндсэн дээр өнөөдөр төрийн бодлого болоод хууль болоод гарах гэж байгаа. Бидний байр суурь бол гэмт хэрэг болгох ёстой. Хуулиар хориглох ёстой гэсэн ийм байр суурьтай байгаа. Засаг дээр ч ер нь бүгдийг нь хориглоё гэж ч ярьсан. Харин бодлогын хүрээнд засаг дээр шийдвэр гараад, Учрал сайдаар ахлуулаад энэ хуулийн ажлын хэсэг нь гараад явж байгаа учраас тэндээс хуулийн ажлын хэсэг ахалж байгаа гэдгийг хэлснээс биш Хууль зүй, дотоод хэргийн сайдын хувьд энэ асуудал дээр хатуу тэмцэх ёстой гэсэн ийм бодлоготой байгаа гэдгийг тодотгож хэлье.

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

Д.Цогтбаатар: Одоо 1 удаа л байгаа шүү дээ тээ. Сайнзориг.

П.Сайнзориг: Баярлалаа Алтангэрэл сайд. Би, Пүрэвдорж дарга аа би ерөөсөө улс төржөөгүй шүү дээ. Та ингээд өөдөөс харж байгаад улс төржлөө гээд загнаад байх юм. Хэдүүлээ энэ дээр ингээд Хууль зүйн байнгын хороо зарчим, мэдээллээ авч байна аа л гэж ойлгож байгаа юм.

Хоёрдугаарт, би Алтангэрэл сайд аа та нар бас мэдээлэлдээ бас хариуцлагатай хандаарай. Би мэдээллийг удаа дараа авъя гэж тантай чуулганы танхимд энэ дээр асуудлаа шийдье гэж хэлсэн. Мэдээлэл өгөөгүй.

Хоёрдугаарт, энэ хуулийн төслүүд дээр та өөрөө эсрэгээрээ би дэмжихгүй гэдэг байдлаар өгсөн. Тэгээд би бас хуулийн төслөө дахиад Засгийн газрын өгч байгаа саналуудыг харгалзаад бас сайжруулах гээд л ажиллаж байгаа юм.

Би сүүлдээ бүр цагдаагийнхныг бичиг явуулаад албан ёсоор авъя аа гэсэн. Би ийм мэдээлэл авч чадахгүй байгаа шүү. Энийг Хууль зүйн сайдаараа дамжуулж өгнө гээд байгаад байгаа. Ерөөсөө л энэ. Энэ мэдээллүүдийг бид нар дандаа хэвлэлээс авч байгаа. Ийм ийм том тоо, тоонууд явж байгаа юм байна. Тэгээд би хувь өмнө нь хууль боловсруулж байсан надад датанууд, мэдээллүүд байгаа. Энэ чинь цаг үеэ бодоод өөрчлөгдөөд байгаа байхгүй юу. Яг сүүлийн үеийн эцсийн мэдээлэл авъя гэхээр.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Ганбат гишүүний микрофоныг өгье. Энэнээс өмнө би зүйл өөрийнхөө гишүүдэд, Байнгын хорооныхоо гишүүдэд хэлчихмээр байна. Түрүүн энэ Дамдинням гишүүн ээ асуудал нь ийм шүү. Энэ өндөр олны анхаарал татчихсан байгаа энэ асуудлыг сүүлд тавьдгийн чинь учир одоо энийг чинь ингээд хэлэлцчихсэний дараа манай гишүүд хэрэв гараад явчихвал энэ Үндсэн хуулийн цэцийн асуудал чинь хугацаатай байхгүй юу. 7 хоног. Өнөөдөр сүүлийн хугацаа нь байгаа учраас л бид нар 1 дэх өдөр энэ хурлыг чинь тавьчихаад яваад байгаа юм.

Тэгээд энэ асуудлынхаа дараа гишүүдийн ирц хүрэхгүй болчихвол санал дээр асуудал гарч магадгүй гээд л би энэ асуудлыг чинь ар руу нь тавиад байгаа ухаантай байхгүй юу.

Ганбат гишүүний микрофоныг өгье.

Д.Ганбат: Улсын Их Хурал, манай Хууль зүй байнгын хороо, манай Хууль зүйн байнгын хороо ч гайгүй л байгаа л даа. Энэ Улсын Их Хурал чинь юу болчихсон юм бэ? Түрүүний долоо хоногт чуулган эхэлсэн. Тэрний дараа 4 дэх, 5 дахь өдөр чуулган хуралдах ёстой шүү дээ. Байхгүй. Яагаад хуралддаггүй юм? Өчнөөн л асуудал байна. Нэгдүгээрт тэр. Энэ дээр бид нар анхаармаар юм шиг байна лээ.

Би, энэ юу болоод байна? Алтангэрэл маань ямар болгочхов оо энэ дээр? Хуулийг сайн мэддэг ийм хуульч, урдаа барьдаг хэдэн хуульч нарын л нэг л дээ. Гэтэл ямар бүдүүлэг алдаа хийж байна аа? Яагаад ийм болчихов? Тэр прокурорын зөвшөөрлөө хэзээ авсан юм бэ? Тэр албан ажлынхаа шугамаар мэдсэн энэ юмаа ингээд яагаад зарлаад байна? Миний ойлгож байгаагаар тэр Хүний эрхийн хороо бил үү тэрнийх нь юм хум нь бас л дүгнэлт энэ тэр нь гарсан л гэж байна. Би олж хараагүй л байна л даа. Тэр болохгүй л гэж гарсан юм шиг байна. Хэнийг ч гэм

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

бурууг нь шүүхээр нотлоогүй байхад ийм юм үүсчихлээ. Юу үүссэн гэхээр нөгөө л ард түмэн л буруутай тээ. Архи уудаг байсан, гэртээ хүн цуглуулдаг байсан, эсвэл тэгдэг ингэдэг байсан гээд. Тийм учраас буруутай гээд ингээд тийм юм явж байх юм, явуулах юм. Яагаад ингэдэг юм бэ? Энэ чинь хуульд нийцэхгүй шүү дээ. Ийм алдаа гарч байгаад үнэхээр харамсаж байна.

Тэгээд энэ манай иргэд маань ч гэсэн энэ 30 жилд ямар ч байсан энэ хуулийг, хууль дээдлэх, ардчилал энэ бүх юмыг мэддэг болчихсон байна. Зүй ёсны шаардлагуудыг тавьж байна. Энэ ч зөв. Сүүлийн үед бид нар аягүй ухарчихсан байна шүү дээ. Хүний эрхийн талаар, хэвлэн нийтлэх, Үндсэн хуулийн зүйл, заалт хэрэгжих энэ бүх юм байхгүй ухарчихсан. Энэ дээр та юу гэж бодож байна вэ гэх мэтчилний ийм асуултууд байна. Одоо цаашдаа яах юм тэгээд? Хариултаа авчхаад.

Д.Цогтбаатар: Алтангэрэл гишүүн, сайдын микрофоныг өгье.

О.Алтангэрэл: Би тайлбарлая. Тэгээд ийм биеэ өмөөрч байгаа юм шиг болчих гээд байх юм. Яг үндсэндээ би 2 мэдээлэл хийсэн. Энэ noogoo.mn нэгдлээс ажиллаж байгаа залуучууд дунд 9.3 тэрбум төгрөг дансаар эргэлдсэн ийм мэдээлэл байна гэж хэлсэн. Би хариуцлагатайгаар хэлж байгаа шүү. Бусдыг амиа хорлоход гэмт хэрэг шалгагдаж байгаа хүн байна гэсэн. Мөн ингээд худал мэдээлэл тараах, хувь хүний нууц талд ийм гэмт хэргүүд байна л гэж хэлсэн энэ. Энэ өөрөө та Улсын Их Хурлын гишүүн асуудалтай танилцах эрхтэй, бичиг цаасыг нь хараарай. Яг прокурорын байгууллагаас өгсөн мэдээллийн хүрээнд байгаа. Харин яагаад энэ мэдээллийг өгөх болсон бэ гэхлээр цагдаад хүмүүс эргэлзсэн байхгүй юу. Худлаа юм зохиогоод байгаа юм биш үү, юун тоглоом гээд. Үгүй тэгээд цаг хугацааны эрхээр энэ нь нотлогдлоо л доо. Хүмүүс нь ч өөрсдөө гараад үнэн тэгэхдээ гэдэг дараагийн зүйлийг л ярьж эхэллээ. Хүний эрхтэй холбоотой асуудлууд, зовлонтой асуудлууд байна. Бид шийдэх ёстой асуудлууд байна. Одоо яг өнөөдрийн Хууль зүйн байнгын хорооны хурлаар хүний эрхийн багц хуулиуд, төслүүдийг би танилцуулах гээд сууж байгаа. Эрүүгийн процессын хуулийн өөрчлөлтийг танилцуулах гээд сууж байгаа.

Тухайлах юм бол өнөөдөр хэвлэн нийтлэх эрх чөлөө гэдэгт юуг хамааруулах юм бэ гэдэг асуудал нэлээн чухал асуудал байгаа. Монгол Улсын эрүүгийн хууль сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаанд саад учруулах гэдэг гэмт хэрэг бий. Өнөөдөр үүгээр шийтгэгдсэн 1 ч хүн байхгүй. Яагаад гэвэл сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаа гэж юу юм бэ гэдэг нь тодорхойлсон тодорхойлолт байхгүй. Ийм ч учраас Засгийн газар Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийг өргөн барьчхаад байгаа.

Цаашдаа энэ олон хуулиар хязгаарлагдаж байгаа эрх, эрхүүдээр бид нар ярих ёстой. Саяын асуудлаас бас дахиад бид нар авч үлдэх ёстой сургамж нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийнхаа процессыг илүү дэлгэрэнгүй болгоё, хойшлуулшгүй ажиллагаа гэж зүйлдээ ингээд хэн нэг нь үзэмжээрээ тайлбарладаг биш, хэн нэг нь ийм ийм байх ёстой гэж ярьдаг тэр нь хууль дээрээ бичигдээгүй биш, энэ процессыг боловсронгуй болгоё гэдэг энэ өөрчлөлтүүд удаа дараалан хийгдээд явна. Их Хурлаар энэ намрын чуулганаар бид нар Жагсаал, цуглааны журмын тухай, Хэвлэлийн эрх чөлөөний тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд хүний эрхийн чиглэлээр авах арга хэмжээний тухай, хүний эрхийн

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

бусад багц хуулиуд гэсэн ийм хуулиуд өргөн барьчихсан. Манай Хууль зүйн байнгын хороогоор ороод хэлэлцэгдээд явна гэдэг хариултыг хэлье.

Нэг асуудал байгаа тэр ард түмэн буруутай гэж. Яг энэ хандлагаас болоод л та бүхэн санаж байвал намайг ажил авсны дараахан нэг асуудал гараад, хүүхэдтэй холбоотой асуудал гараад би цагдаагийн байгууллагад хатуу үүрэг өгсөн. Хохирогчтой холбоотой хувийн мэдээллийг дахиж ерөөсөө ярихгүй, задлахгүй гэж. Дараа нь сая бас золгүй явдалтай холбоотой асуудал гарсан. Энэ мэдээллийг хэн олсон байна, заавал шалгах ёстой гээд өнөөдөр 2 иргэнд бас эрүүгийн хэрэг үүсгээд, энэ хохирогчдын хувийн мэдээллийг задалсан гэдэг асуудлыг шалгаад явж байгаа. Тэгэхлээр хүнийг ямар хэрэгт сэжиглэн шалгаж байгаа тухай ярих нь өөрөө буруутгал биш ээ. Энэ аль ч тохиолдолд мэдэгдэнэ. Энэ хүнийг ийм хэргээр сэжиглэж байгаа юм байна гэдэг асуудал. Тэр дотроос ямар үйл баримтыг олон нийтэд хэлж болох юм бэ гэдэг нь эрүүгийн.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Ганбат гишүүний микрофоныг өгье.

Д.Ганбат: Тодорхой хариулт, асуулт тэгээд дараа нь аяндаа тодорхой болно биз дээ. Хэн нь ямар байгаа, яаж байгаа, юу ярьж байгаа гэдгийг нь тэгээд л бүгд л хараад сууж байгаа юм чинь тодорхой болчих байх.

Нөгөө талаар бас нэг юм тодруулах хэрэгтэй. Яагаад одоо Монголын аж ахуйн нэгжээс Улсын Их Хурлын сонгуульд дэвшсэн хүн хандив хуулийн хүрээнд авчихсан байхад ямар санал өгөхийг нь харъя энэ тэр гэсэн тийм юм яриад байгаа юм бэ? Тэр сэтгүүлчид харагч юм уу, би өөрөө харсан. Тэр хандив авсан хүний тоонд манай Хууль зүйн байнгын хорооны дарга ч гэсэн багтаж байх шиг байна. Ямар хууль зөрччихсөн юм, яг яачихсан юм, юу нь буруу юм?

Д.Цогтбаатар: Алтангэрэл сайдын микрофоныг өгье.

О.Алтангэрэл: Энэ дээр ямар ч хууль зөрчсөн асуудал гэж хэлээгүй. Энэ бол Сонгуулийн хуулийн дагуу ямар ч аж ахуйн нэгж хуулийн дагуу хүнд хандив өгөх эрхтэй. Та анзаарсан бол сэтгүүлчийн асуулт та энэ гишүүдийг зөв шийдвэр гаргана гэж итгэж байна уу, эд нар чинь эсрэг тийшээгээ шийдэх юм биш үү гэсэн утгатай асуудал байсан. Улсын Их Хурлын гишүүд тангараг өргөдөг, Үндсэн хуульдаа тангараг өргөсөн тэр үүргийнхээ дагуу саналаа өгнө гэж найдаж байна гэсэн ийм л зүйл хэлсэн. Тэрнээс биш ямар саналыг нь өгөхийг, тэр тэр өгсөн гэдэг ийм юм яриагүй. Ийм юм ярих нь ч өөрөө утгагүй.

Өнөөдөр гарч байгаа шийдвэр болгоны төлөө тэр тэр компаниас ийм хандив авсан гээд ингээд яваад байх юм бол Улсын Их Хурлын гишүүд бүгдээрээ хандив авсан байгаа байх. Тэр дунд барилгын компанид хандив өгсөн бол барилгын асуудал ярьж болохгүй гэдэг зүйл байхгүй л байх. Тэгэхээр та буруу ойлгосон байна. Тийм хариулт байгаагүй шүү.

Д.Цогтбаатар: 1 удаа. 2 болно шүү дээ. 1 биш ээ. Та сая 2 тодруулсан уу? Тийм одоо харин болно болно. Тийм, микрофоныг чинь өгье гэж байна.

Д.Ганбат: Үгүй за, үгийг чинь бүгдээрээ л улс даяар сонссон л доо. Ер нь ямар ч албан тушаалтан хариуцлагатай л байх хэрэгтэй шүү дээ. Тийм тийм

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

компани, тийм тэр ямар хандив, ямар гишүүдэд өгснийг нь хэлээгүй л байна лээ л дээ. Гэхдээ тэр компани гэж заасан байхгүй юу. Нэр усаар нь хэлж. Би хэлэхгүй байгаа биз. Ингэж болдог юм уу? Бид нар чинь яаж аж ахуйн нэгжүүдээ дэмжих вэ, яаж хувь хүмүүсийг дэмжих вэ, Монгол Улсынхаа иргэдийг дэмжих вэ гээд ингээд байж байхад татвараа төлдөг, хуулийнхаа дагуу ажлаа хийдэг тийм юманд ийм компаниудаа бид нар адалж болохгүй ээ. Тэд нар чинь л ажлын байр бий болгож, тэд нар чинь л энэ улс орныг авч явж байгаагаас биш энэ албан тушаалтнууд авч явдаг юм гэж байхгүй шүү дээ. Энийг бас зөв ойлгох хэрэгтэй. Энийг та одоо.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Эрдэнэболд гишүүний микрофоныг өгье.

С.Эрдэнэболд: Сайнзориг гишүүний хэлээд байгаа зүйл дээр бас тайлбар хийхгүй бол олон нийт буруу ойлголт авах гээд байна л даа. Дуулиан шуугиантай хэрэг ч юм уу, тодорхой асуудал дээр цагдаагийн байгууллагаас дуудаж уулзаад тайлбар, тодруулга аваад байгаа зүйл байхгүй. Хүний эрхийн дэд хорооны даргаар сонгогдсоноос хойш 10 сарын 22-ноос хойш 3 удаа цагдаагийн албан хаагчидтай уулзсан. Нэг нь болохлоороо цагдаагийн удирдах ажилтны арга хэмжээнд оролцооч гээд урилга авчирч 2 хүн ирсэн. Тэгж өрөөндөө уулзсан.

Хоёр дахь нь болохлоороо Хүний эрхийн дэд хороон дээр энэ замын цагдааг, зам дээр хүүхдүүд осол, гэмтэлд өртөж байна. Ялангуяа гарц дээр дайруулж мөргөж байна. Энэ талаарх статистик судалгааг албан бичгээр хүссэний дагуу өрөөндөө уулзаж, цаашлаад Улаанбаатар хотод гарч байгаа 170 гаран гарцтай, зохицуулалттай болон зохицуулалтгүй гэрлэн дохио дээр хүүхдүүд яаж эрсдээд байгаа, үүнийг бууруулахын тулд ямар арга хэмжээ хийх вэ гэдэг асуудлаар уулзсан. Мөн Замын цагдаагийн газар дээр очиж энэ уулзалтуудыг хийгээд одоо дүгнэлт, тайлан нь гарчихсан байж байна.

Гуравдугаарт нь болох юм бол сая өнгөрсөн долоо хоногт энэ СЭМҮТ дээр донтолтын өвчин дотроо энэ цахим мөрийтэй тоглоомоос үүдсэн донтолтыг эмчлэх тухай энэ асуудлаар бид нар энэ долоо хоногтоо СЭМҮТ дээр очих гээд байж байгаа юм. Энэ асуудлаар бас Цагдаагийн ерөнхий газрын холбогдох албан тушаалтантай уулзаж, ер нь энэ донтолтын төрөл, түвшин ямар байгаа, яагаад гэхлээр энд бидэнд статистик нэгдсэн мэдээлэл олдохгүй байсан учраас эх сурвалжуудтай уулзсан ийм уулзалт болсон.

Түүнээс биш яг ингээд нийгэмд дуулиан шуугиан болоод байгаа хэргийн асуудлаар тодруулга авах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ч гэдэг юм уу, процессын үйл ажиллагаанд нөлөөлөх ямар нэгэн уулзалт хийгээгүй. Эдгээр уулзалтуудаа Хууль зүйн байнгын хорооны даргатай тогтмол харилцаж, ярилцаж байж бас энэ чинь ганцаарчилсан биш таны хэлж байгаагаар тийм улс төржүүлсэн зүйл огт байхгүй. Ийм уулзалтууд болсон юм шүү. Тэрийг бас та зөв мэдээлэлтэй байгаасай гэж хүсэж байна.

Байнгын хорооны, дэд хорооны чат дээр жишээлбэл зарим гишүүдийн зүгээс ийм ийм уулзалт хийх үү эд нар гэж асуусан асуултууд байгаа. Тэр дагууд нь шууд зохион байгуулаад, дуудаж уулзаад болсон юм одоохондоо болоогүй байна. Ямар нэгэн байдлаар хувийн харьцаа гэхээс илүүтэйгээр дандаа албан бичгээр харьцаанууд явж байгаа гэдгийг танд хариуцлагатайгаар хэлье.

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

Хууль зүйн сайдаас нь 2 зүйл тодруулъя. Нэгдүгээрт нь болохлоороо энэ анх энэ 3 сарын 18-ны өглөө мэдээлэл хийхэд үндэсний эв нэгдэлд халтай гэдэг ийм хуулийн зүйл, заалт дурдсан шүү дээ тийм ээ. Энэнээс хойшоогоо бол таны өнөөдрийн бас дурдаж хэлж байгаачлан хүнийг амиа хорлоход нөлөөлсөн ч гэдэг юм уу, дээрээс нь цахим мөрийтэй тоглоомтой холбоотой эд нар гээд ингээд олон олон асуудлууд ярилаа. Өнөөдрийн байдлаар яг энэ хэрэг дээр хэчнээн хуулийн зүйл, заалтаар буруутгасан мэдээлэл гарчхав? Яагаад гэхлээр анхнаасаа 1 зүйл, заалтаар явсан ч тухайлбал, тэр хувь хүнтэй холбоотой, тодорхой мөнгөн дүнтэй холбоотой асуудал гээд тэр хувь хүнийх нь асуудлыг салгаагүйгээр шууд энэ байгууллага дээр нь ингээд гүйцэтгэх ажиллагаа явчихсан учраас хойшлуулшгүй гээд ингээд шөнө явчихсан учраас нэг.

Хоёрдугаарт, тэр өглөөний 5 цаг хүртэл.../минут дуусав./

Д.Цогтбаатар: 1 минутыг нь нэмээд өгье Эрдэнэболд гишүүнд.

С.Эрдэнэболд: Тийм байцаасан, байцаагаагүй хоёрын хооронд болчихлоо. Энэ чинь эрүүдэн шүүх хэлбэр юм биш үү эд нар гээд яг ийм асуудал дээр иргэд бухимдсан. Хоёр асуудал байгаа юм л даа. Нэг нь болохлоороо тэр олон янзын Цагдаагийн ерөнхий газар болон Хууль зүйн яамнаас гарч байгаа мэдээллүүд нь олон янзын санкц бүхий эшлэл гарсан байхгүй юу. 5, 6 гарчихсан байх. Энэ дээр хүмүүс ямар нэгэн байдлаар яллах гээд байгаа юм биш үү гэсэн ийм хардалт үүсчихсэн байгаад байгаа юм.

Хоёрдугаарт нь гэх юм бол орой 10 цагаас ажиллагаа эхлээд өглөөний 5 цаг хүртэл ийм юм болчихсон гэдэг. Тэгэхээр өөрөөр хэлбэл зүйл, заалтууд нь аягүй олон удаа холигдож, солигдсон учраас хүмүүс их тээнэгэлзсэн, эргэлзсэн зүйл байгаад байгаа юм.

Гуравдугаарт нь болохлоороо шууд энийг ямар нэгэн аж ахуйн нэгж, компанитай холбоод маргааш, нөгөөдрөөс нь дамжуулаад шууд ийм хэвлэлийн Пи Ар явчихсан шүү дээ. Шууд буруутгагдаад Эм Си Эс эд нартай холбоод ингээд явчихсан байгаа. Энэ дээр ямар нэгэн сэжигтэй зүйл байна гэж иргэд үзсэн байхгүй юу. Тэгэхээр асуулт нь болохлоороо нийт хэдэн зүйлчлэл байгаа юм бэ? Хоёрдугаарт нь та Хууль зүй, дотоод хэргийн сайдын хувьд хэчнээн хүний эрхийг хангах ямар ямар алхмуудыг.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Алтангэрэл сайдын микрофоныг өгье.

О.Алтангэрэл: Бас дараа нь цагдаагийн байгууллагын зүгээс нэмээд өгчихнө биз дээ.

Д.Цогтбаатар: Энд юу яаж байна, яг энэ 2 ажлын хэсгийн маань хүмүүс хүрээд ирчихсэнийг мэдэгдье. Нарантуяа гишүүн Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Ууганбаатар Хүний эрхийн Үндэсний Комиссын Гомдол, хяналт шалгалтын хэлтсийн дарга бас нэмж ирсэн байна.

Алтангэрэл сайдын микрофоныг шинээр тооцоод өгчихье.

О.Алтангэрэл: Яг энэ ташаа, буруу ойлголт яваад байгаа юм. Энэ олон зүйл, ангиар ингээд ямар юм наах гээд байна гэдэг. Тэгээд энэ дотор чинь янз

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

янзын зүйл ангиар хэрэг бүртгэлтийн хэрэг болон гомдлоор шалгаж байгаа зүйлүүд байгаад байгаа байхгүй юу. Одоо жишээлбэл тэр цахим мөрийтэй тоглоом гээд шалгагдаж байгаа хүн байна. Бусдыг амиа хорлохоор шалгагдаж байгаа хүн байна. Хувь хүний нууц задруулах энэ гэмт хэргийн улмаас шалгагдаж байгаа, гомдлоор шалгагдаж байгаа ч гэдэг юм уу ингээд 3, 4 төрлийн зүйлээр шалгагдаж байгаа өөр өөр субъектүүд энд яригдаад байгаа юм.

Тэгэхээр ингээд хувираад байна нэг юмнаас өөр болоод байна, нэг нь өөрчлөгдөөд байна гэдэг ч юм уу ингээд явж байгаа байхгүй юу. Тэгээд энэ хооронд энэ ойлголтын зөрүү үүсчхээд ингээд яваад байна уу л гэж харж байгаа.

Ер нь цаашдаа бид нар энэ цагдаагийн байгууллагаас болон би бол яг хамгийн түрүүнд сонсоод л цагдаагийн байгууллагыг та нар олон нийтэд мэдээлэл өг гээд л ингээд л цагдаагийн байгууллага мэдээлэл өгөөд эхэлсэн. Тэгээд энэ болгондоо ингээд мэдээлэл өгч байсан зүйлүүд дотор нь нэмэгдээд байна, өөрчлөгдөөд байна гэсэн юм байх боловч агуулгаараа үзвэл өнөөдөр ярьсан эдгээр зүйлүүд нь бүгдээрээ шалгагдаад явж байгаа гэсэн ийм байгаа юм.

Би яагаад жишээлбэл энийг яриад байгаа вэ гэхлээр нэгдүгээрт прокурорын зөвшөөрлийн хүрээнд ярилаа.

Хоёрдугаарт энэ ажиллагаануудаа, энэ ажил явагдаж байгаа ажиллагаанууд чинь дандаа прокурорын хяналтад явагдах ёстой ажиллагаанууд. Прокуророос энд байгаад ирчихсэн явж байсан. Тайлбар өгвөл их сайн байна. Тийм учраас ийм ажиллагаа явагдаж байна гэж хэлээд байгаа юм.

Харин дахин дахин байр сууриа илэрхийлээд байгаа юм нь эдгээр зүйлүүд хэвлэн нийтлэх эрх чөлөө рүү халдаж болохгүй гэдэг дээр зарчмын 100 хувь санал нэг байгаа юм. Ийм учраас цаашдаа энэ Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль дээр тусгагдсан сэтгүүл зүйн мэргэжлийн үйл ажиллагаа гэсэн энэ зарчмыг дэмжиж өгөөч ээ. Дахиад цаашаагаа энэ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд орж байгаа энэ процессыг илүү нарийн журамлаж байгаа, хүний эрхийг хангах чиглэлээр орж байгаа өнөөдөр хэлэлцэх асуудлуудыг дэмжиж өгөөч ээ. Энэ бол Засгийн газраас хүний эрхийн чиглэлээр баримталж байгаа бодлого юм л гэж хариулах байна. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Цагдаагаа нэмээд, Эрдэнэболд гишүүнд микрофон өгье.

С.Эрдэнэболд: Хууль зүйн сайд аа энэ их хамгийн ноцтой зүйл нь яах вэ тэрийг ойлгож байна. Эхэндээ бол энэ чинь яг хувь хүн гэхээс илүүтэйгээр шууд байгууллага гэдэг утгаар явчихсан шүү дээ. Тэгэхээр одоо 19-ийн, Эрүүгийн хуулийн 19.9 буюу 19 тээ, үндэсний эв нэгдлийн эсрэг гэж аягүй ноцтой эхэлсэн байхгүй юу. Тэгэнгүүт ингээд л сүр сар тас гээд л. Яг ядаж байхад тэр өдөр чинь цэргийн баярын өдөр, Монгол цэргийн өдөр болж байсан. 19.9 дээр хүмүүсийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, шашны номлол, үзэл бодлоор дайсагнуулах, эвдрүүлэх, салан тусгаарлахыг ухуулсан, уриалсан, ялгаварлан гадуурхсан, хүчирхийлсэн, эрхийг нь хязгаарласан, давуу байдал тогтоосон үйлдлийг зохион байгуулсан бол 5 жилээс 12 жил хүртэл хугацаагаар хорих ял, энэ гэмт хэргийг зохион байгуулттай гэмт бүлэг үйлдсэн бол 12 жилээс 20 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гээд явчихсан.

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

Одоо энэ 18-наас хойш өнөөдөр 24 гээд 6,7 хоногийн хугацаанд процессыг анхааралтай ажиглаж байхад энэ зүйл, заалтыг анх дурдаж энэ үйл явдал болж байсан нь энэ зүйл, заалт нь сарничихсан юм шиг харагдаад байгаа юм.

Д.Цогтбаатар: Алтангэрэл сайдын микрофоныг өгье.

О.Алтангэрэл: Тэгээд ерөөсөө яг анх гарч ирсэн мэдээлэл дээрээс миний хамгийн их ач холбогдол өгөөд яагаад би жишээлбэл энэ талаар та нар үйл ажиллагаагаа танилцуул гээд Цагдаагийн байгууллагад хэлсэн бэ гэхлээр, тэгээд олон нийтэд мэдээлэл өг гэж цагдаагийн байгууллагад хэлсэн бэ гэхлээр энэ өөрөө цагдаагийн байгууллагын харьяалал нь шалгадаггүй дээрээс нь ийм зүйл ангитай асуудал анх яригдаж эхэлсэн. Надад Хууль зүй, дотоод хэргийн сайдын хувьд өнөөдрийг хүртэл явуулж байгаа үйл ажиллагааны талаар энэхүү гэмт хэрэгтэй холбогдуулсан ямар нэг танилцуулга, ямар нэг зүйл байхгүй, мэдээлэл байхгүй. Хууль бус мөрийтэй тоглоомтой холбоотой зүйл байгаа гэдэг мэдээлэл өгсөн. Тэгвэл прокуророосоо зөвшөөрөл ав гэсэн. Прокурор зөвшөөрөл өгсөн, гүйлгээнүүд байсан. Энийг мэдээлсэн. Ийм л үйл явц болсон. Тэгэхээр хариуцлагатай хэлэхэд ийм зүйл ангиар шалгаж байгаа гэсэн ямар ч мэдээлэл Хууль зүй, дотоод хэргийн сайдад өнөөдрийг хүртэл.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Та 2 удаа би түрүүн сунгачихсан шүү дээ. Түрүүн би шууд автомат сунгаад өгчихсөн байхгүй юу. Өөрийнх чинь дуусчихсан юм. Үгүй харин уг нь 2 болчихсон. Танд өгье.

С.Эрдэнэболд: Хууль зүйн сайд аа тэгэхээр логикийн хувьд зөрчилтэй юм байгаад байгаа юм л даа. Таны саяын хэлж байгаа 19 болохлоор тагнуултай хамааралтай зүйл байгаад байна шүү дээ. Хэрвээ тийм байсан юм бол анхнаасаа энэ чинь Тагнуулын газар мэдээлэл өгөх ёстой шүү дээ.

Гэтэл яагаад тагнуултай холбоотой энэ асуудлаар Цагдаагийн ерөнхий газар мэдээлэл өгөөд, одоо тэр дундаасаа ингээд замхраад алга болчихов оо? Тэгэхээр тэр бол юу гэдэг юм ийм Пи Ар-ын шинжтэй юм болоод өнгөрчхөв үү гэсэн хардалт байгаад байгаа байхгүй юу даа. Бусдуудыг нь явцын дундаа энэ Хүний эрхийн Үндэсний Комисс болон бусад таны хэлж байгаа тайлбараас гаргалгаануудыг нь харж байна л даа. Тэр яагаад тэр зүйл, заалт ийм тодорхойгүй, танд мэдээлэл очоогүй нь ойлгомжтой. Та хэргийг гардан шалгаж байгаа хүн бас биш шүү дээ. Тэрийг бол ойлгож байна.

Гэхдээ Цагдаагийн ерөнхий газар яагаад одоо ингээд сарничихсан зүйл, заалтыг тэнд эшилчхэв ээ? Энэ чинь эргээд маш том эсрэгээрээ юу гэдэг юм хүмүүсийн хэвлэлийн эрх чөлөөнд халдаж байгаа ч гэдэг юм уу энэ асуудлыг хардах эрхийг нь суурь болчихсон байхгүй юу даа. Тэрийг л тодруулаад байгаа юм.

Д.Цогтбаатар: Алтангэрэл сайдын микрофоныг өгье.

Гэхдээ гишүүд ээ яана шүү хэдүүлээ бас хурлынхаа дэгийг барьж ажиллана шүү. Алтангэрэл сайдын микрофоныг нь өгье.

О.Алтангэрэл: Тэгээд яагаад мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна гэдэг асуулт та өөрөө бас хуульч хүн. Энэ дээр би түрүүн анхны танилцуулгадаа

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

дурдсан. Цахим мөрийтэй тоглоом буюу энэ сайтад ажилладаг иргэний хэрэг 2022 оноос эхлэн энэ 9.3 тэрбум төгрөг гэж ингэж бүлэглэлтэй холбоотой, одоо бүр бүлэг хэрэг болчихсон шүү дээ. Зарим хүмүүс нь цагдан хоригдсон. Зарим нь энэ нь үнэн гээд өчигдөр олон нийтийн сүлжээгээр хэлчихнэ лээ. Энэ хэрэг шалгагдаж байсан байна. Шалгагдаж байсан байна. Бусдыг амиа хорлоход хүргэх гэдэг хэрэг бас дахиад энэ дундах хүмүүсийн 1 хүнтэй нь холбоотойгоор 2024 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр ЧД хэрэг бүртгэлтийн хэрэг үүсгэж шалгаж байсан байна. Тэгээд энэ хүрээндээ л гэж хэлж байгаа юм. Тэрнээс биш яг таны хэлдэг шиг нэг юман дээр үүсгээд, дахиад өөр тийшээгээ өөр үйл баримт руу үсрээд, тэндээс олсон зүйл дээрээ ингээд явчихсан бол энэ өөрөө зөрчвөл болно. Энд байгаа мэд.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Уянгахишиг гишүүний микрофоныг өгье.

Г.Уянгахишиг: Энэ дээр хэдүүлээ яг гол яригдаад байгаа, бас ойлголцох гээд байгаа, хүсээд байгаа юм бол ерөөсөө энэ процессын явцад хүний эрх зөрчигдсөн үү, үгүй юү гэдэг асуудал байгаад байгаа тийм ээ. Цахим мөрийтэй тоглоом тоглосон ч гэдэг юм уу, тэрэнтэй холбоотой асуудал цагдаагаар шалгагдаад явах энэ бол тусдаа асуудал. Тэрэнтэй холбоотой бол бид нар энд авч хэлэлцээд байх шаардлага байхгүй. Процессын дагуу явах ёстой.

Гол нь бид нарын асуугаад байгаа, тодруулах гээд байгаа зүйл бол энэ 3 сарын 17-нд яг ямар гомдлын дагуу, ямар үндэслэлээр тэр хойшлуулшгүй ажиллагааг явуулсан бэ, тэр шөнийн цагаар байцаалт явуулах үндэслэл байсан уу гэдэг энэ асуудал дээр л тавигдаад байгаа юм.

Нөгөө талаасаа анхнаасаа жишээлбэл, сая ингээд яригдаж байхад, тайлбар өгөгдөж байх явцад болохоор өмнө нь байсан хэргийг гүйцэтгэх ажиллагаа явуулсан юм шиг, эсвэл шал өөр үндэслэлтэй мэдээллийг шалгахын тулд тэр өөр үндэслэлээр очиж хойшлуулшгүй ажиллагаа явуулсан мэт ийм тайлбарууд сонсогдоод байна л даа. Энэ чинь өөрөө жишээлэх юм бол АТГ-аас мөнгө угаахын хэргээр банкны хуулга авдаг, тэр дээрээ татварын хэрэг оногдуулдагтай яг адилхан сонсогдоод байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ тухайн үед Ноорог гэдэг хэвлэл, мэдээллийн хэрэгслийн байгууллагын хувьд байгууллагын эд хөрөнгийг битүүмжилсэн, тухайн байгууллагад ажилладаг хүмүүсийг бүгдийг нь хойшлуулшгүй ажиллагаа гэдгээр байцаасан энэ асуудлын хамгийн гол мэдмээр байгаа юм юу вэ гэхээр Хүний эрхийн Комиссоос ч гэсэн асуумаар байна. Яг энэ процессын үйл ажиллагаанд хүний эрх зөрчигдсөн үү? Нэгдүгээр асуулт.

Хоёрдугаар асуулт нь анхны шалгалт явуулах үндэслэл болсон тэр зүйл анги, зүйлчлэл, үндэслэл чинь нотлогдсон юм уу, нотлогдоогүй юм уу? Тэр тал дээрээ ажиллагаа үргэлжилж байгаа юм уу, эсвэл энэ чинь өөрөө цахим мөрийтэй тоглоом гээд шилжээд өөр ямар нэгэн хэрэг тохох хэрэгтэй ч гэдэг юм уу, хэргийн шалгалт болоод хувь хүний асуудал болоод явчихсан юм уу?

Гуравдугаарх нь болохоороо энэ тухайн хэвлэл, мэдээллийн хэрэгслийн өөрийнх нь бүх контент мэдээллүүд, энэ бүх юмыг агуулж байсан тоног төхөөрөмж, компьютер, гар утас бүх юмыг хурааж авсан байгаа. Тэгэхээр энэ хурааж авсан зүйлсээ буцааж өгсөн үү? Дээрээс нь хэрвээ энэ тухайн үед хэвлэл, мэдээллийн

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

хэрэгслээр яаралтай түгээх шаардлагатай байсан мэдээлэл байгаад тэр хэвлэл, мэдээллийн байгууллагын үйл ажиллагаанд садаа учруулчихсан бол, дээрээс нь энэ нь хэвлэл, мэдээллийн байгууллага гэхээс илүүтэйгээр бас бизнесийн байгууллага байсан байлаа гээд тэр тухайн байгууллагын үйл ажиллагаанд садаа учруулчихсан байсан бол тэгэхээр энэ асуудлууд өнөөдөр тодорхой болчихсон байх ёстой. Тэр процессын асуудлууд тэр хэрэг шийдэгдэж байна уу, яаж энэ процессын тусдаа асуудал тийм үү? Энэ асуудал өдийд шийдэгдчихсэн байх ёстой. Тэгэхээр энэ 3 асуултад ер нь хариулт авмаар байна.

Д.Цогтбаатар: Болно болно. Эхлээд Комиссын дарга тэгвэл. Нарантуяа гишүүний микрофон өгье 4 дүгээр микрофон.

Г.Нарантуяа: Тэгэхээр Хууль зүйн байнгын хорооноос энэ poorog.mn сайттай холбоотой үүссэн асуудалд анхаарал хандуулж, энэ талаар Засгийн газрын байр суурийг сонсохдоо Хүний эрхийн Үндэсний Комиссыг оролцуулж байгаад бас талархал илэрхийлье.

Тэгэхээр Хүний эрхийн Үндэсний Комисс 3 асуудлаар дүгнэлт гаргаад өнөө өглөө танилцуулсан байгаа. Noorog.mn сайт, poorog creative юу билээ studio компанийн 8 ажилтантай холбогдох энэ тохиолдол дээр 8 хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийг зөрчсөн гэсэн дүгнэлтийг Комисс цугларсан баримтад үндэслэж гаргасан.

Ямар баримтууд байна вэ. Цагдаагийн байгууллагаас Хүний эрхийн Үндэсний Комисст өгсөн мэдээллээр бол Тогосоо Ти Жи гэх иргэн Н.О-ын хөтөлдөг цахим хуудаснаас ирсэн мэдээллийн дагуу бол хойшлуулшгүй ажиллагаа явуулсан. Гэхдээ Хүний эрхийн Үндэсний Комисс иргэн О.У, түүний өмгөөлөгч Б.Н-ий гаргаж өгсөн баримтаар бол 25 оны 3 сарын 18-ны өдрийн 4 цаг 55 минутад Эрүүгийн цагдаагийн албаны Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газрын мөрдөгчийн 8686 дугаарын утаснаас Эрүүгийн хуулийн 19.9.1 улс үндэстний эв нэгдэлтэй холбоотой заалтаар баривчлах гээд байна. Зөвшөөрөл хүсэж байгаа юм байна. Тогтоол дээр гарын үсэг зурснаар баривчлах ажиллагаа эхэлнэ гэнэ, яах вэ тэр байна аа гэсэн мессежийг илгээсэн байсан.

Тэгэхээр баривчлах үндэслэл, саатуулах үндэслэл бол анхнаасаа тодорхойгүй байсан. Энэ нь Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх тухай хууль, Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээгээр баталгаажсан ямар хэрэгт сэжиглэгдэж байгаагаа мэдэх, өөрийгөө хамгаалах энэ эрхүүдийг зөрчсөн үйлдэл болсон учраас Хүний эрхийн Үндэсний Комисс бол хүний эрхийн зөрчил гэж дүгнэсэн.

Хоёрдугаарт энэ асуудлаар прокурорын байгууллага Хүний эрхийн Үндэсний Комисст бичгээр тайлбар ирүүлсэн. Тайлбар ирүүлэхдээ мөрдөгч хуульд заасан бүх арга хэмжээг авч, яллах, цагаатгах нөхцөл байдлыг эргэлзэлгүй тогтоож, нотлох баримтыг тал бүрээс нь бүрэн дүүрэн гүйцэд шалгаж, хянасны үндсэн дээр хэргийн бодит байдлыг тогтоох, мөрдөн шалгах ажиллагааг үргэлжлүүлэн явуулж байна гэсэн ийм тайлбар ирүүлсэн боловч ямар үндэслэлээр хойшлуулшгүй ажиллагаа, хууль зөрчөөгүй зөвшөөрөл өгсөн тухайгаа бол тодорхой тайлбарлаагүй байна.

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

Тэгэхээр прокурорын байгууллага бол энэ дээр албан ёсны тайлбарыг маш тодорхой гаргаж өгөх нь энэ асуудлын талаар олон нийт тунгалагт тодорхой ойлголттой болоход маш чухал ач холбогдолтой гэж үзэж байна. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Алтангэрэл сайд нэмэх үү яах вэ? Цагдаагийн тайлбар Батзориг хурандаад микрофон өгье. 8 дугаар микрофон.

Б.Батзориг: Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Батзориг илтгэж байна. Гишүүний асуултад хариулъя.

3 сарын 17-ны өдөр хойшлуулшгүй тохиолдолд хуулиа хэрэгжүүлэх үндэслэл, шалтгаан нь юу вэ гэж асуусан.

Эрүүгийн хэрэг хянан шийдэх тухай хуульд зааснаар мөрдөн шалгах ажиллагааг прокурорын зөвшөөрлөөр явуулах, эс үгүй бол мөрдөгч бие даан явуулах эрх зүйн зохицуулалттай. Цагдаагийн байгууллагын та бүхэнд урьд нь мэдээлэл өгч байсантай, өгч байсны нэгэн адилаар энэ тохиолдол нь мөрдөгч бие даан хойшлуулшгүй тохиолдолд мөрдөн шалгах ажиллагааг шуурхай явуулах шаардлага үүссэн байгаа юм.

Цагдаагийн байгууллагаас мэдээлэл өгч байсан энэ мэдээллүүд нь бол жишээлбэл түрүүн бас зүйлчлэлийн асуудал яригдаж байна л даа. Цагдаагийн байгууллагаас албан ёсоор хэвлэлийн мэдээлэл, прокурорын байгууллагын зөвшөөрлөөр өгөхөөс өмнө ийм үндэсний аюулгүй байдал гэх мэтчилэн мэдээлэл явж байсан. Цагдаагийн байгууллагаас, яг прокурорын байгууллагаас өгсөн зөвшөөрлийн хүрээнд өгөгдсөн мэдээллийн хүрээнд өгсөн гэж өгсөн юм.

Үндсэндээ бол эрүүгийн хэрэг бүртгэлтийн 2 дугаартай хэрэг байгаа. Мөнгө угаахтай холбоотой, зохион байгуулалттай бүлэгтэй холбоотой, цахим, мөрийтэй тоглоомтой холбоотой. Мөн түүнчлэн амиа хорлохтой холбоотой. Сүүлд 17-ноос 18-ны шилжих шөнө бүртгэдэг тэр тохиолдол нь өнөөдрийн байдлаар гомдол, мэдээллийн бүртгэлд бүртгэгдчихсэн. Яг Эрүүгийн хуулийн ийм зүйл, Эрүүгийн хуулийн ийм заалт гээд зүйлчлэх хараахан болоогүй ийм асуудал байж байгаа.

Тэгэхээр тухайн гомдол, мэдээллийн хувьд бол товч утгаар нь мэдээлэл танилцуулагдаж явна. Нөгөөтээгүүр мөрдөн шалгах ажиллагаа бол прокурорын зөвшөөрлөөр тухайн хойшлуулшгүй тохиолдолд 22.4-д зааснаар хүчинтэйд тооцсон байгаа. Мөрдөгч мөрдөн шалгах ажиллагаа.../минут дуусав./

Д.Цогтбаатар: 8 дугаар микрофоныг гүйцээгээд өгье.

Б.Батзориг: Ажиллагаагаа дууссанаас хойш 24 цагийн дотор прокурорт хүчинтэйд тооцуулахаар заасан байдаг. Эрүүгийн хэрэг хянан шийдэх тухай хуулийн 4.1, Эрүүгийн хэрэг хянан шийдэх тухай хуулийн 4.2-т зааснаар хэрэг бүртгэлд, мөрдөн байцаалтад хяналт тавих, шалгалт хийх эрх нь зөвхөн прокурорт байдаг. Зарим байгууллагын шаардлагатай мэдээллийг прокурорын зөвшөөрлөөр л өгдөг. Тэгэхээр хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад хяналт тавих, энэ нь хуулийн хүрээнд нийцэж байна уу, үгүй юү, мөрдөн шалгах ажиллагаа хуулийн хүрээнд явагдсан уу, үгүй юү. Энэ хойшлуулшгүй тохиолдолд хийгдсэн мөрдөн шалгах ажиллагаа нь хууль зүйн хүрээнд явагдсан уу гэдэг бүх асуулт, бүх хариулт бүх

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

мөрдөн шалгах ажиллагааны бүх процесс прокурор дээр эцэслэгдэнэ гэж ойлгогдох юм.

Хурааж авсан зүйлтэй холбоотой асуулт асуугдсан байгаа. Мөрдөгчөөс аливаа хэргийн газрын үзлэг дээр тухайлбал, хулгайн гэмт хэргийн газрын үзлэг дээр тухайн хэрэгтэй холбоотой байж болзошгүй. хөшигч багаж гэдэг юм уу, бээлий гэдэг юм уу холбогдолтой байж болзошгүй гэсэн зүйлийг хурааж авах эрх зүйн зохицуулалт нь хуулиараа өөрт нь байдаг.

Үүний нэгэн адилаар цахимтай холбоотой хэрэг дээр очсон учраас дийлэнх нь цахим төхөөрөмжийг хурааж авсан байгаа. Тухайн хурааж авсан зүйлүүдийг үзлэг хийх, шинжилгээ хийх, шалгах процессын ажиллагаанууд хийгдэж байгаа. Энэ цахим төхөөрөмжтэй холбоотой энэ ажиллагаа бол тийм богино хугацаанд хийхэд хүндрэлтэй асуудал байдаг юм байна.

Өнөөдөр цагдаагийн байгууллагаас бас прокурорын зөвшөөрлийн хэмжээнд мэдээлэл өгсөн. Энэ хүрээнд хэрвээ тухайн мөрдөн шалгах ажиллагаанд нь байгаа ажиллагаагаар тухайн хэргийг шийдвэрлэхэд ач холбогдолгүй, тухайн хэрэгт хамааралгүй байж болзошгүй эд зүйлс, төхөөрөмж тогтоогдвол прокурорын зөвшөөрлөөр буцааж болох ажлыг зохион байгуулах болно гэж мэдээлсэн байгаа. Танилцуулж дууслаа.

Д.Цогтбаатар: Тодруулах уу Уянгахишиг гишүүн айн? Уянгахишиг гишүүний микрофоныг өгье.

Г.Уянгахишиг: Миний 2 дахь асуулт уг нь их тодорхой байгаад байгаа юм. Анхны шалгалт явуулсан үндэслэл тогтоогдсон юм уу, эсвэл ингээд шал өөр хэрэг болоод явчав уу гэдэг асуулт байгаад байгаа юм.

Хоёрдугаарх тэр контенттой холбоотой, эд хөрөнгө, тоног төхөөрөмж хурааж авсантай холбоотойгоор тэр тоног төхөөрөмж дотор байгаа мэдээллүүд жишээлбэл, яаралтай ашиглах шаардлагатай, компанийн үйл ажиллагаатай холбоотой жишээлбэл контентууд, мэдээллүүд бэлтгэгчид хэргийн зүйлсийг хүсэлт гаргаад тэрийг авах боломж нь байх ёстой. Тэр хүсэлт гарсан уу? Хүсэлтийг нь хангаж байгаа юу буюу хэвлэн нийтлэх эрх чөлөөний чинь нэг хэсэг тэр шүү дээ. Өөрсдийнхөө хэвлэн нийтлэх эрх чөлөөнийхөө хүрээнд хийсэн бүтээсэн зүйлээ тодорхой цаг хугацаанд нь ил болгох гаргах тэр эрх чөлөө нь байж байгаа. Тэгэхээр тэр боломжийг хаагаад, хязгаарлаад тэр тоног төхөөрөмжийг чинь хадгалчхаад байгаа юм биш биз дээ гэдэг асуулт байгаад байгаа байхгүй юу. Бас 1 асуулт нь сая амралтын өдрүүдээр гарсан.../минут дуусав./

Д.Цогтбаатар: 1 минут өгье.

Г.Уянгахишиг: Сая амралтын өдрүүдээр мэдээлэл гараад байсан шүүх хурал хуралдчихлаа, тэгээд 1 сарын хугацаагаар баривчлах шийтгэл оногдууллаа, цагдан хорих. Тэгэхээр энэ нь өөрөө яг ямар хэрэгтэй холбоотойгоор энэ асуудал шийдэгдчихэв? Яг одоо энэ 3 сарын 17-нд үүссэн хойшлуулшгүй ажиллагаатай холбоотойгоор асуудал шийдэгдсэн үү, энэ эсвэл тусдаа явж байсан асуудал уу гэдэг ийм нэг бас асуулт гарч ирээд байгаа юм.

Д.Цогтбаатар: Цагдаагаас асууж байна уу? 8 дугаар микрофон.

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

Г.Уянгахишиг: Хугацаа байгаа юм чинь би бас юм хэлчихье. Сая Хүний эрхийн Комиссоос байна шүү дээ яг хэллээ шүү дээ. Өөрөөр хэлбэл, миний хүсээд байгаа юм энэ байхгүй юу. Бид нар хэрэг шалгаж болно, мэдээлэл авч болно. Гол нь энэ чинь хүний эрх зөрчигдөхгүй байх ёстой. Ямар тохиолдолд хойшлуулшгүй ажиллагаа явах ёстой юм, ямар тохиолдолд тэр шөнө байцаанаа гэдэг чинь өөрөө эрүүдэн шүүлтийн хэлбэр шүү дээ. Тэгэхээр энэ тал дээрээ цагдаагийн байгууллага анхаарч.../минут дуусав./

Д.Цогтбаатар: 8 дугаар микрофон.

Б.Батзориг: Таны асуултад хариулъя. Прокуророос өгсөн зөвшөөрлийн хүрээнд мэдээлэх боломжтой гэсэн энэ хэсгийн хүрээнд би таны асуултад хариулъя. Мөрдөн шалгах ажиллагаа бол үргэлжилж байгаа. Өнгөрсөн хугацаанд тухайн хэрэгт холбоотой буюу хэрэг бүртгэлтийн 2 дугаартай тусдаа хэрэг байгаа. Цахим тоглоомтой холбоотой, мөрийтэй тоглоомтой холбоотой хэрэг дээр 3 этгээдийг шүүгчийн захирамжаар, прокурорын саналаар, шүүгчийн захирамжаар цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан байна лээ.

Түрүүн буцааж өгөх асуудлын хувьд би түрүүн мэдээлэл өгсөн байгаа. Тухайн оролцогч нар прокурортоо, мөрдөн шалгах байгууллагадаа энэ асуудлаа, энэ үндэслэлээ тавиад өөрөө байдаг юм уу, өмгөөлөгчөөрөө дамжуулаад байдаг юм уу хүсэлтээ гаргах эрх зүйн зохицуулалт нь бол нээлттэй, бүрэн хангалттай байж байгаа. Тухайн асуудлыг прокурорт тавьсны дараа, эсвэл мөрдөн шалгах байгууллагын удирдлагад тавьсны дараа шийдвэрлэх боломжтой байх. Миний хувьд бол энэ талаар тодорхой шууд ирсэн.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Алтангэрэл сайдын микрофоныг өгье.

О.Алтангэрэл: Энэ анхны үндэслэл нотлогдсон уу, үгүй юү гэж. Энийг хэлэх бололцоогүй шүү дээ. Ер нь 1 зүйлийг бас тод тодруулаад хэлчихье. Энэ Комиссын гишүүн Нарантуяа энд сууж байна. Та бас хариуцлагатай ажил хийж байгаа хүн. Өнөөдөр та хэвлэлийн хурал хийхдээ Хууль зүй, дотоод хэргийн сайдын тэр нотлогдсон, тогтоогдсон гэж ярьсан энэ тэр гэж шууд тийм үг, хэллэг хэрэглэж байна лээ. Тэр лайв/live/ чинь байгаа. Би 1 ч тийм үг хэрэглээгүй, хэрэглэж болохгүй. Гэм бурууг чинь ганцхан шүүх тогтооно. Хүний эрхийг хамгаална гэж яриад тэнд ажил үүрэг гүйцэтгээд сууж байгаа хүн ингээд олон нийтээр хэн нэгнийг гүтгээд байж болохгүй шүү гэдгийг би сануулж хэлье танд.

Нотлогдож, тогтоогдсон эсэх талаар таны асуултад хариулах бололцоогүй ээ. Энэ асуудал чинь дараа нь шийдэгдэнэ. Тэр хурааж авсан зүйл гэж ярьж байгаа. Энийг хамгийн боломжит хугацаанд буцааж өгөх ёстой. Энэ дээр байр суурь нэг байгаа. Энэ дээр ул мөр шаардлагатай зүйлүүдээ бэхжүүлээд буцааж өгөх ёстой.

Д.Цогтбаатар: Энэ хэлэлцүүлгийн явцад манайхан нэг зүйлийг анхаараарай. Ер нь олон нийт ч гэсэн анхаармаар байна. Энд бид нар мэдээлэл авч, энэтэй холбогдуулж яг хүний эрхийн зөрчил гарч уу, үгүй юу, тэр эрсдэл цаашаа үргэлжлэх нь үү, үгүй юу ийм л юм ярьж байгаа шүү. Түүнээс хэн ч энд өнөөдөр буруутай, буруугүйн тухай ярих эрх ч байхгүй. Ийм тухай 1 үг дуугарах ч эрх байхгүй. Өнөөдөр презампшн оф инносенс/presumption of innocence/ буюу тэр

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

буруугүйн зарчим чинь үйлчлээд явж байгаа бөгөөд өнөөдөр энд байгаа, тэрэнд холбогдсон хүмүүс 1 нь ч буруугүй байгаа шүү гэдгийгээ тал талдаа манай олон нийт ч гэсэн тэрийг бас анхаараарай.

Яагаад гэвэл нэгэнт хэвлэлээр бас аягүй олон эерэг, сөрөг мэдээлэл явж байгаа болохлоор буруутай ч юм уу, буруугүй ч юм уу гээд энэ улсад үйлчилж байгаа хууль чинь шүүхээр шийдвэр гартал тэр хүмүүс чинь буруугүй байгаа шүү гэдгийгээ анхаарах нь зөв байх.

Нарантуяа гишүүн үг хэлье гэж байх шиг байна. 4 дүгээр микрофон.

Г.Нарантуяа: Хууль зүйн сайд бас тодорхой асуудлыг анхааруулсан учраас бол би энд хариулт өгөх нь зүйтэй гэж бодож байна. Тэгэхээр Хүний эрхийн Үндэсний Комиссын дүгнэлтийг гаргахдаа бид бүх эх сурвалжуудыг харьцуулан үзэж энэ яг ямар нөхцөл байдал болов гэдгийг бол нэг мөр тогтоож ингэж эцэслэдэг.

Тэгэхээр хэлсэн үг, өгүүлбэрийн хувьд бол Хууль зүйн сайдын тодорхой өдрүүдэд хийсэн мэдэгдлүүд дээр бол Хүний эрхийн Үндэсний Комиссын Гомдол, хяналт шалгалт хэлтсийн ажилтнууд бол бүгд дүн шинжилгээ хийсэн. Ямар үг илэрхийллийг ашигласан бэ гэдгийг бол бид маш нарийн тогтоосон. Энэ дээр хэрвээ шаардлагатай гэвэл бид танд Комиссоос хийсэн илтгэх хуудсыг хүргүүлэх нь бол маш илүү тодорхой мэдээллийг өгнө гэж бодож байна. Тэгээд Хууль зүйн сайд болон цагдаагийн эрх бүхий албан тушаалтнууд илэрхийлсэн байр сууриудыг нэрлээд гэх албаны байр байр сууриа илэрхийлж олон нийтэд.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.

Х.Баасанжаргал: 2 юм тодруулж асууя. Манай Байнгын хороо өмнөх хуралдаанаараа хуралдаанаа хаагаад, үргэлжлээд цагдаагийн одоо яг энд сууж байгаа албан тушаалтнаас бид нар мэдээлэл авсан. Тэгэхэд ерөөсөө энэ мөрийтэй тоглоом яригдаагүй. Гол нь энд чинь л бид нар эргэлзээд байна шүү дээ тээ Хууль зүйн сайд аа? Та мөрийтэй тоглоом хүнийг амиа хорлоход хүргэсэн гээд угаасаа шалгаж байсан энэ 2 хэргийн тухай одоо ярих чинь өөрөө утгагүй шүү дээ. Ямар ч логикийн ямар ч холбоо хамааралгүй юм яриад байгаа биз дээ? Тэгээд хамгийн гол нь бид нарын тодруулаад асуугаад байгаа юм энэ байхгүй юу өмгөөлөгч нь өөрөө мессежээ ил болгосон хамгийн эхлээд. Манай үйлчлүүлэгчийг энэ 19.9.1-д заасан гэмт хэрэгт буруутгагдаж байгаа юм байна гэдгийг өмгөөлөгч л болгосон. Одоо бүгд энийг мэдэж байгаа.

Дараа нь прокурорын байгууллагаас худал мэдээлэл тараасан гэдэг үндэслэлээр тодорхой нэр бүхий иргэдийг баривчлах ийм хүсэлт ирүүлснийг прокурор татгалзаж шийдлээ гэдэг прокурор өөрөө ийм хэвлэлийн мэдээ гаргасан. Дараа нь энд сууж байгаа цагдаагийн байгууллагын албан тушаалтан Байнгын хорооны гишүүдийн өмнө бас яг худал мэдээлэл гэдэг үндэслэлээр энэ байгууллагыг шалгасан гэдгийг хэлсэн. Тэгээд дараа нь 4 дэх дээр нь яг цагдаагийн байгууллага хэвлэлийн хурал хийхдээ энэ мөрийтэй тоглоом гэдэг зүйл гарч ирсэн. Гол эргэлзээд байгаа юм энэ л байхгүй юу.

Тэгэхээр бид нарын тодруулаад асуугаад байгаа юм тухайн хойшлуулшгүй ажиллагааны, ажиллагаа хийх зайлшгүй, гарцаагүй ямар нотлох баримтууд,

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

үнэхээр тийм гарцаагүй үндэслэл байсан юм уу? Байгаагүй юм байна аа гэдэг чинь өөрөө яг ингээд удаа дараагийн чинь ингээд хийж байгаа мэдээллүүдээр энэ тэр бүгд ингээд няцаагдаад байгаа байхгүй юу. Хоорондоо ингээд зөрчилдөөд байгаа.

Тэгэхээр ялт ч үгүй иргэд энэ дээр эргэлзээд байна. Би ч өөрөө эргэлзэж байна. Тодорхой асуултаа асууя. Бас яг энд байгаа цагдаагийн алба хаагч хэлж байсан. Худал мэдээлэл тараах гэдэг хэргээр шалгаж байгаа хэдий ч гэсэн бид нар ерөөсөө энэ байгууллагын хэвлэлийн эрх чөлөөтэй холбоотой асуудлаар хяналт, шалгалтын ажиллагаа явуулаагүй гэдэг ийм мэдэгдлийг хэлсэн.

Тэгээд худал мэдээлэл гэдгээр шалгаж байгаа мөртөө хэвлэн нийтлэх эрхтэй нь хамаагүй юм аа гэдэг. Би ерөөсөө энэ логикийг бас ойлгохгүй байгаа. Энийг та тайлбарлаад өгөх юм уу, эсвэл цагдаагийн алба хаагч өөрөө дахиад тайлбарлах юм уу? Одоо яг ийм микрофонтой камерын өмнө тайлбарлаад өгөөч. Хэвлэн нийтлэх эрх чөлөөтэй хамаатай юм уу, хамаагүй юм уу? Хэрвээ хамаагүй бол тэр холбогдох тоног төхөөрөмж, камераа гээд ингээд өчнөөн олон юмнууд хураагдлаа гээд л ингээд хүмүүс гомдол гаргаад байдаг. Яг хэвлэн нийтлэх эрх чөлөөтэй хамаагүй юм бол яагаад энэ тоног төхөөрөмжүүдийг нь одоо болтол олгохгүй байгаа юм бэ?

2 дугаар асуулт. Шөнөжингөө тэр цагдаагийн байгууллага дээр суулгасан гэдэг асуудал тодорхой болчихсон тээ? Энэ баривчилгаа юм уу, саатуулах ажиллагаа юм уу? Эрүүгийн процессын хуулийн дагуу хийсэн юм уу, Цагдаагийн албаны тухай хуулийн дагуу хийсэн юм уу? Хэрвээ Эрүүгийн.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Цагдаагийн Батзориг хурандаад микрофон өгье. 8 дугаар микрофон.

Б.Батзориг: Гишүүний асуултад хариулъя.

Цагдаагийн байгууллагаас явж байгаа, явуулсан саяын, сүүлийн олон нийтэд мэдээлэгдээд байгаа хэрэгтэй холбоотой энэ асуудал дээр цагдаагийн байгууллагаас, тухайн мөрдөн шалгах байгууллагаас Эрүүгийн хэрэг хянан шийдэх тухай хуулийн 22.1, 22.2, 22.3, 22.4-д зааснаар мөрдөн шалгах ажиллагааг явуулсан байна. Энэ хүрээнд тухайн харьяалах, хяналт тавих чиг үүрэг бүхий прокурор нь хянаж үзээд хуульд зааснаар хүчинтэйд тооцоод цаашаагаа мөрдөн шалгах ажиллагаа прокурорын хяналтад үргэлжлээд явагдаж байгаа.

Тэр мэдээлэл өгсөнтэй холбоотойгоор бас нэмэлт тайлбар хэлэхэд яг миний хувьд бол тухайн үед нөхцөл байдлаа хэлж байсан гадуур ажилтай явж байгаад шууд дуудагдаад ирчихсэн. Анхны ерөөсөө яг мэдээлэл дөнгөж аваад ингэж байсан учраас тодорхой мэдээлэл надад байгаагүй. Анхны мэдээллээрээ л ярьсан. Тухайн нөхцөл байдал нь анхандаа ерөөсөө л тийм байсан. Юу яадаг юм байна сүүлд цагдаагийн байгууллагаас мэдээллийн талаар тайлбараа өгчихсөн байж байгаа, сайдаас бас сая мэдээлэл бас та бүхэнд тайлбарлалаа. Хэрэг бүртгэлтийн 2 дугаартай хэрэг байна.

Үүнээс гадна гомдлын, гомдол, мэдээллийн дугаартай бас гомдол, мэдээлэл бүртгэгдэж байгаа юм байна. Эдгээр нөхцөл байдлуудыг эхний ээлжид гомдол мэдээллийн мэдээллүүдийг танилцуулж байгаад төгсгөл рүүгээ өмнө нь хэрэг

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

бүртгэлтийн хэргийн мэдээллүүдийг хамтад нь танилцуулсантай холбоотойгоор олон төрлийн мэдээлэл өгч байгаа байдлаар бас андуурагдсан гэдэг юм уу ийм нөхцөл байдал үүссэн байж болзошгүй байна. Цаашдаа энэ асуудал дээр холбогдох мөрдөн шалгах байгууллага, холбогдох албан тушаалтнуудад сайн анхааруулж, хэлж ярих болно, уламжлах болно.

Д.Цогтбаатар: Алтангэрэл сайдын микрофоныг өгье.

О.Алтангэрэл: Тийм, манай Баасанжаргал гишүүн энэ байгууллагыг нь шалгасан гээд яриандаа ярьчихлаа. Байгууллагыг ерөөсөө шалгаагүй гэж ойлгож байгаа юм. Ийм мэдээлэл ерөөсөө байхгүй шүү. Байгууллага гэдэг үг байхгүй. Тэгээд энэ дээр хууль бусаар мөрийтэй тоглоом зохион байгуулах хэрэг байна уу? Байна. Шалгаж байна. Бусдыг амиа хорлоход хүргэх хэрэг байна уу? Байна. Худал мэдээлэл тараах гэмт хэрэг гомдол байна уу? Байна. Олон төрлийн зүйл дээр шалгалтын ажиллагаа явуулж байгаа гэдэг нь мэдээллийг л хэлээд байгаа юм. Эд нар хэрвээ өөрчлөгдсөн бол тэр 2022 оноос, 2024 оноос шалгагдаж байсан энэ хэргүүдийн процессын явцын үйл ажиллагаа бүгд явж байгаа шүү дээ. Одоо энэ зүйлд зориулаад тэнд хэн 1 хүнийг амь насыг нь хохироох боломж байхгүй. Одоо энэ хэрэгт зориулаад тэр хүнийг 9, 10 тэрбум төгрөгөөр тоглуулах, нөхөж тоолуулах боломжгүй хэрэг явж байсан гэдгийг л хэлж байгаа юм.

Харин санаа зовж байгаа асуудлыг чинь ойлгож байгаа юм. Энэ хэвлэн нийтлэх эрх чөлөөтэй холбоотой байж магадгүй л гэж. Яагаад энэ худал мэдээлэл тарах, хэвлэн нийтлэх эрх чөлөөтэй холбоотой, хамааралтай юм аа, хамааралгүй гэдэг ийм асуудал ярьж байгаа. Би танд 1 статистик хэлье. 1 минут нэмж авч болох уу?

Д.Цогтбаатар: Алтангэрэл сайдын микрофоныг нэмж өгье.

О.Алтангэрэл: Худал мэдээлэл тараах гэмт хэрэг гэж хэрэг байгаа. Энэ дандаа хэвлэн нийтлэх эрх чөлөөтэй холбоотой үйлдэгддэггүй. Субъектийн хувьд ч тийм. Хэвлэл мэдээллийн байгууллагатай дандаа холбодог боловч өнгөрсөн 2024 он, 2025 оны эхний 2 дугаар сарын байдлаар худал мэдээллийг олон нийтэд тараасан гэж 476 хэрэг бүртгэгдэн шалгагдсанаас 476 хэрэг, 54, 54 сэтгүүлчид хэвлэл мэдээлэлтэй холбоотой байгаа. Өөрөөр хэлбэл 422 хэрэг нь сэтгүүлч хэвлэн нийтлэх эрх чөлөөтэй холбоогүйгээр бусдыг цахим сүлжээнд доромжилсон, нэр төрд нь халдсан, худал мэдээлэл тараасан гэдэг ийм гэмт хэргээр явж байгаа учраас заавал энэ хэргүүд хоорондоо шалтгаант холбоотой байх ёстой, хэвлэн нийтлэх эрх чөлөөтэй нь холбоотой байх ёстой гэсэн дүгнэлтийг хийж болохгүй байх гишүүн ээ. Баривчилгаа бол ерөөсөө огт явагдаагүй шүү дээ. Нэг зүйл байгаа та мэдэж байгаа.

Д.Цогтбаатар: Алтангэрэл сайдын микрофоныг өгье.

О.Алтангэрэл: Хэрвээ баривчилгаа байсан бол Эрүүгийн хуулиар энэ өөрөө баривчилсан тэр хүмүүс нь хариуцлагаа хүлээх ёстой. Прокуророос татгалзсан байгаа юм. Энэ хүмүүсийг ингээд хойшлуулалгүй баривчилъя аа гээд. Тэгэхээр энэ үйл ажиллагаа ерөөсөө явагдаагүй. Харин таны хэлж байгаа энэ шөнийн цагаар байцаалт авсан, энэ хүмүүсийг саатуулсан, нэр томьёоны хувьд мэдүүлэг авсан энэ үйл ажиллагаа нь яг хуулийн дагуу байна уу, үгүй юу гэдэг зовнилыг ойлгож байгаа. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны гол

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

үндэст хяналт тавих үүрэг бүхий этгээд прокурор энэ үйл ажиллагаагаа 24 цагийн дотор прокурорт мэдэгддэг. Энэ үйл ажиллагаа нь явагдчихсан байна гэж ойлгож байгаа. Баривчлах үйл ажиллагаа огт явагдаагүй. Шүүхийн журмаар цагдан хорьж байгаа үйл ажиллагаа энэ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмын дагуу ганцхан энэ хэрэгт шалгагдаж байгаа иргэн биш, өөр бас 2 иргэний хувьд хоригдсон гэдэг ийм мэдээлэлтэй байна.

Д.Цогтбаатар: Одоо Дамдинням. Баасанжаргал гишүүн тодруулъя. Одоо 1 шүү дээ тээ?

Х.Баасанжаргал: Үгүй шүү дээ. Тэгэхдээ багтаачихъя би. Гол нь яагаад баривчилгаа юм уу, саатуулах юм уу гэж тодруулаад асуугаад байна. Бүтэн шөнөжингөө хүнийг явуулахгүй байлгана гэдэг чинь өөрөө ямар нэгэн байдлаар хууль зүйн үндэслэлээр байлгаад байнаа даа процессын хуулиар. Тэгэхээр бодвол баривчлах биш юм бол эрүүгийн процессын хуулиар биш юм бол Цагдаагийн хуулийн дагуу хийж байгаа саатуулах ажиллагаа болж таараад байна шүү дээ. Зөв үү? Хэрвээ саатуулах ажиллагаа мөн гэж үзэх юм бол Цагдаагийн албаны тухай хуульд заасан үндэслэл, шаардлагыг энд чинь хангахгүй шүү дээ. Бид нар түрүүчийн чуулганаараа Цагдаагийн албаны тухай хуулийн саатуулахтай холбоотой заалтад өөрчлөлт оруулсан. Ямар тохиолдолд хүнийг хойшлуулахгүй яг ингээд саатуулах юм бэ гэдэг дээр.

Тэгэхээр яг энэ тохиолдол ерөөсөө саатуулах үндэслэл харагдахгүй байгаа байхгүй юу. Тэгэхээр хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой асуудал дээр яагаад ингэж ийм гоомой, ийм хөнгөн хуумгай, яагаад ингэж ийм байдалтай хандаж байгаа юм бэ гэдэг яг энэ хандлага чинь өөрөө ерөөсөө болохгүй байна сайд аа. Тэгэхээр би таныг яг улс төрийн албан тушаалтныхаа хувьд тэр чиглэл өгдөг юм уу, мэдэхгүй ямар эрх зүйн акт гарах ёстой юм? Ерөөсөө яг ямар ч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, ямар ч.../минут дуусав./

Д.Цогтбаатар: 1 минут өгье.

Х.Баасанжаргал: Судалгааны явцад ямар ч ийм үндэслэлгүйгээр хүнийг ийм байдалд оруулж байгаа энэ дээрээ та нар залруулга засах, эсвэл уучлалт гуйх, одоо уучлалт гуйна ч гэж манайхан бараг байхгүй л байх л даа. Залруулах энэ ажиллагаагаа хийгээсэй гэж хүсэж байна.

Хоёрдугаарт, хэвлэлийн эрх чөлөөтэй хамаагүй гэж байгаа бол тэр хурааж авсан эд зүйл дээр үзлэг хийх явц чинь хамгийн чухал нарийн байгаа. Жишээ нь өмгөөлөгчийг ямар нэгэн хэрэгт холбогдуулаад шалгаад миний бүх материалыг хурааж авлаа гэхэд миний материал дотор үйлчлүүлэгч асар их нууц байгаа. Яг үүнтэй адилхан сэтгүүлчдэд эх сурвалжийн нууц гэж байдаг. Энэ мэдээлэл нь алдагдвал яах вэ, энэ мэдээлэл рүү нь та нар эрээ цээргүй л халдаж байна гэсэн үг шүү дээ. Энэ чинь өөрөө бас зөрчил биш юм уу?

Д.Цогтбаатар: Алтангэрэл сайд яах вэ хариулах уу?

Х.Баасанжаргал: Гишүүний зовнилыг ойлгож байна. Тэгэхдээ одоо манай хуульд энэ эх сурвалжийн нууц гэж байхгүй шүү. Бид нар бас хэдүүлээ асуудлаа ярих ёстой. Хуульд эх сурвалжийн нууц гэж өнөөдөр байхгүй. Шинээр өргөн барьчихсан төсөлд эх сурвалжаа нууцлах эрхтэй гээд орчихсон явж байгаа. Та бас

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

энийг мэдэж байгаа хүний хувьд. Тэгэхдээ энийг нууцлах ёсгүй гэж хэлээгүй, нууцлах ёсгүй гэж хэлээгүй. Эх сурвалжаа нууцлах эрхийг өнөөдөр л бид нар хуулийн төсөл дээр оруулаад Хууль зүй, дотоод хэргийн яамнаас болон Засгийн газраас санаачилж байгаа хууль дээр байгаа шүү. Өнөөдөр хэвлэлийн эрх чөлөөний 4-хөн зүйлтэй хууль дээр чинь энэ тухай 1 ч зүйл байхгүй шүү. Тэрийг санаачлаад явж байгаа.

Тэгэхлээр үзлэг, нэгжлэг хийж байгаатай холбоотойгоор тэр мэдээлэл аюулгүй байдлын санаа зовж байгаа асуудлыг ойлгож байгаа. Тэгээд энэ дээр нэг ийм асуудал байгаад байгаа юм билээ. Энэ шүүх шинжилгээнд, дүгнэлтийг Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэн гаргах гаргах ёстой. Тэгэхээр энэ өмгөөлөгчтэй нь хамтраад тэр материалыг хуулах, ажиллах бололцоогоор нь хангах энэ ажлыг зохион байгуулж байгаа гэсэн ийм мэдээлэлтэй бас байгааг танд нэмж хэлье.

Д.Цогтбаатар: Манайхан нэг юмыг хэдүүлээ анхаармаар байна. Би сая зүгээр чимээгүй л сонсоод сууж байгаа. Энэ чинь үнэхээр хараат бус бас шалгалт явах ёстой. Бид нар энд энэ чинь улс төрийн механизм, энэ улсад байгаа хамгийн том улс төрийн механизм шүү дээ. Бид нар тэгээд энэ шалгалт явж байгаа хүмүүсийг энд нь ингэж авчирч байгаад, суулгаж байгаад ярьж байгаа болохлоор хэд хэдэн юмыг бодох хэрэгтэй. Сая асууж байгаа асуултууд дотор би чимээгүй л асуулгаж байгаа юм.

Тэгэхдээ та нар асуух ёсгүй юмнууд яг эрх зүйн хувьд асуух ёсгүй, нөгөө тал хариулах боломжгүй юмнуудыг асууж байна шүү. Би тэгээд дуугүй өнгөрсөн. Би цагдаагийнханд хэлье. Та нар хариулах боломжгүй юмаа хуулийн дагуу энэ дээр одоогоор хариулах боломжгүй гэдгээ шууд хэл. Түүнээс бас л бид нар хуульд л захирагдаж амьдарна. Түүнээс их дарга, цэрэг нар ирээд энд суугаад байгаа биш. Та нар тэр шалгадаг ажил дээрээ та нар гол хүмүүс чинь.

Тийм учраас тэр хариултаа өгч байхдаа энэ дээр би хариулах боломжгүй байгаа шүү гэдэг юмнуудаа шууд хэлж байгаарай.

8 дугаар микрофоныг өгье.

Б.Батзориг: Баасанжаргал гишүүний асуулт дээр нэмэлтээр хариулъя. Саатуулах ажиллагаа явагдаагүй бөгөөд үндсэндээ цахим төхөөрөмж, гар утас, таблиц зэрэгт үзлэг хийхэд тухайн эзэмшигчийг, тухайн өмчлөгчийг өөрийг нь байлцуулдаг байлцуулдаг. Байлцуулаад тухайн төхөөрөмжид юу юу байгаа юм бэ гэдгийг яг энэ хөндлөнгийн гэрч нотлох бүхий л ажиллагаагаа хийж байлцуулдаг учраас эзнийг нь өөрийгөө байлцуулах ажиллагаа маань өөрөө удааширсан ийм нөхцөл байдлууд бас байгаа гэдгийг манай холбогдох бас байгууллагуудаас надад мэдээлэл ирүүлсэн. Үүнийг нэмэлтээр хариулъя.

Д.Цогтбаатар: Дамдинням гишүүний микрофоныг өгье.

Г.Дамдинням: Яах вэ хамгийн түрүүнд бид нар Улсын Их Хурал, Улсын Их Хурлын гишүүд, Байнгын хороо ингээд л Хууль зүйн сайд руу дайраад байгаа юм шиг, Хууль зүйн сайдын үйл ажиллагаанд садаа болоод байгаа юм шиг ийм ойлголт яваад байдаг юм. Зарим яваад байна лээ. Ёстой тийм юм байхгүй шүү. Хамгийн их дэмжигдсэн сайд бол Хууль зүйн сайд шүү. Хүний эрхийн асуудал, шүүхийн шийдвэр гүйцэтгэл дээр байгаа асуудлууд, цагдаагийн орон тооны

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

асуудлууд гээд 2025 оны алдагдалгүй төсөв батлахад хамгийн их орон тоо нэмүүлж, хамгийн их мөнгө тавиулсан сайд бол Хууль зүйн сайд. Би өөрөө энэнд нь дэм болоод явж байсан хүн. Хүний эрхийг хамгаалаарай л гэж тэр дээр нь зүтгэж дэмжиж өгцгөөсөн шүү дээ бид нар.

Тийм учраас Их Хурлын гишүүд энд хариуцлага нэхээд байгаа байхгүй юу Алтангэрэл сайд аа. Тэрийг бас ойлгоно биз. Одоо тэгээд энэ хариу нь тэгээд л нэгдлийн улаан бух гээд би бүр зориуд твиттертээ бичсэн юм. Энэ улс коммунизмын үеийн хууль, шүүхийн байгууллагын дарга нар ингээд хүн яллах гэж дайраад байдаг учраас тэгж нэрлэдэг байсан юм байна лээ. Нэгдлийн улаан бух шиг тэгээд л зүйл, анги нь өөрчлөгдөөд л Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хортой гэсэн 1 заалт зарлаад л, дараа нь хүний амь насны асуудал яригдаад л, дараа нь мөрийтэй тоглоомын асуудал болоод л. Тэр 8 хүүхэд 1 байгууллагад ажилладаг. Тэгвэл тэр холбоотой байгаа 2 хүүхдийг нь бариад л явна биз дээ? Яахаараа 8-ууланг нь аваачаад шөнөжингөө байцаачихдаг юм? Би асуугаад байна шүү дээ. 126 гишүүний 1 нь асуудалд орвол 126-ланг нь аваачаад шөнөжингөө байцаах уу? 1 байгууллагад ажилладаг учраас. Эрүүгийн гэмт хэргийг нялзааж хэрэглэж болохгүй байлгүй дээ энэ чинь. Одоо тэгээд болохоор тэр сайттай холбоотой асуудал байхгүй гээд байна л гэсэн. Сайт л гэж яриад байсан шүү дээ. Noorog.mn, noorog.mn гээд л хэвлэлийн бага хурал хийгээд байсан биз дээ? Үгүй л гээд байх юм. Энэ цагдаа танд танилцуулаагүй байхад та хаанаасаа тэр 9.3 тэрбум төгрөгийг мэдчихсэн юм? Прокурорын дүгнэлт гарахаас 1 хоногийн өмнө хэвлэлийн бага хурал хийсэн санагдаад байх юм. Бид нарын томилсон Их Хурал өөрөө томилсон, хүний эрхийг хамгаалаад дүгнэлт гаргаад өгөөрэй гэж гаргасан Хүний эрхийн Комисс энд ирээд суучихсан хууль зөрчсөн байнаа гээд хэлж байна шүү дээ Их Хурлын гишүүд ээ. Ноцтой шүү дээ. Хүний эрхийн асуудлыг хамгийн их ярьдаг байгууллага байхгүй юу. Тэгээд бид нар энд хариуцлагын асуудал ярихгүй юм уу? Тэгээд формалдаад өнгөрөх үү хэдүүлээ? Энэ дүгнэлт дээр та ер нь ямар байр суурьтай байна Алтангэрэл сайд аа? Ер нь эцэст нь тэгээд ер нь энэ асуудлууд болоод өнгөрлөө. Хэдэн цагдаа хариуцлага хүлээгээд л өнгөрөх вий дээ. Явж явж хөөрхий дөө энэ муу мөрдөгч хариуцлага хүлээгээд л өнгөрнө. Монголын цагдаад сайн хүмүүс байгаа шүү. Гагцхүү харин буруу юм хийлгэдэг дарга нар байгаа шүү. Энэ тухай та ер нь ямар байр суурьтай байна? Хууль зүйн сайд өөрөө энэ дээр ер нь улс төрийн хариуцлагаа хүлээнэ гээд мэдэгдэл гаргаад байсан. Хариуцлагаа хүлээх үү? Хүний эрхийн Комисс дүгнэлт гаргачихсан байна шүү дээ. Энэ дээр ямар байр суурьтай байна?

Д.Цогтбаатар: Алтангэрэл сайдын микрофоныг өгье.

О.Алтангэрэл: Төсвийн үеэр дэмжсэнд бас салбарынхаа өмнөөс баярлаж явдаг гэдгээ хэлье. Энэ яагаад 8-ланг нь шөнөжин байцаадаг юм байна гэж. Энд тайлбараа тодорхой хэлээд байгаа байхгүй юу. Байцаагаагүй. Үзлэг, нэгжлэг хийсэн тэр үед нь гэрчээр байлцуулсан гэж хэлээд байгаа юм. Үнэхээр тэр байцаалт, шөнөжин байцаагаад ингээд энд бас байсан бол асуудал өөр цагдаагийн байгууллага тайлбараа хэлээд энд бид нар байцаагаагүй гэдэг тайлбараа танилцуулж байгаа юм. Тэр яагаад танилцуулаагүй байхад танилцав гэж. Он сартай нь би яг ямар учраас мэдээлэл хийх вэ гэдгээ энэ чинь бодож төлөвлөж байгаад ярина шүү дээ. 2025 оны 3 дугаар сарын 19-ний өдөр Засгийн газрын хуралдаан дуусаад Засгийн газрын хурал дээр танилцуулсан агуулгынхаа дагуу мэдээлэл өгсөн. Ингэхдээ хэлсэн үг болгоныхоо цэг, таслал дээр хариуцлага хүлээнэ гэж хэлсэн юм. Энэ зүгээр хүч оруулах гэсэн тийм үг биш.

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

Яагаад гэвэл цагдаагийн байгууллагыг явуулсан үйл ажиллагааныхаа талаар мэдээлэл өг гээд цагдаагийн байгууллага олон нийтэд мэдээлэл өгсний дараагаар юун мөрийтэй тоглоом гараад ирэв ээ, өөрчлөөд байгаа юм биш үү та нар гээд олон нийтийн зүгээс эргэлзээ үүссэн учраас цагдаагийн байгууллагын прокуророос авсан зөвшөөрлийн хүрээнд би түрүүн Ганбат гишүүнд хэлсэн, одоо танд дахиж хэлье. Та бүхэн маань бас танилцах эрхтэй хүмүүс учраас прокурорын тэр зөвшөөрөлтэй үзээрэй. Он сарыг нь тулгаж хараарай. Энэ хууль зүйн асуудал яригдаж байгаа учраас бэлэн байгаа. Ийм учраас олон нийтэд мэдээлэл өгсөн юм. Яагаад танилцуулав гэж.

Хүний эрхийн Үндэсний Комиссын дүгнэлтийг хүндэтгэж байгаа, хүндэтгэж байгаа. Тэгэхдээ өнөөдөр энэ гэмт хэрэгтэй тэмцэж байгаа, хууль бус юм болгоны өмнө явж байгаа цагдаагийн байгууллагын албан хаагчдын асуудал яригдаж байгаа. Өнөөдөр цахим мөрийтэй тоглоомтой тэмц, гэмт этгээдүүдийг барь гэж хэлчхээд энэ асуудалтай тэмцээд явахаар нь ямар үндэслэлгүйгээр энэ хүмүүсийг буруутгахгүй, болохгүй. Тэгээд миний хэлсэн өгүүлбэр тэр шүү дээ. Хэрвээ хэн нэгний буруутгал хэрэгтэй байгаа бол, хэрэв улс төрийн буруутгал хэрэгтэй байгаа бол би тэрийг хүлээхэд бэлэн гэсэн юм. Яагаад ингэж хэлж байгаа вэ гэхлээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дүгнэлт өгөх эрх бүхий цорын ганц субъект прокурор. Прокурор энд хууль зөрчигдсөн үү, үгүй юу гэдгийг хэлнэ. Прокурор хууль зөрчигдсөн эсэх талаар дүгнэлт гаргана. Өнөөдөр прокурорын байгууллага дүгнэлтээ гаргачихсан байна.

Дээрээс нь хэрвээ өнөөдөр Хүний эрхийн Үндэсний Комиссын ярьж байгаа зүйл үндэстэй бол энэ өөрөө шүүхээр орох гэмт хэргийн дайны асуудал Хүний эрхийн Үндэсний Комисс ярьж байгаа. Комисс чинь хариуцлагаа хүлээх байх. Тэгэхлээр энэ асуудал энэ тогтоогдоод гараад ирэх юм бол энэ дээр их айгаад, бултаад ингээгүй тэгээгүй гээд байх юм ерөөсөө байхгүй ээ. Асуудлын гол нь хаана байна вэ гэхлээр энэ асуудал дээр хяналт тавих хүмүүс нь хяналтаа тавьсан, дахиад цаашаагаа үйл ажиллагаанууд үргэлжилж байна. Асуудал тодрох болоогүй. Хэний ч гэм буруугийн асуудал өнөөдөр яригдаагүй байгаа шүү.

Д.Цогтбаатар: Дамдинням гишүүний микрофоныг өгье.

Г.Дамдинням: Тэгэхээр энэ Монголын ард түмний эрх чөлөөтэй байх уу, үгүй юу, айдсаар удирдагдах уу, үгүй юу гэдэгтэй холбоотой л асуудал яригдаж байгаа байхгүй юу. Цаад бүр гүнзгий утга нь. Тийм учраас л энэ кэйс дээр Монголын залуучууд шинэ үе харин ёстой гоё болчихсон тулдаа энэ асуудлыг олны анхаарлын төвд авчирч байгаа юм.

Залуучууддаа хандаж уриалъя, бие биеэ өмөөрөөрэй, хамгаалаарай, дуугараарай, энд чинь бас энэ 126 дотор чинь бүгдээрээ бас хүний эрхийн мэдрэмжтэй хүмүүс сууж байдаг юм шүү, хамтдаа байна аа, хууль бус юм байвал хамгаална аа, өмгөөлнө өө. Цагдаа нар дотор муу хүмүүс цөөн байдаг аа, цагдаа нар дотор сайн хүмүүс нь дийлэнх байгаа. Гагцхүү зарим муу удирдлагынх нь үйл ажиллагаагаар энэ том байгууллагын нэр хүнд хаяад сэвтчих гээд байдаг юм шүү л гэдгийг хэлж байгаа шүү. Тэгээд энэ дээр бас Хууль зүйн сайд анхаарч, энэ хариуцлагын асуудлаа ярина биз дээ та нар өөрсдөө ч гэсэн.

Д.Цогтбаатар: Алтанхуяг гишүүний микрофоныг өгье.

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

Н.Алтанхуяг: Нөгөө ямар кинон дээр гардаг билээ их тоогүй л юм болж байгаа юм даа. Тийм яриа гардаг. Тэгэхээр би энэ Хүний эрхийн энэ Комиссын дүгнэлтийг би нэлээн сайн сонссон. Энэ Нарантуяа өөрийн чинь яриад байгаа юмыг сонссон. Би бичиж тэмдэглэж авсан. Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийг зөрчсөн, прокурор шалтгаан, үндэслэлийгээ бол танилцуулаагүй, танилцуулсан ч тэр нь байнга өөрчлөгдөж солигдсон, факт ярьж байна шүү дээ. Олон нийтийн мэдээлэл авах эрхийг хангаагүй, бүгдээрээ олон нийтээрээ монголчууд оньсого таасан. Хэрэг хийчихсэн ч юм уу, яачихсан ч юм уу. Би ер нь бас энэ тэр залуу, хөгшиндөө биш хэдүүлээ жаахан хүний эрхийн мэдрэмжтэй л ажилламаар байна. Би Алтангэрэлийг тэгж ажиллах байх, өмгөөлөгч хийж байсан хүн. Намайг болоод намайг тойрсон хэрэг дээр бас өмгөөлөл хийгээд явж байсан хүн болохоор тэгж горьдсон. Сая жаахан буруу л боллоо.

Хамгийн наад зах нь манай Байнгын хорооныхон ч гэсэн анхаармаар юм байна. Би энэ Эрүүгийн байцаан шийтгэх хуульд 2024 оны 1 сард өөрчлөлт оруулахад нь энэ процессын хууль дээр бүүр яг энэ хойшлуулшгүй гээд үг, үсгээр нь хөөцөлдөж суусан. Мөнх-Оргил гишүүн ахалсан байхгүй юу. Тэгээд амьдрал дээр их өөрөө хэрэгждэг юм байна. Одоо жишээлэх юм хэний мэдээллээр хойшлуулшгүй гэж үзэж байгаа юм? Цахим хуудаснаас явуулсан мэдээллийг алиныг нь яг хойшлуулшгүй мэдээлэл, хойшлуулшгүй нөхцөл байдал үүсчихье гэдгийг хэн тогтоож байгаа юм? Ингээд ярья дараагаар нь хойшлуулшгүй гэдгийг яг хэн тогтоох юм? Мэдээж хутга бариад дайрч байгаа бол хойшлуулшгүй гээд нь нэг нийтлээд гаргах ёстой. Ийм ийм юмнууд тодруулмаар юм байна. Энэ миний их харамсаад байгаа юм байна шүү дээ. Хүнийг ингээд залхаан цээрлүүлдэг аргыг энд хэрэглэчихсэн л байгаа байхгүй юу. Энд тэнд явж байсан залуучуудыг энд тэндээс бөөгнүүлж авчраад 22 цагаас өглөөний 7 хүртэл байлгана гэдэг зүгээр л эрүүдэж байгаа байхгүй юу. Хуцаарай та нар аятайхан байгаарай л гэсэн үг шүү дээ. Үгүй ийм баймааргүй л байх юм даа. Энэ баривчлах үндэслэл чинь тэгээд ямар их солигддог юм бэ? Тэр өмгөөлөгчийнх нь тэр утсан дээр байгаагаар бол үндэсний аюулгүй байдалд заналхийлсэн, дараагаар нь худал мэдээлэл тараасан, тун удалгүй цахим мөрийтэй тоглосон. Тэгээд одоо тэр 8 залууг өглөөний 7 хүртэл байлгасан. Одоо тэгээд 1 ганц асуулт байгаа шүү. Одоо 3 хүн хорьчихсон гээд байна. Тэр 8-аас нь 3 хорьчоод байгаа юм уу? Хэдэн хүн хорьчоод байгаа юм тэрийг хэлээдхээч.

Ер нь би бас энэ хөөе Дамдинням гишүүн та бид чинь ганц юман дээр санал нийлж байна. Энэ буруутай этгээдийг олж хариуцлага тооц оо, ингэж бид нар худлаа хоёрын хооронд юм хийгээд яах юм, хэн буруутайг нь би мэдэхгүй байна. Та болохоор дарга нар нь л буруутай байж магадгүй, цагдаа нь буруугүй. Би бол мэдэхгүй. Ер нь бол энэ дээр шаардлагатай бол бас өөр янз бүрийн комисс гаргаад ажиллаад хийх хэрэгтэй. Би Хүний эрхийн Комисс.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Алтанхуяг гишүүний микрофоныг өгье. Алтанхуяг гишүүний микрофоныг өгье.

Н.Алтанхуяг: Би Хүний эрхийн Комиссынхонд их талархаж байна. Нарантуяа та нарт. Та нарыг би томилогдож байхад чинь жаахан баалж байсан юм. Та нар амьдрал мэдэхгүй, зориг зүрх байхгүй, хулчгар муу сайн юмнууд гээд. Энэ дээр бол та нар их аятайхан дүгнэлт гаргасан байна. Тэгэхдээ Алтангэрэл

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

сайдын дүгнэлтийг буруу гэж байгаа бол та нар маргах ёстой. Бас ийм кэйс гармаар байна. Хэн нь үнэн яриад, хэнийх нь дүгнэлт худлаа яваад байгаа юм?

Ер нь би боловсон байдлаар Алтангэрэл сайдад хэлэхэд буруутай хүмүүс болоод хариуцлага тооцчих. Ер нь энэ залуучуудаас юм уу, хэнээс ч юм буруу энэ хэлмэгдээд байгаа, хэлмэгдэж байгаа байхгүй юу энэ чинь. Хэлмэгдээд байгаа хүмүүсээс уучлал гуйчих. Өнөө өглөө би тэрний бичлэг харсан үнэн, худлыг би мэдэхгүй. Ер нь зүгээр энэ кибер аюулгүй байдал, цахим мөрийтэй тоглоом гэдэг чинь өөрөө бүр дампуурчихсан юм явж байгаа юм биш биз дээ. Та тэн дээр бас анхаарал тавиарай, жаахан шударга ажиллаад өгөөрэй, хүний эрхийн мэдрэмжтэй ажиллаад өгөөрэй. Монголын хэн нэгэн залуу, хэн нэгэн хөгшин хүн, хэн нэгэн хүн хэлмэгдмээргүй л байна. .../минут дуусав./

Д.Цогтбаатар: Хэнээс, Алтангэрэл сайдаас уу? 8 дугаар микрофон өгье.

Б.Батзориг: Гишүүний асуултад хариулъя. Хойшлуулшгүй тохиолдлыг ямар эрх зүйн үндэслэлээр авч үзэж байна вэ? Хойшлуулшгүй тохиолдол гэж яг юуг авч үзээд байна вэ гэж. Эрүүгийн хэрэг хянан шийдэх тухай хуулийн 1, 4-ийн 1.27 гэсэн заалт байгаа. Хойшлуулшгүй тохиолдол гэдэг нь хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой аюул учрах, ноцтой хохирол учрах, мөн түүнчлэн сэжигтэн, яллагдагч этгээд нь оргон зайлах, мөн түүнчлэн гэмт хэргийн ул мөр, гэмт хэргийн баримтыг устгах, нуух, тээвэрлэх, зөөвөрлөх, үрэгдүүлэх бодит нөхцөл байдал үүсэж болзошгүй энэ нөхцөл байдлыг л хуульд өөрөө хойшилшгүй тохиолдол гэж заасан байгаа. Цагдаагийн байгууллагын хувьд хоногт дунджаа, Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулж байгаа 101, 102, 103, 105 гэсэн энэ тусгай дугаарууд дээр хоногт дунджаар 7-8 мянган удаагийн хандалт ирдэг юм байна лээ. Үүнээс цагдаагийн байгууллагын 102 тусгай дугаарын утсан дээр 4300 орчим удаагийн хандалт ирдэг.

Үүнээс бодит яг цагдаагийн байгууллагын алба хаагч очих шаардлагатай гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй байж болзошгүй 2000 орчим дуудлага мэдээлэл дээр алба хаагч нар өдөр шөнийн 24 цагийн хугацаанд үүрэг гүйцэтгэж, очиж үүрэг гүйцэтгэж байгаа. Энэхүү нөхцөл байдал дээр зайлшгүй. Өмнө нь гэмт хэрэгт холбогдон шалгагдаж байсан, сэжиглэгдэж байсан нэр бүхий тухайн хэргийн нөхцөл байдал өөр байна. Хоёрын хоёр хэрэг бүртгэлийн дугаар бүхий хэрэгтэй холбоотой байж болзошгүй хүмүүстэй холбоотой, дахиад шинээр гэмт хэргийн шинжтэй ийм тохиолдолд, дуудлага мэдээлэл ирсэн тохиолдолд хуульд зааснаар нотлох баримтыг үрэгдэх, устгах, зөөвөрлөхөөс сэргийлэх зорилгоор л энэ ажиллагаа хийгдсэн гэж ойлгогдоно. Хариулж дууслаа.

Надад ирсэн мэдээллээр 3 хүн, 3 хүнийг шүүгчийн захирамжаар цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ хийгдсэн гэсэн мэдээлэл ирсэн байгаа. 3.

Д.Цогтбаатар: Алтанхуяг гишүүний микрофоныг өгье.

Н.Алтанхуяг: Чи Батзоригоо эртээр чи бас энэ манай Байнгын хороон дээр ирж мэдээлэл өгсөн байхгүй юу. Чи одоо ингээд хүн юм асуугаад яг энэ хэрэг дээр яагаад хойшлуулшгүй нөхцөл байдал гэж юу үүссэн юм гэхээр манайд төчнөөн хэрэг ирдэг гээд. Чи надад тэр хуулийн заалт уншиж өгдөг хүн биш. Би тэр хуулийг чинь өөрөө бичилцсэн хүн учраас би мэдээд, асуугаад байгаа юм чамаас. Та нар

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

энийг юу гэж ойлгоод, яг энэ тохиолдолд яаж хэрэглэчхээд байгаа юм бэ гэж би өөрөөс чинь асуусан шүү дээ.

Хоёрдугаар асуулт нь бол тэр 8 залуу гээд байгаагаас чинь 3-ын шоронд хийчхээд байгаа юм уу, 1-ийг нь шоронд хийчхээд байгаа юм уу? Би ойлгохгүй байна. Тэрийгээ тодорхой хэлээдэх. Яагаад 3 болчихсон юм? Яагаад 1 болчихсон юм?

Д.Цогтбаатар: 8 дугаар микрофон өгье.

Б.Батзориг: Бас нийтэд мэдээлэх боломжтой гэж үзсэн хэмжээнд 3 хүнийг гэж мэдээлэл ирсэн байгаа. Яг ямар 3 хүн гэдгээ тодорхой мэдээлэл алга байна. Эргээд танд шаардлагатай бол эргээд танд мэдээлэл өгье гэж.

Д.Цогтбаатар: 4 дүгээр микрофон. Нарантуяа гишүүний микрофоныг өгье.

Г.Нарантуяа: Алтанхуяг гишүүний асуултад бас тодруулга хэлье. Тэгэхээр Эрүүгийн хуулийн 1.4-д бол хойшлуулшгүй ажиллагаа гэдэг үндсэн 3 тохиолдлыг л заасан байгаа шүү дээ.

Нэгдүгээрт нь гэмт хэрэг үйлдэгдэж байгаа хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хор хохирол учруулж байгаа, хоёр дахь нь сэжигтэн, яллагдагч оргон зайлж байгаа, гуравдугаарт нь эд мөрийн баримт устгах ийм тохиолдол үүссэн тохиолдолд бол хойшлуулшгүй ажиллагааг явуулна гэсэн ийм агуулгыг хуульчилсан байгаа.

Тэгэхээр хойшлуулшгүй ажиллагаагаар аливаа этгээдийг саатуулахад үндэслэл нь маш тодорхой байх ёстой. Хүний эрхийн Үндэсний Комисст авагдсан баримт бол ямар зүйлийг илтгэж байна вэ гэхээрээ саатуулахдаа ямар үндэслэлээр саатуулж байгаагаа тухайн хүмүүс мэдээгүй байсан нь өөрөө халдашгүй, чөлөөтэй байх эрхийг зөрчсөн гэж дүгнэх үндэслэл болж байгаа юм шүү.

Ер нь хойшлуулшгүй ажиллагаа явуулах ёстой, Цагдаагийн байгууллага үйл ажиллагаагаа зохистой явуулах ёстой, Монгол Улс гэмт хэрэгтэй тэмцэж чаддаг ийм тогтолцоотой байх ёстой.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Лодойсамбуу гишүүний микрофоныг өгье. Тэгээд ингээ нээрээ Лодойсамбуу гишүүний микрофоныг өгөхөөс өмнө би нэмээд энд орж ирсэн гишүүд бас 3 хүнд энэ юунд ороогүй ч гэсэн би 3 хүнд асуулт асуух эрхийг өгье. Яагаад гэвэл хоцорч орж ирсэн. Манай Байнгын хорооны гишүүд биш, тэгэхдээ цаг гаргаад энэ асуудал дээр ороод ирж байгаа учраас асуудлын ач холбогдлыг бас бодолцоод 3 хүнд асуулт асуух боломж олгоно.

Лодойсамбуу гишүүний микрофоныг.

Ч.Лодойсамбуу: Манай төрийн энэ бүүр юмыг аргалах гээд л, зальдах гээд л, тойрох гээд л, бултах гээд л байдаг ийм яг одоо харагдаж байгаа. Noorog.mn-ний тухай ярьж байхад тэр 8 залуугийн тухай ярьж байхад юун 3 хүний баривчилгаа яриад байгаа юм бэ Цагдаагийн дарга? Мэдээллээ судалж орж ир л дээ. Бид нарт өгсөн мэдээллээр, одоо авсан мэдээллээр энэ дээр бас Хууль зүйн

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

сайд тодруулаад хариулаад өгөөрэй. Noorog.mn сайтад ажиллаж байсан 1 хүн хоригдсон.

Хоёдугаарт тэр тоног төхөөрөмжүүдийг шалгахын тулд, гэрчээр байлцуулахын тулд тэр хүмүүсийг авч явсан болохоос саатуулаагүй гэж хэлээд байгаа юм. Тэр залуучууд гарч ирээд л хэлсэн шүү дээ. Тэр өрөөнд байхаас нь хойш тоног төхөөрөмжөө дахиж хараагүй, бүр юу аваад явсныг нь ч мэдээгүй, жагсаалтыг нь одоо хүртэл үзүүлээгүй. Орж ирээд худлаа мэдээлэл өгөөд байгаа юм. Нэндүгээрт.

Хоёрдугаарт, ер нь бол ингээд ийм худлаа аргалах гэсэн тайлбаруудыг сонсоод энэ энэ бол их тийм онцын юм биш. Би одоо шууд дүгнэлт хэлэх гэж байгаа юм. Би өөрөө энэ сэтгүүл зүйд бас улс төр, нийгэмд нөлөө бүхий контент хийж байсан өөрөө ийм дарамтуудад өчнөөн өртөж явсан. Зүгээр пост оруулсныхаа төлөө цагдаад дуудагдаж явсан хүний хувьд, бодлоо бичсэнийхээ төлөө дуудуулж явсныг энийг мэдэж байна. Энэ бол юу болсон бэ гэхээр яг тэр Noorog.mn-ийн залуучуудын хийсэн нэвтрүүлгийг л үзье гэсэн манай Ерөнхий сайдын гэр бүлийн багийнхан. Тэгээд үзэх гээд тэр даалгаврыг нь цагдаагийнхан биелүүлэх гэж оролдсон гэж би бодож байгаа. Тэгээд төхөөрөмжүүдээ хураагаад, 8 залуутай нь цуг хамт хураагаад явангуут энэ Noorog.mn-нийг энэ залуучуудын дунд ийм нэр хүндтэй гэж ерөөсөө мэдээгүй, бодоогүй, өөрсдөө мэддэггүй байсан тийм сайт байдгийг.

Гэтэл залуучууд бүгдээрээ үздэг, дэмждэг л байсан. Ингээд явж байсан араас нь 1 гишүүн нь тийм хэрэгт хутгалдсан байж таараад ингээд дансны мэдээлэл гээд ингээд цаашаа хөврөөд явсан. Одоо ингээд нөхцөл байдал юу болж хувирч байна гэхээр энэ Алтангэрэл сайд л ерөөсөө энэ хэвлэл мэдээллийн энэ орчныг, энэ ардчиллыг ер нь байхгүй болгож байгаа юм шиг тал руугаа 1 хүн рүү чиглэсэн ер нь яг л баларчхаад байгаа юм шиг яваад байгаа юм. Үгүй шүү дээ. Би зүгээр дүгнэлт хэлж байгаа юм. Энэ бол энэ Ерөнхий сайдыг Ерөнхий сайд болсноос нь хойш эхэлсэн. Нямбаатар сайдын үед бүр энэ хэргийг зүгээр самбар тавьж байгаад хэргийн материалыг дэлгээд, задлаад ярьдаг. Хэрээс хэтэрсэн шүү дээ. Дараагийн сайд Энхбаяр дээр ч энэ үргэлжилж байсан. Энэ болохгүй зүйл өнөөдрийг хүртэл үргэлжлээд байна аа энийг ер нь Алтангэрэл сайд маань өөрөө ер нь юу гэж бодож байгаа вэ? Энэ өвлөгдөж ирсэн муу муухайг ер нь засъя гэсэн бодол байгаа юу? Энэ өвлөгдөж ирсэн буруу зүйлийг олж харж байгаа юу? Энийг л ер нь шийдье гэж Ардчилсан намаас бид нар бас энэ засагт нь ороод ажил хийж байгаа байлгүй дээ.

Д.Цогтбаатар: Алтангэрэл сайд хариулах уу? Алтангэрэл сайдын микрофоныг өгье.

О.Алтангэрэл: Лодойсамбуу гишүүний хөндөж байгаа шиг асуудал үндсэндээ цаашаа шийдвэрлэгдэх ёстой асуудал мөн үү? Мөн. Зарим зүйл дээр шууд хүлээн зөвшөөрөх ёстой. Сая бол энэ хүмүүсийг шалгагдаж байгаа хэрэг дунд цагдаагийн байгууллагаар гаргаж тавьсан үндэслэл нь, өөрөөр хэлбэл энэ чинь хэд хэдэн гэмт хэргүүдэд энэ субъектүүд ингээд тус тусдаа шалгагдаад байгаа зүйл нь бүтэн хамт олныг энэ зүйл ангиудаар шалгагдаж байгаа юм шиг харагдаж байсан учраас энэ эргэлзээг тайлахын тулд прокурорын зөвшөөрлийн хүрээнд 9.3 тэрбум төгрөг гэдэг мэдээлэл хэлсэн. Тэгэнгүүт энэ мэдээлэл нь эргэж

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

мушгигдаад бүтэн сайтыг нь харлуулах үйл ажиллагаа мэт болоод явчихсанд харамсаж байгаа.

Тэгэхдээ энэ мэдээлэл бол прокурорын зөвшөөрөлтэй, дээрээс нь бүгдээрээ ч хэлж байгаа үнэн тоо байсныг харсан байх. Харамсалтай нь таны хэлээд байгаа гол зүйл байгаа. Энэ үнэхээр хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдсан уу, үгүй юу гэдгийг бид нар явуулсан үйл ажиллагаа, энэ явуулсан үйл ажиллагаанд тавьсан хяналтаар тогтоохоос өөрөөр энийг тогтоох боломжгүй. Бид энд суугаад хэдийгээр манай Цогтоо даргын түрүүний хэлдэг үнэн. Энэ улсад ажиллах хяналтын хамгийн чухал том механизм ажиллаж байгаа боловч өнөөдөр хэргийн аль талын юм уу, үйл баримтаар энэ дүгнэлт өгөх бололцоо байхгүй ээ. Таны саяын хэлсэн үгэн дээр гарч байна. Энэ хүүхдүүд гарч ирээд тоног төхөөрөмжийг үзээгүй, хараагүй гэж хэлсэн гэж.

Нөгөө талаар энэ нэгжлэг хийсэн, үзлэг хийсэн үйл ажиллагааг хуулийн дагуу явуулсан гэж тайлбарлаад байгаа юм. Хэрвээ хуулийн дагуу явуулсан бол хөндлөнгийн гэрч байлгаж, энэ хүмүүсээр өөрсдөөр нь гарын үсэг зуруулж, протоколдож, видео бичлэгийг нь хийдэг. Энийг хийгээгүй явуулсан байх юм бол жинхэнэ таны саяын хэлсэн зүйл рүү явна. Тийм, өөрсдөө гэдэг субъектив байдлаар бид нар буруутгахгүй ээ. Өнөөдөр гэмт хэрэгтэй тэмцэж байгаа зүйлийг шалгагдаж байгаа хүмүүсийн үгээр шууд буруутгаад байдаг бол хэн нэгэн хэдэн жил энэ олон хүний нус нулимсаар тоглосон 1 этгээд гадаадаас мэдэгдэл хийнгүүт ингээд шууд буруутгаад хэргийн материалыг задлаад байдаг бол энэ үйл ажиллагаа явахгүй ээ.

Харин шалгах ёстой зүйл мөн үү? Мөн. Ингэж хэлсэн, ингэж явсан гэж байгаа энэ үндэслэлүүд нь шалгах ёстой зүйлүүд мөн. Тэр мөрдөн байцаалтынхаа протоколоор, нотлох баримтуудаараа нотлогдохгүй бол энэ өөрөө зөрчил мөн, цаашилбал гэмт хэрэг мөн. Ийм л үйл явдал байгаа.

Тэгэхээр тавьж байгаа хүсэлт бол хэрэгт буруутгагдаж байгаа буюу сэжиглэгдэж байгаа, шалгаж байгаа хүн бүх төрлөөр юу гэж ч хэлж болно. Энэ бол эрх чөлөө. Өөрийгөө хамгаалах эрхтэй Монгол Улсын иргэн хүн. Нөгөө талаар энэ цагдаагийн байгууллага чинь ингээд цаашдаа хэрэг түвгээ мөрдөх үйл ажиллагаагаа явуулах юм уу, үгүй юү? Гэмт хэрэгт мөрдөгдсөн хүн дээр ямар нэг ажиллагаа хийж болох юм уу, үгүй юү? Энэ талаас нь л би Хууль зүй, дотоод хэргийн сайдын хувьд гэмт хэрэгтэй тэмцэх үүрэгтэй Хууль зүй, дотоод хэргийн яамыг тэргүүлж байгаа хүний хувьд санаа, зовнил нь энэ дээр гарч байгаа шүү.

Д.Цогтбаатар: Лодойсамбуу гишүүний микрофоныг өгье.

Ч.Лодойсамбуу: Би маш тодорхой хэлсэн. Энэ цагдаа нарыг ерөөсөө шууд буруутгаагүй байна. Энэ цагдаагаар улс төрийн алхам хийлгэж байгаа Ерөнхий сайд, Засгийн газрын тухай ярьж байна. Энэ бас анхны тохиолдол биш гэдэг тухай баримт нотоор ярьж байна. Олон жил үргэлжилж байгаа. Энийг олон улсын байгууллагуудын үнэлэлт, дүгнэлт хүртэл хэлээд өгч байна. Манай дотоодын Хүний эрхийн Комисс нь хүртэл суучихсан хэлээд сууж байна шүү дээ.

За тодорхой асууя. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбоогүй гэж байна. Тэгвэл тэр төхөөрөмжүүд 14 терабайт файлыг 5 хоног хуулаад байгаа юм уу? Яасан үзэж дуусдаггүй юм? Задалж үзээд байгаа юм уу? Утсыг нь тоолоод байгаа

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

юм уу? Хэзээ өгөх юм? Тэнд нэг нэвтрүүлэг байгаа. Яагаад өгөхгүй байгаа юм? Юу гэж бодож байгаа юм энийг ер нь? Одоо энэ нь хэвлэл, мэдээлэлтэй холбоотой асуудал нь энэ л байна шүү дээ. Энэ файлаа л авмаар байна гээд байгаа шүү дээ.

Д.Цогтбаатар: Харин наадах чинь, ер нь Лодойсамбуу гишүүн ээ би түрүүн сануулсан одоо яг хэргийн юу руу энэ Их Хурлын юу чинь бол ингэж бас ордог механизм биш. Гэхдээ Алтангэрэл сайд энд тийм яг үнэн. Алтангэрэл сайд энд хариулах хүрээндээ, өөрийнхөө мэдэж байгаа хүрээндээ та хариулаад явчих.

О.Алтангэрэл: Энэ яг үнэндээ Ганбат гишүүн сая тэндээс задалчихсан юм чинь гэдэг үг хэлж байна. Прокурорын зөвшөөрлийн хүрээнд явж байгаа гэдгээ би дахиад хариуцлагатайгаар хэлье. Энэ мэдээлэл болгон прокурорын зөвшөөрлөөр хэрэглэж байгаа.

Тэр 14 терабайт гэдэг мэдээлэл жишээлбэл би мэдэхгүй, анх удаагаа сонсож байна. Энэ бэхжүүлэх ажиллагаа процессын дагуу яаж явж байгааг би мэдэхгүй. Таны тавьж байгаа шаардлагыг ойлгож байна. Ийм байх, ямар байх ёстойг нь ойлгож байна. Энэний талаар яриад эхлэх юм бол ёстой жинхэнэ хэрэг ярьсан болох гээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр нэг зарчмын байр суурийг би маш сайн түрүүн бүлгийн хурал дээр ч хэлсэн. Та хэлсэн. Ойлгож авч байгаа. Ер нь тэгэхдээ асуудал яаж эхэлсэн бэ гэхлээр яг таны хэлсэн шиг чи Ардчилсан намаас томилогдсон Хууль зүйн сайд байж байж энэ талаар яагаад мэдээлэл өгдөггүй юм, цагдаа нар чинь ингэхгүй байна, мэдээлэл өг гэж л асуудал эхэлсэн.

Мэдээлэл өгсний дараа яагаад мэдээлэл өгсөн юм гэж өрнөж байгаа. Ийм учраас ер нь таны зөвлөгөөг хүлээж авч байгааг хэлье.

Д.Цогтбаатар: Одоо тэгвэл ингээд 3 гишүүн юу яая. Өөрөө наадах чинь, өөрөө нэр чинь харин өөрөө бүртгүүлчихсэн үү? Тэгвэл Цэлмүүн гишүүний микрофоныг өгье. Цэнгүүн гишүүний микрофоныг өгье. Тэгээд Сандаг-Очир гишүүн, тэгээд Цогтгэрэл гишүүн.

С.Цэнгүүн: Энэ Noorog.mn сайтын залуусын тухайд өнөөдөр бид нар тэр хүмүүсийн зориг, зүрхийг цохож тэмдэглэх зайлшгүй шаардлагатай байна. Тэгэхээр сонгуулийн сурталчилгааны үеийн 18 хоногийг баримтжуулаад бүрэн хэмжээний баримтат кино хийх хэмжээний материалыг нь хүмүүс цуглуулсан. Энэнийхээ хажуугаар Засгийн газрын үйл ажиллагааг факттайгаар, баримттайгаар, хэн нэгний нэрийг шүүмжилж гутаахгүйгээр энэ хүмүүс 4 дэх засаглалын үйл ажиллагааг маш амжилттай хийгээд явж байсан юм.

Тийм учраас өнөөдөр хүмүүс энэ залуучуудыг Noorog.mn-ийнхнийг органикаараа дэмжиж байгаа юм. Бас хамгаалж байгаа юм. Энэ Noorog.mn сайтын залуучууд ямар ч талцал хуваагдал хүсээгүй. Энэ залуучууд бол эрүүл, саруул эрх чөлөөтэй улсад л амьдрахыг хүсэж байгаа юм. Тэр хүрээндээ хараат бусаар үйл ажиллагаагаа явуулахын тулд олон нийтээс санхүүжилтийг босгоод энэ баримтат киногоо хийе гээд ил зарлаад явсан. Энэ баримтат киногоо удахгүй нийтэд зарлах гэж байна аа гээд хэлэхэд хэдхэн хоногийн дараагаар хойшлуулшгүй ажиллагаа гэдгээр баривчилгаа болсон. Ийм баривчилгаа болчихсон байхад иргэн хүний хувьд, Их Хурлын гишүүний хувьд бид нар зүгээр хараад суугаад байж болохгүй.

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

Манай улсын Үндсэн хууль дээр байгаа манай нийгмийн үнэт зүйл маань энэ. Бид нар хэзээ ч энэнтэй эвлэрч болохгүй зүйл юм. Тэр утгаараа бид нар Нооргийн залуучуудаа хамгаалсаар байх болно.

Тэгэхээр 1 асуулт асуумаар байна. Энэ сонгуулийн 18 оны баримтат кино гээд бид нар ярьж байгаа юм. 1 зүйлс байна л даа. 24 оны сонгууль болохоосоо 2-3 сарын өмнө 37 хөтөлбөрийг тухайн үеийн эрх баригч нам, Монгол Ардын Намаас санаачлаад 658 тэрбум төгрөг гаргачихсан байнаа гэдгийг энэ Нээлттэй нийгэм форумаас тайлан дээр нь гаргаж өгсөн.

Тэгэхээр жишээ нь Noorog.mn сайтын гаргаж байгаа энэ баримтат кинон дээр, энэ тайлан дээр бичигдсэн байгаа шиг үйл ажиллагаануудыг системийг илчилсэн байвал яах вэ? Бид нар энэ киног үзэх боломж нь байгаа юу? Ер нь энэ үзэгчид, Монголын ард түмэн энэ кинон дээр юу гарч байгаа талаар харах уу? Харахдаа энэ кино, энэ тайлан дээр бичигдсэн байгаа тоо, төсөв, баримтуудыг, тэгээд хэрхэн энэ сонгуультай холбоотой үйл ажиллагаа явагдсан системийг илчилсэн байх юм бол бид нар энд улс төрийн хариуцлага нэхэж чадах уу гэдгийг Улсын Их Хурлын гишүүдээс бас асуумаар байна. Энэ асуудал чинь өөрөө хаашаа хөтөлж явах вэ гэвэл дараагийн байдлаар бид нар Сонгуулийн тухай хуулиа ахиж ярих шаардлагатай. Нооргийн залуучуудын зоригтойгоор хөндөж чадсан, хэний ч хөндөж чадаагүй зүйл энэ баримтат киногоор илчлэхийг тэд зорьж байгаа.

Тэгэхээр тэрийг ч гэсэн бид нар хамгаалах ёстой. Энэ киног зайлшгүй олон нийт үзэх ёстой. Харин миний айдас төрж байгаа зүйл бол энэ маань бүрэн эхээрээ материалууд нь одоо гарч ирж чадах болов уу? Тэр зүйлсийг гаргаж тавих зориг, зүрхийг нь мохоочхоогүй байгаа даа гэдгээс айж байна. Энийг бас асуумаар байна.

Д.Цогтбаатар: Алтангэрэл сайд хариулах уу? Одоо Алтангэрэл сайд л хариулна л даа наадхыг чинь.

О.Алтангэрэл: Нэг зүйлийг бас цохон тэмдэглэж хэлье. Улсын Их Хурлын гишүүдийнхээ асууж байгаа асуулт, санаа зовнил, анхаарал хандуулж байгаа байдлыг ойлгож байна аа, хүндэтгэж байна аа. Бид анхаарал хандуулах ёстой. Үнэхээр ийм зүйл болж байхад бид нар хүний эрх, эрх чөлөөг зөрчигдөхгүй байхыг, хэвлэлийн эрх чөлөө зөрчигдөхгүй байхыг хянах ёстой. Энэ байр суурийг хүндэтгэж байгаа шүү.

Гагцхүү нэг талд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаа учраас ингээд ийм тодорхой төрлийн асуудлууд дээр зарим зүйл нь тодорхойгүй, зарим зүйлийг нь хэлэх боломжгүй ийм асуудал байгаад байгаа шүү гэдгийг юуны түрүүнд онцолж хэлье.

Тэр кино гэсэн асуудал яриад байгаа яг үнэндээ тэр кино ямар агуулгатай, ямар юу байгааг мэдэхгүй байна. Гэхдээ үзлэг хийгээд хурааж авсан эд зүйл тоо ёсоороо байх ёстой. Энэ ерөөсөө эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тавигддаг наад захын стандартуудын нэг. Эндээс устах, алга болох, үрэгдэх ийм байдал ерөөсөө гарч болдоггүй хуулиараа энэ.

Мөрдөн шалгах ажиллагааны хамгаалдаг энэ Эрүүгийн хуулийн холбогдох зүйл, хэсгүүдэд ч гэсэн мөрдөн шалгах ажиллагааны тодорхой журам зөрчихийг

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

хэрэг эрүүгийн хэрэг болгоод хуульчлагдсан байдаг. Ер нь энэ эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж байгаа хүмүүс бол нэг талдаа хууль сахиулаад энэ хутганы ирэн дээр явдаг хүмүүс. Буруу алхахад л өөрсдийг нь яг энэ хууль дээр заачихсан хариуцлагууд байдаг учраас. Тэгэхээр энэ дээр тэр хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулахад ямар байдлаар контент алга болох, агуулга үгүй болох ийм юм явахгүй болов уу гэж бодож байна.

Тэгээд яг зүгээр Улсын Их Хурлын гишүүнийхээ хувьд хэлэхэд үнэхээр тийм сонгуулийн луйвар, булхай ийм зүйлийг илчилсэн юм байвал гараасай гэж бас хүсэж байна. Амаргүй сонгууль даван туулсны хувьд, олон удаагийн амаргүй сонгууль харсны хувьд үнэхээр манай тогтолцооны талаар болохгүй, бүтэхгүй зүйл байгаа бол тэр илчлэгдээсэй гэж яг хувь хүнийхээ хувьд байр суурийн хувьд хүсэж байгаа.

Д.Цогтбаатар: Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Түрүүн тэр Ганбат гишүүн энэ Их Хурал чинь яачихсан юм бэ гэж асууж байсан. Би энэ бол Их Хурлын гишүүд чинь яачхаад байгаа юм бэ гэж асуумаар байгаа юм. Үгүй тэгээд 1 хэргийг энд авчраад л ингээд л Засгийн газрын түвшинд, Их Хурлын түвшинд авчирч яриад л. Сая хэлж байна шүү дээ. Өдөрт хэдэн зуун мянгаараа л хэрэг гардаг шүү дээ. Тэгээд одоо яах юм Их Хурал ингээд 1 хэргийг авчраад ингээд энд, одоо сүүлдээ бүр хэрэг ярьдаг болох гэж байна шүү дээ. Хэргийн дотоод асуудал руу, нарийн ширийн асуудлыг ярьдаг болох гэж байна шүү дээ. Асуугаад байна шүү дээ.

Тэгээд прокурорын зөвшөөрлийн хүрээнд л сайд учирлаж тайлбарлаад байна л даа. Тэгээд энэ чинь их буруу жишиг тогтоож байна шүү дээ. Цаашдаа ингээд асуудлыг сенсац болгоод ингэчихвэл тэгээд Их Хурал Засгийн газрын түвшинд авч ярьдаг ийм байдал руу орох гэж байна шүү дээ. Яах вэ ойлгож байна хүний эрхийн асуудал зөрчигдсөн асуудал тэр талаас нь ярьж байгаа боловч сүүлдээ асуудал чинь өөр тийшээ хувирч байна шүү дээ. Тэгээд энэ чинь Их Хурлын гишүүд чинь үндсэн үйл ажиллагаа нь хууль тогтоох л үйл ажиллагаа шүү дээ. Та бид нарын баталсан, хууль тогтоогч нарын баталсан хуулийн хүрээнд л энэ мөрдөн байцаагч нар ажиллаж байгаа шүү дээ.

Тэгээд цаашдаа сая сайд хэлж байна шүү дээ. Энэ мөрдөн байцаах үйл ажиллагааг, хэрэг бүртгэлтийн үйл ажиллагааг хийж болох юм уу, үгүй юу? Хөндлөнгөөс нь нөлөөлөх гэж, нөлөөлөх байдал ч үүсэхийг үгүйсгэхгүй болж байна шүү дээ. Тийм учраас би гишүүдийгээ энэ их хууль тогтоох үндсэн үйл ажиллагаандаа л анхаарлаа хандуул. Хуралдаа суу. Хажууд чинь Төрийн байгуулалтын байнгын хороо 2 цаг, 3 цаг хүлээгээд ирц нь бүрдэхгүй байж байна. Тэгсэн хэр нь үндсэн үйл ажиллагаанаас гадуур улс төржсөн, энэ хэвлэлийнхэн ч сайхан овоо босгож өгөх юм. Босгосон овоон дээр нь сайхан улс төрч нар нь талцаж сайхан хуваагдаж алалцах юм даа.

Тийм учраас үндсэн үйл ажиллагаа дээрээ анхаарал хандуулж ажиллаач ээ. Хууль тогтоох, санаачлах, ажлын хэсэгт орж ажиллах, хэлэлцүүлэгт суух, хурал чуулгандаа суух ажилдаа л анхаарлаа хандуул. Тэрнээс энэ ажлыг чинь хийдэг байгууллага, хянадаг байгууллага, мөрдөн байцаадаг байгууллага, эрх бүхий байгууллагууд нь байгаа шүү дээ. Тэгээд эд нар яах юм? Үнэхээр хариуцлага

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

алдсан бол, хууль зөрчсөн бол хариуцлагаа хүлээх хуулийн заалт нь ч байж байгаа шүү дээ.

Тэгээд ингээд л Их Хурлын гишүүд нь урдуур нь орж ирээд л асуудлын жинхэнэ улс төржүүлнэ гэдэг чинь энэ л байх даа. Улс төржүүлж асуудлыг ингээд. Тэгээд цаашдаа хэрэг болгоныг ингээд Байнгын хороон дээр авчирч ярьдаг болно гэвэл энэ их л буруу жишиг. Энэ чинь хийдэг, хянадаг, мөрддөг, нотлох баримтыг нь бүрдүүлдэг бүгд сансгаар байгаа шүү дээ. Эрх бүхий хүмүүс нь байгаа шүү дээ. Тэгээд энийгээ л хий л дээ. Би асуулт алга байна. надад. Саналаа хэлье.

Д.Цогтбаатар: Цогтгэрэл гишүүний микрофоныг өгье.

О.Цогтгэрэл: Хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой асуудал яригдаж байна. Ер нь сүүлийн үед Монгол Улсад хүний эрх, эрх чөлөө, тэр тусмаа ардчилсан засаглалын индекс, үзүүлэлт унаж байгаа тухай, уруудаж байгаа тухай, доошилж байгаа тухай мэдээлэл сүүлийн 2, 3 парламент дамжаад л байнга л гардаг болсон. Гадаад олон улсын байгууллага нь ч тэр, дотооддоо байгаа нөхцөл байдал ч тэр. Тэгээд энэтэй холбоотойгоор энэ хуулийг, хэрэгжилтийг хангах ёстой, төрийн албатай холбоотой, төрийн алба хаагчидтай холбоотой, тодорхой асуудал хариуцсан байгууллагатай холбоотой асуудал дуусахгүй л байнга л гарч байна л даа. Ингээд 2, 3 тал, хэд хэдэн тал болоод л ярьдаг.

Би яг өөрт бас тохиолдсон гэх юм уу, асуудал болсон зүйлийн талаар бас энд тодруулга авах гэж байна л даа. Тэр юу вэ гэхээр сая 1 дүгээр сарын 10-нд улс орон даяар жагсаал болно гээд баахан юм боллоо. Жагсаал болох гэж байгаа юм гээд л баахан юм боллоо. Болж байгаа юм гээд л юм боллоо. Яг тэр үеэр надад бас ар гэрт гачигдал, бэрхшээл ч гараад л ийм байдалтай л байлаа. Тэгсэн ТЕСО жагсаал зохион байгуулах гэж байгаа, санхүүжүүлэх гэж байгаа гэж байгаа юм байна гэдэг мэдээ урд нь гараад л. Тэр яг тэр жагсаалынхаа өдөр нь ч билүү, хэзээ нь ч билүү жагсаал зохион байгуулсан, ТЕСО-гоос мөнгө авсан, ТЕСО-гийн хүмүүс ирж жагссан гээд бас баахан мэдээ бүүр нэртэй, хаягтай, эзэнтэй, биетэй баахан хүмүүс сошиалаар гарсан. Тэрний маргааш нь билүү, нөгөөдөр нь билүү, надтай холбоо бүхий компани жишээ нь нэр нь дурдагдаж байгаа компанийнх нь гомдол гаргасан байна лээ. Үнэн, зөв байвал энэ бүгдийг шалгаж өгөөч гэж.

Тэр чинь 1 сарын 10 гэхээр өнөөдөр 3 сарын 20 гэхээр лав л 2, 3 сар болчихлоо. Хариу байхгүй таг. Тэгэхээр энэний цаана ер нь энэ хуулийн байгууллага чинь дураа хүрэхээр хойшлуулшгүй ажиллагаа гээд л дуртай л юмаа хийдэг юм байна. Дургүйгээ хүрэхээр ингээд хэдэн сараар нь эзэнтэй, биетэй, нэртэй, устайгаа томоохон хэрэгт ингээд бие биеэ гүтгэхчээд тэрэнд нь гомдол өгөхөөр ингээд хариу байхгүй таг байж болдог. Энэ нэг л ийм жишээ, би ийм тохиолдсон жишээ л ярьж байна л даа. Би хэн нэгэн хүний энд тэндээс юм ярьсангүй.

Тэгэхээр тэр цагдаагийн байгууллагын удирдлага бас байх шиг байна Хууль зүйн сайдыг энэ ер нь яг ингэж байж болдог юм уу? Хоорондоо зөрчилдсөн 2 асуудал дээр энэ чинь аль нэгнийх нь буруу гэж гарч ирэх ёстой биз дээ? Нэг бол тэр жагсаал зохион байгуулсан юм бол мөнгө төгрөг хаанаасаа хаашаа шилжсэн юм, ямар нэртэй устай хүн нь хаанаасаа ирж тэр жагсаалд оролцсон юм гэдгийг нь нотлох баримттайгаар ингээд олон нийтэд нь тавиад тэр зохион байгуулсан бол бурууг нь дурдах ёстой байх.

Аль эсвэл энэ худлаа юм бол тэр нэртэй, хаягтай хүмүүс хэн нэгэн хүн буруу хүлээх ёстой байх. Тэрний цаана магадгүй захиалагч гэж байх ёстой байх. Аль эсвэл ингээд ийм тодорхой асуудал дээр энэ хуулийн байгууллага аль эсвэл ур чадвар нь хүрэхгүй байдаг ийм хэдэн сараараа мөрдөөд учир нь олддоггүй байдаг гэж би ойлгохгүй байна. Энэ дээр та болоод энэ цагдаагийн байгууллагын зүгээс хариулт өгөөч. Энэ бол бас өнөөдрийн яригдаж байгаа асуудалдаа тодорхой бас ингээд ийм нөхцөл байдлын хувьд бас.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Алтангэрэл сайд хариулт өгье.

О.Алтангэрэл: Цогтгэрэл гишүүний хувьд саяын ярьж байгаа нөхцөл байдал үүссэн. Бас ар гэрт нь эмгэнэлтэй явдал тохиолдсон. Уй гашуу тохиолдсон үед бүр ийм зүйл гарсан. Бид бол маш сайн мэдэж байгаа. Тэгээд нэр хаяг нь тодорхойгүй ийм хаягуудаас ийм мэдээллүүдийг яг тэр эмгэнэлтэй үед тарааж, цацаж, ингэж явсан ийм асуудлууд гарсан. Тэгээд албан ёсоор Цогтгэрэл гишүүн гомдлоо гаргасан. Бидний хувьд энэ гомдолд шалгах ажиллагаа ер нь хийгдэж байгаа юу, энэ үйл ажиллагаа чинь хуулийн дагуу явагдаж байгаа юу гэдэг энэ асуудлаар цагдаагийн байгууллагад хандсан. Тэгээд таны гаргасан гомдлын хүрээнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааныхаа талаар мэдээллийг журмынх нь дагуу танд өгнө гэсэн ийм хариу бол цагдаагийн байгууллагаас өгсөн байгаа шүү.

Тэгэхээр хариу өгөгдөнө гэж ойлгогдож байгаа. Ер нь яг үүнийг тохиолдуулаад хэлэхэд энэ цахим орчинд худал, илт худал мэдээлэл тарааж байгаа, энэ асуудлын илрүүлэхтэй холбоотойгоор зөндөө олон асуудал цагдаагийн байгууллагад бас тулгамдсан асуудлууд зөндөө байгаа. Өдөр ирэх тусам энэ чиглэлийн гомдол мэдээлэл ихсэж байгаа. Ингэж гүтгэсэн, ингэж худлаа ярьсан, энэ хаягаас ингэлээ гэдэг гомдол өдөр ирэх тусам ихсэж байгаа. Тухайлах юм бол залилах гэмт хэргийн хүртэл дийлэнх хувь нь цахим залилан болж ингэж хувьсаж байгаа.

Тэгэхлээр таны тавьсан асуудлын зүгээс гомдол гаргагч иргэний хувьд танд яг албан ёсны хариу өгөгдөнө гэж хариулъя.

Д.Цогтбаатар: Сая энэ Цогтгэрэл гишүүний асууж байгаа юм зөв шүү. Ингээд баахан дайрч дайрчхаад тэгээд ямар ч үр дагаваргүй чив чимээгүй болоод явчихдаг. Алтангэрэл сайд минь таны үед ийм юм зогсох ёстой шүү. Та заавал энэний хариултыг авч Цогтгэрэл гишүүнд өг. Тэгээд эзэн холбогдогчийг нь тогтооно. Наадах чинь их хүнд эд биш шүү. Яг үнэнийг хэлэхэд. Тэгээд тийм хүмүүс ингэж болдоггүй юм байна энэ чинь хуультай улс байна гэдгийг мэдрэх ёстой шүү.

Цогтгэрэл гишүүн тодруулах гэсэн юм уу? Цогтгэрэл гишүүний микрофоныг өгье.

О.Цогтгэрэл: Ингээд хэдэн сарын дараа ч гэсэн хариулт өгөх юм байна гэж ойлголоо. Тэгээд хариултыг нь аваад байр сууриа илэрхийлнэ.

Хамгийн гол нь энд өчүүхэн төдий ч холбоогүй гэдгээ мэдэж байгаа. Тэгээд сошиалаар баахан зохион байгуулалттай бараг 20, 30, 40 сайтаар зэрэг бичүүлээд, үүний дараа, тэгээд холбоогүй гээд та холбоогүй байсан юм байна гээд

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

тэгээд хохироод өнгөрөх ёстой юу? Нөгөө талд нь баахан эзэн биетэй хүмүүсийн чинь 2, 3 зохион байгуулалттай маргааш нь билүү маск зүүчихсэн эмэгтэй, эрэгтэй хүмүүс баахан хүмүүс л юм ярьж л байсан, харагдаж байсан.

Тэгээд тэр бүхэн дээр тэгээд тодорхой байр суурь илэрхийлээд явах боломж олдох байх гэж бодож байна. Энд бол ямар ч холбогдолгүй гэдгээ мэдэж байгаа учраас надад бас их илүү их тийм эмзэг байна л даа. Ингэж ийм зохион байгуулалттай юм хийж болдог жишиг тогтчихсон байгаа нь энэ өөрөө маш их эмзэг байна.

Д.Цогтбаатар: Одоо гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Би аль болох нээлттэйгээр хаачихсан хойноо ч гэсэн гишүүдэд асуулт асуух боломж олголоо шүү.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү.

Лодойсамбуу гишүүнээр тасаллаа. Номинчимэг гишүүний микрофоныг өгье.

О.Номинчимэг: Баярлалаа. Өнөөдөр Улсын Их Хурлын гишүүд бүгдээрээ уг нь мэдэж байгаа бид 1 тодорхой хэргийн мөрдөн шалгах ажиллагаанд бас хөндлөнгөөс оролцоод баймааргүй байна. Нийгмийн талцалыг бас өдөөмөөргүй байна. Улсын Их Хурлын гишүүдийн хувьд бол ажил үүрэгтээ ухамсарлаж жоохон хариуцлагатай хандмаар байна. Хэлж байгаа үг, мэдэгдлүүд гарч байна.

Тэгээд бид нарын хувьд юу хийх ёстой юм бэ гээд тэгэхээр ер нь бид нар нийгмээ харахаар ингээд маш их талцдаг болчихсон. Нэгдүгээрт 1 сэдэв гаргаад ирнэ. Үнэн, худал нь мэдэгдэхгүй тэгээд бид нарын хэлж байгаагаар сошиал троллууд байдаг юм уу, сэвэлтүүд их хийдэг болчихсон. Энэ дунд иргэд угаасаа их төөрөгддөг болчихсон. Иргэд байтугай Улсын Их Хурлын гишүүд ч гэсэн энд өөрсдөө төөрөгдөлд ороод явдаг болчихжээ. Энэ кэйс ч гэсэн бас энэний 1 жишээ гэж бодож байна. Яах вэ өнөөдөр бол бид Хүний эрхийн Комиссын гишүүний дүгнэлтийг сонслоо. Ер нь нөхцөл байдал бүгдээрээ бид нар сая 10 гаруй хоногийн, 10 орчим хоногийн хугацаанд дүгнэлт хийлээ. Процесс дээр бас алдаа байна, ойлгомжгүй, тодорхойгүй зүйл байна гээд. Энэ дээр Алтангэрэл сайд бол энэ цагдаагийн албаны албан хаагчдынхаа ур чадварыг дээшлүүлэх энэ дээр бас анхаарах ёстой.

Хэрвээ энэ улс төрийн зорилготой ийм асуудал болсон энэ бол бид нарын хувьд ч гэсэн тэвчишгүй асуудал. Үүнийгээ мөрдөн шалгах ажиллагаагаа хийгээд үнэн мөнийг нь гараад ирэхээр энэ цаашаа үргэлжлэх асуудал гэж харж байгаа.

Яг бид нарын хувьд хараад дүгнэхэд энэ гишүүд бас ингээд хөндөж байна л даа. Янз бүрийн асуудал гаргадаг, тэгээд баахан дайрдаг, сошиал дээр ялладаг, ер нь сошиал энэ сэвэлт байдаг юм уу, тролл байдаг юм уу үүгээрээ буруутан хүн ч буруугүй энхийн цагаан тагтаа шиг болоод, ямар нэгэн буруугүй хүн ч маш муухай хүн болох ингээд харагддаг л болчихоод байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ дээр Улсын Их Хурал бид нар ард түмнийхээ элч төлөөлөгчийн хувьд юу хийх ёстой юм бэ? Энэ сошиал дээрх худал мэдээллийг цацдаг энэ асуудал дээрээ бид нар яаж хандах ёстой юм бэ? Хууль, эрх зүйн орчноо яаж

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

анхаарах ёстой юм бэ гэдэг дээр уг нь анхаармаар байна. Бид нарын лессон лөрнт/lesson learnt/ буюу эндээс авч гарах дүгнэлт, диалоги хийгээд энийгээ шийдэх асуудал ийм гэж харж байгаа. Тэрнээс нэгнийх нь гэр бүлийн гишүүн нь ийм болохоор киноны асуудал чинь энэ бол энэ цаг хугацааны хувьд, мөрдөн шалгах ажиллагааны хувьд гараад ирэх асуудал. Энэ дээр битгий манай Улсын Их Хурлын гишүүд ул суурьгүй хандаж ингэж нийгмийг дэвэргэх юм хийгээч гэж бодож байна.

Үнэхээр тийм кино байгаа бол би ч гэсэн үзмээр байна. Бүгдээрээ л энийг үзмээр байгаа. Энэ улс төрийн санхүүжилт, намын санхүүжилтийн асуудал бүгдээрээ бид нар олон удаа ярьж байгаа. Энэ дээр шинэчлэл хийх гээд ч гэсэн өмнөх Улсын Их Хурал бас ажиллаж байгаа. Энэ дээрээ зөвхөн Ардчилсан намын гишүүд нь санаа зовоод л, бид нар санаа зовохгүй байгаа юм ерөөсөө биш. Бүгдээрээ адилхан энийгээ шийдье, асуудал нь энэ юу вэ гэж байгаа. Харин үүн дээр гишүүд маань ажил хэрэгч хандаасай гэж хүсэж байгаа. Тэгэхээр энэ дээр гишүүд маань бас анхаараач гэдэг юмыг хэлмээр байна.

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Би Ноорог гээд ерөнхий тэр малгайн дотор шалгагдсан тэр залуучуудыг Үндсэн хуульд заасан өөрсдийгөө аливаа гэмт хэрэгт шалгагдсан ч өөрийгөө өмгөөлөх гэдэг юм уу, хамгаалах тэр эрхийг нь хүндэтгээд янз бүрийн коммент хэлмээргүй байна.

Гэхдээ төрийн байгууллагууд энэ дээр нь дагаж үймдэг, дагаж үймүүлэхдээ ямар ч эмх цэгцгүйгээр бужигнаж эхэлдэг. Би гадуур явж байгаад орж ирээд авагдсан мэдээллийн хүрээнд л анх мэдээлэл өгөөд буруу, зөрүү ярьчихсан юм гээд яриад сууж байдаг байж болохгүй. Манай цагдаагийн байгууллага бас энийгээ ойлгох хэрэгтэй. Би энэ бас салбарт бас 10 хэдэн жил ажилласан. Мэдээж сайнтай, муутай зөндөө юм байдаг. Бид алдаагаа уг нь давтахгүй засаад л явах ёстой асуудал. Тэгээд би бас Хууль зүйн сайдын мэдэгдэл дунд 1 зүйлд л харамсаж байгаа юм. Цагдаагийн байгууллагад итгэхгүй учраас би гарч мэдээлэл хийгээд баларчихлаа гээд байгаа байхгүй юу. Би Ардчилсан намаас томилогдсон сайд учраас би өгсөн юм гээд. Та Монгол төрийн сайд, Ерөнхий сайд таныг томилсон, Ардчилсан нам биш шүү. Та төрийн сайд хуулиа биелүүлэх ёстой.

Тэгээд цагдаагийн байгууллагад итгэхгүй учраас би гарч мэдээлэл хийж байгаад алдчихлаа уучлаарай гээд байгаа байхгүй юу. Тийм байж болохгүй шүү. Цагдаагийн байгууллага ажлаа хийх хэрэгтэй. Энэ алдаагаа давтахгүй байх ёстой. Өнөөдрийн нийгэмд яригдаж байгаа шиг буруу зүйл байвал тэр албан тушаалтанд хариуцлага тооцоорой. Сая тэгээд бас яах вэ Цогтгэрэл гишүүн хэлж байна би бас гүтгүүлээд, би ч бараг сүүлийн 6 сар бас гүтгүүлж байна. Хятадаараа дуудуулаад 280 мянгаа Хятад оруулж ирэх гэж байгаа гээд. Энэ Засгийн газрын тусгай элч буюу хийн хоолой хариуцсан БЭТ юм уу даа тэр нөхөр гүтгээд байгаа юм. Худал мэдээлэл тарааж байгаа Алтангэрэл сайд аа, цагдаагийн байгууллага аа. Тэх тэгэхээр энэ хүнийг би мэдээлэл өгвөл бас ийм хурдтай шалгачих юм шиг байна тээ? Би бас тэгж бодоод ер нь өгье гэж бодож байна шүү.

Тэгэхээр ийм зүйлүүдээрээ ингээд царай харахгүй шүү. Би бас Ардчилсан намын бас журмын нөхөд энд сууж байгаа Лодойсамбуу гишүүндээ хэлмээр байна. Та бас баримтаа гаргаад тавьчих. Ерөнхий сайд энэ мэдээлэл, кино үзье гэсэн

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

учраас авсан юм байна. Нийгэмд хэдүүлээ ингээд улс төрийн оноо хожоод, харин тийм бодож болно. Тэгэхдээ тэгсэн юм байна лээ гээд хэлсэн. Та үгээ бас эргээд хар. Тэгэхээр хэдүүлээ ингэе хаа хаанаа зарчим ярьж байгаа бол зарчим. Тийм учраас энэ баримтаа гаргаад тавьчих. Эцсийн дүндээ эрх барьж байгаа намууд хэн бэ? Монгол Ардын нам биш шүү. Ардчилсан нам, ХҮН нам байж байгаа. Бүгд 1 завин дээр яваад эрх барьж байж одоо ийм инээдтэй юм ярьж болохгүй.

Тийм учраас Алтангэрэл сайд бас одоо залуу хүний хувьд яах вэ та бас ийм байна. Ер нь бүлэглэлийн гар, хөл битгий болоорой. Өөрөө ч тэрийгээ хэлээд байгаа шүү дээ. Яах вэ Женкотой холбоотой. Үнэн шүү дээ чиглэлийг нь өгч байгаа нь энэ биз дээ? Энэ харлуулаадах бүх муухай юмыг хийж байгаа биз дээ? Тэгчхээд өөрөө хүртэл энийгээ улаан цагаан мэдэгдэж байгаа шүү дээ. Баавартай байгаа юм аа бас зарим талаараа.

Тэгэхдээ одоо ном журмын дагуу, зарчмын дагуу ажиллах ёстой шүү. Цагдаагийн байгууллагын өмнүүр эд нар новшийн амьтад учраас би мэдэгдлийг нь хийсэн гэж энэ хамгийн хариуцлагагүй мэдэгдэл шүү. Хөөе та яриагаа хар. Тийм учраас цагдаагийн байгууллага хаана хаана анхааръя. Алтангэрэл сайд хууль номыг нь сайжруулах ажлаа түргэн шуурхай хийе. Улсын Их Хурал энэ дээр нь шийдэх юм байвал шийдээд өгье. Ийм л ном журмаар явахгүй бол одоо ийм сэдвийг дагаад нийгмээ бухимдуулдаг, талцуулдаг, сүүлдээ энэ нийгэм чинь ерөөсөө ингэж аймаар их хүнд байдалтай байна сэтгэл зүйн хувьд. Тэгээд хэдүүлээ бас тэгээд зарчмаа яривал ярих ёстой байхгүй юу. Баярлалаа Лодойсамбуу.

Д.Цогтбаатар: Ганбат гишүүний микрофоныг өгье.

Д.Ганбат: Ер нь манай Монгол Улсыг чинь тэгээд дүгнэчихсэн л байна лээ шүү дээ тэр Вертас демократи /Varieties of Democracy/ гэдэг байгууллага. Авторитар засаглалтай болчихжээ. Дарангуйлал тогтож байна аа гээд. Энэ хараат бус байгууллага дэлхийн хэмжээний байгууллага тогтоочихсон л байна л даа. Тэр Пакистан, Афганистан энэ тэртэй хавьцаа явж байна л гэхихсэн байна лээ шүү дээ. Одоо ийм л болчихоод байна. Тэрний нэг илэрхийлэл нь энэ хэрэг юм уу даа. Тэгээд энэ Засгийн газар, энэ манай Хууль зүй, дотоод хэргийн яам, би ганцхан Алтангэрэлийг буруутгах гээгүй байна, энэ систем, энэ цагдаа, энэ прокурор ямаршуухан ажиллаж байгаа вэ гэдэг нь харагдаж байна л даа. Баг нь хууларч байна, ард түмэн харж байна.

Гэхдээ ямар ч байсан 30-аад жил ардчилсан замаар замнах гэж оролдсон, явж байгаа энэ улс орны нүүр царай энэ хэдэн залуучууд болж байна. Энэ залуучууд өөр болсон байна шүү. Бас энэ Хүний эрхийн Үндэсний Комисс ч гэсэн дүгнэлтээ гаргачихсан байна. Нарантуяа ирээд энийгээ уншиж байгаа нь их сайн байна. Бас бага ч гэсэн итгэл найдвар төрүүлж байна. Яаж ажиллаж байна вэ гэхээр ерөөсөө хүн нь байвал зүйл анги нь олдоно. Ямар ч хүнийг ямар ч зүйл ангиар буруутгаж чадах нь. Энэ чинь хэдэн өдөр дараалаад тэр зүйл анги нь өөрчлөгдөв өө. Тэр хойшлуулшгүй үйл ажиллагаа явуулах шаардлагагүй байна гэсэн ийм утга агуулга Хүний эрхийн Үндэсний Комиссоос гаргаж ирж байна шүү дээ.

Бас нөгөө талаар амралтын өдрөөр 10 цагаас өглөөний үүр цайтал эрүүдэн шүүсэн гэж үзэж болохоор байна шүү дээ. Ингэж л ажиллаж байна. Тэр тоног

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

төхөөрөмж, тэнд байгаа мэдээлэл хэний дургүйг хүргээд байгаа юм бэ? Ямар их айдастай байх юм бэ энэ улсууд. Улсууд ч биш л дээ. Энэ Их Хурал, энэ Засгийн газар. Юунаасаа айгаад байгаа юм. Хэвлэн мэдээлэх, үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэхэд чинь Үндсэн хуулиар олгосон. Тэр байтугай хүн төрөхдөө дагаж төрдөг жам ёсны эрх шүү дээ. Тэрийг нь зөрчиж байна. Нэгэнт ийм болчихсон юм чинь уул нь бол энэ Засгийн газрыг түдгэлзүүлээд, сайд нь түдгэлзээд, тэр Цагдаагийн ерөнхий газрын дарга нь түдгэлзээд, тэр кибер гэмт хэрэгтэй тасгийг удирдлагыг нь түдгэлзүүлж байгаад шалгах ёстой. Тэр мөрдөн байцаах үйл ажиллагаа бол халдашгүй л байх ёстой шүү дээ.

Гэтэл яагаад энд оролцоод байгаа юм бэ? Хууль зөрчигдөөд байна. Зүгээр хажуу талаас нь харахад. Хуулийг дээдэлдэг, хуульд захирагддаг ийм юм байхгүй болоод байгаа юм биш үү гэсэн ийм эргэлзээ ард түмний дунд төрж байна. Энд л дургүй хүрээд байна шүү дээ. Ингэж чадах уу, чадахгүй юу? Ингэж хийвэл бага ч гэсэн итгэл сэргэх байх. Тэгэхгүй бол энэ ард түмний итгэл, олон түмний харж байгаа, үзэж байгаа юм бол ямар ч итгэх, найдах ийм юмгүй болчихоод байна. Ёстой шалаар дүүрэн болчихлоо шүү дээ энэ Их Хурлын, энэ Засгийн газрын байж байгаа байдал. Энийг ойлгох цаг болсон байна.

С.Эрдэнэболд: Эрдэнэболд гишүүний микрофоныг өгье.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын зарим гишүүд байр сууриа илэрхийлж байгаа бусад гишүүнийг илтэд шүүмжлэх, хэлсэн үгийг нь мушгин гуйвуулах ийм хандлага ажиглагдаж байгаа. Улсын Их Хурал бол өөрөө хууль тогтоох, дээд эрх хэрэгжүүлэгч байгууллага. Нөгөө талаасаа хяналтын чиг үүрэгтэй. Зарим гишүүний хэлээд байгаачлан энд Монгол Улсын бүх хэргийг тэгвэл татаад авчраад шүүх, цагдаагийн өмнүүр ороод ярихгүй яасан юм бэ гэдэг ийм гуйвуулсан асуулт асуугаад байгаа юм. Үгүй л дээ. Бид өнөөдөр суурь зарчмын тухай асуудлыг ярьж байгаа юм. Монгол Улсын Үндсэн хууль ноцтойгоор зөрчсөн байж болзошгүй. Тэр дундаа хүний эрх, эрх чөлөө, магадгүй эрүүдэн шүүх процесс явагдсан байж магадгүй. Улмаар аливаа хүнийг Үндсэн хуулийн дагуу шүүхээс гэм буруутайг нь эцэслэн тогтоогдоогүй байхад улс төрийн зорилгоор тодорхой сэдэл бүхий байдлаар хэрэг тохож байж болзошгүй юм гэсэн хардалтуудын үндсэн дээр хүмүүс байр сууриа илэрхийлж байгаа.

Тийм учраас энд бол Их Хурлын гишүүдийн үг, үзэл бодлоо илэрхийлэх, ард иргэдийг төлөөлж хууль тогтоогчийн байр сууриа хуулийн дагуу илэрхийлэх зүйл дээр цензурдэх боломжгүй юм гэдгийг бас хэлье.

Хоёрдугаарт нь бол энэ мэдээж энэ хэрэг бол процессынхоо шатаар явж байгаад шүүхээр шийдэгдэх юм уу, ямар нэгэн байдлаар ингээд үр дүнд хүрэх байх. Гэхдээ нөгөө талд нь иргэдэд, ялангуяа залуу үед ямар айдас байгаа вэ гэхлээрээ үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, жагсаал цуглаан хийх энэ асуудал чинь сүүлийн үед бол асар том дээсэн дөрөөн дээр орчхоод байна. Үзэл бодлоо илэрхийлэнгүүт тэр хүний хувийн амьдралыг нь ухдаг, ямар нэгэн ноотоо зүйлийг гаргаж ирдэг, эс үгүй бол бий болгодог. Улмаар тэр хүнийг нийгмийн адгийн шаар мэтээр үзүүлээд, үзэн ядагдах тэр нөхцөл байдал шахаанд оруулангуутаа улс төрийн зоригийг нь мохоодог. Улмаар үзэл бодлоо илэрхийлэх тэр эрхийг нь хязгаарлах гэсэн энэ халдлагууд явж байгаа. Энэ хэргийг зүгээр хэрэг гэж бодохоосоо илүүтэйгээр энэ дээр байр сууриа илэрхийлсэн гишүүдийн зургийг эвлүүлээд, ямар нэгэн компанийн санхүүжүүлсэн, нэр хоч өгсөн, хэн нэгэн

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

улс төрч байсан хүмүүсийн төлөөлөл болгож гарч ирж байгаа мэтээр эвлүүлгүүдийг зохион байгуулалттайгаар санхүүжүүлж хийсэн нь бол харагдаж байгаа. Энэ дээр бид нар ямар ямар хэвлэлүүд, ямар ямар цаг үеүдэд гаргасан гэдгийг нь ч мэдэж байгаа. Монголын ард түмэн тэнэг биш, залуу үе тэнэг биш, тархи угаах мессеж болон бодитой үйл хоёрыг ялгаж харж байгаа.

Хууль зүйн байнгын хороонд Улсын Их Хурлын 22 гишүүн байдаг. Хүний эрхийн дэд хороонд 9 гишүүн байдаг. Хаа очиж энэ Хууль зүйн байнгын хорооны дарга Дамдины Цогтбаатар гишүүнийг бид нар бас үнэлэх хэрэгтэй. 11 сарын хорьдоор тэр эрүүдэн шүүхийн эсрэг тэр сонсголыг зохион байгуулсан. Араас нь ингээд Байнгын хорооноос шийдвэр гараад, ажлын хэсэг гараад явж байгаа. Хүний эрхийн асуудал дээр улс төржихгүй байгаа, намчирхахгүй байгаа. Ингэж ажиллаж байгааг нь бид нар сайшаах ёстой байхгүй юу. Тэгэхээр ер нь бол цаашдаа энэ хүний эрхийн асуудал дээр битгий улс төржөөч л гэж хэлэх гэж байгаа юм.

Яагаад гэхлээр энэ хүний эрхийн асуудал дээр улс төржөөд л, намч байр сууриас гараад байхаар бид нар дундын үнэт зүйлээ хуваагаад байгаа юм. Тэр Үндсэн хуулийн эсрэг үйлдлүүдийг өөгшүүлээд байгаа юм. Хүний үндсэн эрх, заяамал оршихуй, тэр эрхэмсэг чанарыг бид нар хуулийн буулгаар үгүй хийх гээд байгаа юм. Гишүүдийн хэлээд байгаачлан яагаад тэгвэл хэргийг нь татаж ирээд вэ гэхлээр яах арга байхгүй цагдаа ч гэх юм уу, Хууль зүйн сайд ч гэх юм уу өөрсдөө улс төржиж гарч ирж мэдэгдэл хийгээд байгаа шүү дээ. Ингээд хүмүүсийн итгэл үнэмшлээ чөлөөтэй илэрхийлж байгаа байр суурь руу нь талцал, хуваагдлын мессежийг өөрсдөө хаяад байна шүү дээ.

Тийм учраас энэ дээр хаа хаанаа бодох ёстой л гэж бодож байна. Энэ бол зөвхөн 1 хэргийн асуудал биш. Сүүлийн үед зүй тогтол болоод байгаа асуудал. Өнөөдөр ямар нэгэн байдал талаар шүүмжилсэн хүн шууд маргааш нь хараар бодогдож байгаа. Одоо энэ Энхбаяр гишүүн энэ хажууд сууж байна. Та 1 үг хэлээд л маргааш нь улсын дайсан болоод.

Д.Цогтбаатар: Дамдинням гишүүний микрофоныг өгье.

Г.Дамдинням: Бид нар энд Монгол Улсын Их Хурлын хийх ёстой ажлыг л хийж байгаа. Монгол Улсын Их Хурал хууль баталдаг. Хуулийнхаа хэрэгжилтийг нэхээд л энд сууж байгаа шүү дээ. Хэрэг яриад байгаа юм юу ч байхгүй шүү дээ энэ чинь. Хүний эрхийг хамгаалсан хуулийн хэрэгжилт ямар байгаа юм бэ гэдэг асуудал яриад байгаа болохоос хэрэг яриад суугаад байгаа асуудал байхгүй шүү дээ. Монголын хэвлэл, мэдээллийг, Монголын залуучуудыг, шинэ үеийг айдсаар удирдах гээд байгаа юм уу гэдэг асуудлыг л ярьж байгаа шүү дээ. Ардчилал, хүний эрх, чөлөөтэй зах зээлийг хамгаалахын төлөө л бид нар энд ажиллана гэж ардчилсан Монгол Улсын парламентын гишүүн болоод сууцгааж байгаа шүү дээ энэ чинь. Тэр ажлаа л хийж байна. Парламентын гишүүдийг юу хэлсэн, хэлээгүйгээр нь шүүмжилж хоорондоо дайралцах бол бидний үндсэн ажил. Эмзэглээд байх ч юм байхгүй, баярлаад байх ч юм байхгүй. Үзэл бодлын зөрүүгээ ярих гэж л энд сууж байгаа зарчмын байр сууриараа. Тэгэхээр энэ дээр их асуудал болоод байх юм байхгүй байлгүй дээ л гэж бодож байна.

Үндсэн асуудлын тухайд бол Noorog.mn-ийн кэйс гэж цаашдаа ер нь яригдах биз дээ бодвол. Энэ бол 1 сайтын асуудал бол ерөөсөө ч биш. Энэ шинэ үе үзэл

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

бодлоо чөлөөтэй илэрхийлэх зоригтойгоо үлдэх үү, үгүй юу гэдэг асуудал байхгүй юу.

Тийм учраас орж ирж ярьж байгаа юм би. Би Хууль зүйн байнгын хорооны гишүүн биш. Би тэгэхдээ ардчилалд итгэдэг. Ардчиллын үнэт зүйлд хайртай ийм л хүн. Хуулийг сахиулж яваасай гэж бодож, зүтгэж яваа. Намчирхаад байгаа ч юм алга. Буруу байвал Хөдөө аж ахуйн сайдыг барьж аваад нүдэж явсныг та нар харж л байсан байх. Зөв байвал Ардчилсан намаас томилогдсон Хууль зүйн сайдыг, төсвийг нь батлуулах гээд бүх гишүүдийг тойроод гарын үсэг зуруулаад гүйж л явдаг. Хуулиа зөрчөөд байгаа бол уучлаарай харин. Хайр байхгүй шүү найзууд аа.

Монголчуудыг монголын ард түмнийг худал гүтгэлгээр хэвлэлийн мэдээгээр дарангуйлж байгаад хэрэг үүсгээд хэрэг нь байвал ял нь байдаг юм аа гэдэг шиг, хүн нь байвал ял нь байдаг юм аа гэдэг шиг хандлагаар хандаж нэгдлийн улаан бух царайлцаагаад байвал уучлаарай. Ийм хүний эрх, ийм хүний, ийм Хууль зүйн сайд, ийм цагдаагийн байгууллага гэж юу байдаг юм, ийм парламентын гишүүд ч гэж юу байдаг юм. Юугаа хийгээд сууцгааж байгаа юм бид нар энд. Ярих ёстой шүү дээ. Маргаашаас бодвол тэгээд гүтгэдэг сайхан ах нар нь, нөгөө бүлэглэлийн эсрэг гээд манай Хууль зүйн сайд яриад байна лээ. Бүлэглэлийнх нь, өөрийнх нь бүлэглэлийн толгойлогч бодвол тэгээд л баахан хаяг тавиад л тавьцгаах байлгүй дээ. Тэрний, энэний, тэр нам, компанийн, энэ намын, энэ бүлэглэлийн, энэ фракцынх гээд л тавих биз. Тавьж л байхгүй юу. Айгаад байх юм алга. Энэний эсрэг л зогсож байгаа шүү дээ.

Тийм учраас би зориуд хэлж байгаа юм. Энэ үйл ажиллагаанаас хэд хэдэн үр дүн харагдаад байгаа байхгүй юу. Гэмт хэргийн шалгаж байгаа материалд задардаг. Энэ байдлыг болиулмаар байна. Энэ Энхбаяр, манай энэ Б.Энхбаяр Хууль зүйн сайд байхдаа хамгийн эхний өгсөн үүрэг даалгавар нь энэ гэмт хэргийн материал битгий задлаарай гээд нэлээн чанга явж байсан юм. Одоо тэр нь хаана байгаа юм? Хаанаасаа ч энэ мэдээллүүд нь гараад байдаг юм. Энийг болиулмаар байна шүү дээ Хууль зүйн сайд аа. Зөв ажлыг чинь дэмжинэ, буруу ажлыг чинь дэмжихгүй. Хатуу шүүмжилнэ.

Эцэст нь тэгээд энэ хууль эрх зүйн өөрчлөлт хийх ёстой бол оруулж ир Засгийн газар. Бид нар ч гэсэн гишүүд бас энэ дээр ажиллая. Процессын хуулиудад нь алдаа байгаа бол энэ дээр нь ярья. Бид нар хийх ёстой юм юу байна гэдгээ л харж энд ярьж байгаа шүү дээ. Монголын залуу үе, ардчилалд хайртай ард иргэддээ хандаж хэлэхэд бие биеэ өмөөрөөрэй. Ардчилалдаа хайртай байгаарай. Мэдээллийн ил тод байдал гэдэг бол таны эрх чөлөөний асуудал шүү гэдгийг дахин хэлье. Баярлалаа та бүхэнд.

Д.Цогтбаатар: Лодойсамбуу гишүүний микрофоныг өгье.

Ч.Лодойсамбуу: Дамдинням гишүүнтэй санал нэг байна. Энэ бол зүгээр 1 гэмт хэрэг, хэрэг л ярьдаг боллоо, зүгээр л ингээд л явж байгаа юмыг улс төржүүлээ. Ерөөсөө тийм биш л дээ. Тийм бишийг нь мэдээд манай Хууль зүйн байнгын хорооны дарга Цогтбаатар гишүүн өөрөө санал гаргаад Хууль зүйн байнгын хороогоор байх ёстой хүмүүсийг нь байлгаад, бусад Байнгын хороондоо байхгүй гишүүдийг суулгаад хэлэлцүүлж байгаад талархаж байна. Яг ийм хэлэлцүүлгийг бид нар маш олон хийх ёстой. Төр яах гэж байдаг юм. Иргэнээ хамгаалах гэж л байдаг. Талцуулж байна гээд байгаа. Одоо бид нарын энэ

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

хандлагаасаа засах ёстой юм нь юу вэ гэхээр бид нар бүгдийг улс төр болгож хардаг. Угаартаж хүн нь нас барчихлаа гээд эмгэнэнгүүт битгий улс төржөөд бай. Гэр бүлээрээ нас барчхаад байна гээд хүүхэд нь уйлангуут тэр мэдээллийг дарах гэж оролддог л ийм л Засгийн газартай шүү дээ бид нар. Одоо ингээд хэвлэл, мэдээллийн байгууллага бүр хамаг юмаа хураалгаад, 1 нэвтрүүлэг хийсэн биш ийм юм болж байгаа юм биш үү гээд ярихаар, парламентын гишүүд нь ярихаар улс төржөөд байна аа, нийгмийн асуудал болгоод байна аа, талцуулаад байна аа гээд. Энэ талцуулдаг багаа бид нар буруу хараад байна. Энэ талцуулдаг баг чинь би одоо нэр ус хэлээд яах вэ. Монголчууд бүгдээрээ мэдэж байгаа шүү дээ. Хав харанхуй болгож байгаа шүү дээ энэ нийгмийг, энэ улс төрийг түнэр харанхуй болгож байгаа шүү дээ. Сошиалыг ер нь хэн удирдаад байгаа юм? Манай улс төрчид нэг юмыг андуураад байгаа юм. Ард түмэн ийм юм бодож байна гээд фэйсбүүк/facebook/ ухаад, таймлайн/timeline/-аа харангуутаа монголчууд масс нээрээ ийм юм бодоод байна энд итгээд байна гэж бодоод байгаа. Бид нар энэ сошиалыг давж нийгмээ ч олж харахаа байтлаа сохорсон шүү дээ. Сошиалыг тэгж удирдаж бид нарын нүдийг хааж байгаа шүү дээ. Тийм хүмүүс засгийг толгойлж байгаа шүү дээ. Тийм гэр бүл засгийг толгойлж байгаа шүү дээ.

Тэгээд ингээд тэр асуудлыг нь ярьсан хүмүүсийг улс төржлөө, талцууллаа гээд байдаг. Тэр хүмүүс чинь монголын цагдаа нар монголын иргэдийг хооронд нь зодолдуулаад байна шүү дээ тэр хүмүүс. Цагдаагийн даргыг хэн тавьдаг юм? Ерөнхий сайдын санал болгосноор Их Хурал томилдог биз дээ? Тийм болчихсон биз дээ? Одоо энэ болж байгаа асуудлууд дээр тэгээд хэнтэй нь хариуцлага ярих юм? Ерөнхий сайд, Засгийн газартай ярихгүйгээр хэнтэй ярих юм цагдаатай холбоотой асуудал? Өчигдөр лайв/live/ хийсэн залууг манай Хууль зүйн сайд бас жишээ татаад байна. Тэр дээр нь бас хэлье. Одоо ингээд энэ Засгийн газрын өмнө маш том даалгавар бий боллоо. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын хэлж байгаа тоогоор бол энэ мөрийтэй бооцоот тоглоом Монгол Улс 500 сая ам.доллар гадагшаа гаргачихсан юм байна гэдэг тоо гаргаад ирсэн. 9 тэрбум нь 1 дансаар орсныг бид нар харлаа. Тэр дунд Цагдаагийн албан хаагч сард 75 сая төгрөгийн цалин авдаг байсан тухай ярилаа. Энийг шалгах байх. Энэ юуг хэлж байна гэхээр тэр 500 сая доллар, ам.долларын зүгээр 9 тэрбум төгрөгийнх нь асуудал л ил гарлаа. Энэний цаана энэ 500 сая ам.доллар-ын мөрийг мөшгөхөд энийг ер нь илрүүлж шийдэх л ёстой шүү. Энэ том л юм гарна. Ер нь хууль хүчний байгууллагын тусламжгүйгээр ийм төрлийн хуулиар хориотой гэмт хэргүүд явах боломжгүй гэж би боддог.

Д.Цогтбаатар: Баярлалаа.

Би хэдэн зүйл хэлнэ. Үг хэлэх гишүүд үгээ хэлээд дуусаж байх шиг байна. Тэгэхлээр өнөөдөр энэ хурал явж байгаа гол шалтгаан ямар учиртай вэ гэхлээр энэ шалгалтын ажилд садаа болох гээгүй харин тус дэм болох гэж байгаа юм. Юу гэвэл олон нийт энэ асуудалд итгэхгүй байгаад байна. Тэгтэл энэ хууль, хяналтын байгууллага олон нийтийн итгэлгүйгээр энэ хяналт шалгалтынхаа ажлыг явуулах маш хүндрэлтэй болно.

Тийм учраас энд ил авчирч, бид нар энэ асуудлыг яг хүний эрх талаас нь түүнээс хэргийн талаас нь биш шүү, хүний эрх талаас нь хэвлэлийн эрх чөлөөтэй энэ дандаа Үндсэн хуулийн асуудал. Ноорог гэдэг тэр сайтын тухай асуудал ерөөсөө биш. Энэ ерөнхий том утгаар нь бид нар хөндөж энэ Байнгын хороон дээр ярьж байгаа юм шүү. Тийм ч учраас би энэ саналыг даргын дэргэдэх, Их Хурлын

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

даргын дэргэдэх зөвлөл дээр асуудлыг тавиад, тэндээс дэмжлэг аваад, энийгээ ингээд хэлэлцээд явж байна.

Тэгэхлээр ийм ерөнхий хүний эрхийн асуудал дээрээ Их Хурал хэнтэй ч хуваалцахгүйгээр бид нар хяналтаа тавина. Хэргийн дотоод юу руу сая зүгээр зарим гишүүд маань явцад дунд ороод байна. Би тэн дээр нь сануулж хэлсэн шүү дээ. Хариулахгүй байж болно шүү. Энэ рүү зарим гишүүд маань мэдэхгүй асууж байж болно тэрэнд хариулахгүй байж болно.

Энд би юу хэлэх гээд байна гэхлээр Алтангэрэл сайдад ч, Хүний эрхийн Комисс, цагдаадаа ч гэсэн хандаж нэг юм хэлмээр байна. Үндсэн хуулиараа Монгол Улсын иргэн халдашгүй дархан эрхтэй. Юуны чинь Их Хурлын гишүүний дархан эрх. Тэр биш шүү. Монгол Улсын иргэн дархан эрхтэй. Тэр дархан байдал нь Үндсэн хуулиараа хамгаалагдсан. Тэрийг нэвтэлж орохын тулд үнэхээр тэр жишээлбэл хойшлуулшгүй ажиллагаа явагдаж байгаа бол маш нарийн шалгуурууд тавиад өгчихсөн байгаа шүү дээ. Зөвхөн тэр хүрээнд л орох ёстой.

Тэгэхлээр саяын энэ яригдаж байгаа Их Хурал дээр бид нар Байнгын хороон дээр ярьж байгаа асуудлууд чинь тэр хэнийг яасан бэ тэрийг ерөөсөө, жинхэнээсээ яриагүй. Энд яригдаж байгаа асуудал чинь хэвлэлийн эрх чөлөө рүү сая энэ халдсан байна уу? Зорилго чинь яг хэргийг илрүүлэх байна уу, хэвлэлийг айлгах байна уу гэдэг дээр л хамгийн том үндсэн ялгаа гараад ирж байгаа юм. Аливаа хуулийн хэрэгжилт дээр интент гэж байдаг. Тэр зорилго бүхнийг шийдэж байгаа юм. Тэгээд энэ гишүүдийн асуугаад байгаа чинь би нийгмийн итгэл маш чухал аа гэдэг чинь энийг л хэлж байгаа юм. Тэр зорилгод чинь хүмүүс итгэхгүй байгаа тохиолдолд та нарт харин бид нар ийм зорилготой, ийм ийм факттай гэдгийг чинь олон түмэнд ярьж өгөх тэр боломжийг чинь бид нар гаргаж өгч байгаа юм. Тэр үүднээсээ хэргийн юунд бид нар хажуугаас оролцоогүй шүү. Хууль зүйн байнгын хороо ийм зорилго ч урдаа тавиагүй. Тэгээд энэ иргэний халдашгүй эрхээ ямар ч төрийн байгууллага тэр дотроо Их Хурал ямар ч том дарга нь анхаарч явах ёстой шүү.

Хүний эрхийн Комиссыг харин мөрдөн байцаах ажиллагаанд оруулдаг болох энэ хуулийг би санаачилна гээд Хүний эрхийн Комисстой яриад явж байгаа. Эд нар орж болдоггүй. Одоо ингээд амьдрал өөрөө шаардаад оруулаад ирж байна шүү дээ. Яах аргагүй эд нарын бас оролцоо хэрэгцээтэй байгаад байгаа.

Тийм учраас энэ хуулийг ойрын хугацаанд яах аргагүй энийг дөрөөлж оруулж ирнэ. Энэ дээр нэг зүйлийг хэлэхэд энэ ахиад л энэ Нооргийн тухай асуудал биш гэдгийг би юугаар хэлж байгаа гэхлээр энэ дээр ийм асуудал гарч байгаа юм чинь цаана нь хэчнээн олон асуудал дээр ийм зөрчил гарсан байж болзошгүй вэ гэдгийгээ л бид нар бодолцож, холбогдох байгууллагууд дээрээ энэ дээрээ анхааралтай ажиллаарай. Бид нар кэйс болгон дээр хүрч ажиллаж чадахгүй. Тэгэхдээ 1 энэ дээр байгаа бол цаана 10 байж болзошгүй гэж л иргэдийнхээ эрх ашгийг хамгаалж ярьж байгаа юм шүү.

Тэгээд цагдаагийн байгууллагадаа нэг зүйлийг харин хэлмээр байна. Энэ 1 бус удаа яригдаад байна. Батзориг дарга аа энийг та анхаараад авчхаарай энэ хар аа нэгэнт тэнд компьютер эд нарыг нь хураагаад авчихсан байгаа бол та нар тэгээд шалгаж байгаа байх. Буцаагаад олгохдоо тэндээс 1 ч баримт гээгдээгүй байх ёстой шүү. Угаасаа хуулиараа ч тийм. Энэ дээрээ та нар анхаарч үзээрэй

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

дээ. Дараа нь нөгөөдүүл чинь манай 1 тийм баримт байхгүй болчихсон байна, ингэчихсэн байна, энэ дээр засвар орсон байна гэвэл наадах чинь өөрөө бие даасан асуудал болж гарч ирнэ шүү.

Тэгэхлээр энэ дээрээ цагдаагийн байгууллага маш хяналттай ажиллаарай. Тэгээд төр, иргэдийн хоорондын итгэл байж байж л хууль хэрэгжинэ. Үл итгэсэн орчинд хууль хэрэгжихгүй шүү гэдгийг та нар яаж ч хуулиар далайлгаад хууль ингээд зөв юм гээд иргэд итгэхгүй байгаа бол хууль хэрэгжихгүй гэдгийг л та нар маань бодож ажиллаарай гэдгийг хэлэх гэсэн юм.

Ингээд өнөөдөр энэ мэдээллийг, энэ сүүлийн үед гараад байгаа асуудалтай холбогдсон мэдээллийг Хууль зүйн сайдаас авлаа.

Нээрээ энэ дээр нэг зүйлийг хэлмээр байна. Хууль зүйн сайдаас авахдаа бид нар энэ удаа бол цагдаагийн байгууллагаа дуудаагүй шүү. Хууль зүйн сайд өөрийнхөө эрх мэдлийн хүрээнд цагдаагийнхаа байгууллагыг байлцуулъя гэсэн учраас бид нар хүлээн зөвшөөрөөд байлцуулж байгаа.

Түүнээс цагдаагийн байгууллагыг энд авчраад Их Хурлын гишүүдээр асуулгах гээд хэрэв эндээс ямар нэгэн тийм дарамталсан шинж чанар илэрсэн бол зөвхөн тэрийг тэр асуултын хүрээндээ яагаарай. Хууль зүйн байнгын хороонд ийм ямар ч зорилго байхгүй. Та нар ажлаа хийдгээрээ хийх ёстой.

Би хэвлэлийнхэндээ хандаж нэг зүйлийг хэлмээр байна. Хэвлэлийн эрх чөлөөний тал дээр Хууль зүйн байнгын хороо Монгол Улсын Их Хурал хөдөлшгүй хатуу Үндсэн хуулийнхаа байр суурь дээр байгаа. Сэтгүүлчид юунаас ч айхгүй хэлэх үгээ хэлээд явж байх эрхтэй шүү гэдгийг би энд онцлоод хэлмээр байна.

Тэгээд энэ асуудлыг сонсож дууслаа. Дараагийн асуудалдаа оръё. Шинээр батлагдсан дэгийн дагуу, ирж оролцсон ажлын хэсгийнхэндээ талархал илэрхийлье.

18.56 цаг

Дэгийн дэс дарааны дагуу 2 дугаар асуудлаа, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 03 дугаар дүгнэлтийг хэлэлцэх асуудалдаа оръё.

Энэ асуудал маань батлагдсан. Миний түрүүн яг дэс дараагаараа явъя гээд байдаг яг л энэ байхгүй юу. Одоо гишүүд маань энэ улс төрийн өндөр юутай асуудал дээр орж ирчхээд бид нар Үндсэн хуулийн цэцийн асуудал одоо яг ингээд өнөөдөр эцсийн хугацаанд байхгүй юу. Батлах гэхлээр гишүүд маань гараад явчихсан байна. Манай Хууль зүйн байнгын хороо гишүүн нь биш юм чинь Хууль зүйн байнгын хорооны гишүүд хуралдаа орж ирэхийг би урьж байна. Энэ Төрийн байгуулалтын байнгын хороонд 2 гишүүн орчихсон байгаа. Тэр 2 гишүүн, 4 гишүүн орчихсон байж байгаа юм байна.

Тэгээд 4 гишүүн санал хураалт дуусаад орж ирэх байх. Бас тэд нарыгаа хүлээх хэрэгтэй болж байна. Одоо энэ асуудал руугаа орох гэхлээр тийшээ орчихсон гишүүд маань яг танилцуулах, тэгэхлээр харин тийм Номинчимэг гишүүн тийшээ орчхоод байгаа юм. Ер нь хэдүүлээ хэлэлцээд л явж л байя.

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 03 дугаар дүгнэлтийг гишүүдэд тараасан байгаа. Цэцийн дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Номинчимэг гишүүнээс асуулт асуух гишүүд байна уу? Асуулт асуух гишүүн тийм. Асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгчих. Тэгээд Номинчимэг гишүүн орж ирнэ шүү дээ. Энд яг юун дээр байж байгаа тийм.

Энхбаяр гишүүнээр тасаллаа. Тэгээд Номинчимэг гишүүнийг оруулж ирэхлээр, аан Эрдэнэболд гишүүнээр тасаллаа. Асуу асуу асуулгүй яах вэ. Тэгээд Номинчимэг гишүүнийг орж ирэхлээр хурлаа үргэлжлүүлье. Одоо ингээд түр орж иртэл завсарлаадахъя.

Харин тийм. Шууд асуулт хариулт руугаа ороод явчихъя. Номинчимэг гишүүнээс, Эрдэнэболд гишүүний микрофоныг өгье. Асуулт.

С.Эрдэнэболд: Номинчимэг гишүүн ээ одоо энэ чинь Цэц дээр жишээ татаж ярихад жишээлбэл сая 24 оны сонгуулиар ингээд тойрог томроод 3 аймаг ч юм уу 1 болоод ингээд явангуут гишүүд болохлоороо өөр өөрсдийнхөө хэвлэмэл материал, сэтгүүлийг тараагаад сонгуулийн үеэр сурталчилгаа хийсэн гэдэг асуудал тийм үү? Цэц энэ дээрээс жишээлбэл юу яачихлаа шүү дээ зөрчсөн байна аа гэдэг болчихлоо шүү дээ. Та Их Хурал төлөөлж энийг бол зөрчөөгүй байна аа гэдгийг хамгаалахаар орсон байгаа тийм үү? Тэгэхээр ерөнхийдөө бол яг та энэ дээр гол гол аргуудыг нь хэлж өгөөч. Сая жишээлбэл бид нар яасан гэхлээр би жишээлбэл өөрөөрөө бодоход Төв аймаг дээр бэлдэж явж байгаад тэгээд Дархан, Сэлэнгэ ороод 5 дугаар тойрог гээд ингээд болчихсон. Тэгэнгүүт Их Хурлын яг бодит амьдрал дээр бол Их Хурлын гишүүн хүмүүс бол сонин хэвлэл тараагаад тэгээд бүр тэгж ярих юм бол Засгийн газрын үйл ажиллагааг танилцуулна гэдэг байдлаар ингээд явчихсан. Тэгэнгүүт яасан бэ гэхлээрээ Ардчилсан нам бүлгийн зөвлөхүүд гээд бас бас тэгээд бүлгийн мэдээлэлд танилцуулна гээд алив шулуухан хэлэхэд бол тийм ковер хийгээд явчихсан байхгүй юу. Тэгэхээр одоо энэ ингээд цаашлаад яаж явах юм бэ? Одоо энэ дээр та гол нь гол аргуудыг хэлээч. Өөрөөр хэлбэл, Цэц дээр гаргасан гол гол аргуудыг танилцуулаач гэж хүсье. Тэгээд 1 тодруулах юм байгаа юм. Хариултынх нь дараа.

Д.Цогтбаатар: Номинчимэг гишүүний микрофоныг өгье.

О.Номинчимэг: Яах вэ энэ Цэцийн дүгнэлт дээр байгаачлан Улсын Их Хурлын гишүүний хувьд сонгуулийн жил эхэлснээс хойш 1 сарын 1 энэнээс нэр дэвшүүлэх ажиллагаа хүртэл байдаг юм шүү дээ тээ. Энэ хүртэл бол Улсын Их Хурлын гишүүний хувиараа хийсэн ажлынхаа тайланг тарааж байгаа нь, тарааж иргэд, сонгогчидтой уулзалт хийж байгаа нь ерөнхийдөө Үндсэн хууль зөрчсөн гэдэг дүгнэлт Цэцээс гарчхаад байгаа.

Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгчийн хувьд гол аргумент юу байсан бэ гэхээр Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч, төлөөлөгч. Тэндээс 4 жилийн хугацаатай мандаттай сонгодог хүн. Энэ хүн Улсын Их Хурлын гишүүний төлөөлөх, хууль тогтоох, хянан шалгах энэ чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд заавал энэ ардчилсан парламентын энэ зарчмын дагуу иргэд, сонгогчидтойгоо эргэх холбоотой ажиллаж хийсэн ажлаа тайлагнаж, ингэснээр ард түмэн маань Улсын Их Хурлын гишүүн өөрсдийн элч төлөөлөгчөөрөө дамжуулж төрийн эрхийг барина гэсэн энэ Үндсэн хуулийн суурь зарчим маань биелэх ийм боломжтой байгаа юм.

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

Улсын Их Хурлын хуулийн 8 дугаар зүйл дээр бас Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх бол тангараг өргөснөөс эхлээд дараагийн Улсын Их Хурал бүрэлдсэнээр энэ чинь бүрэн эрх нь дуусаж байгаа. Энэ бүрэн эрхийн хүрээнд юу байх вэ гэвэл Улсын Их Хурлын гишүүн өөрийн иргэд, сонгогчдодоо мэдээлэл өгөх бол өөрийнх нь бүрэн эрхийн асуудал.

Тэгэхээр энэ бол зөвхөн сонгуулийн жил эхэлсэн үү, үгүйгээс хамаарахгүйгээр бүтэн сонгогдсоноосоо хойш дараагийн хугацаа нь дуусах хүртлээ энэ үүрэг бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байгаа. Цэц яах вэ энэ дээр 3 ийм үндэслэлээр бол энэ зүйл, заалтуудыг Үндсэн хууль зөрчсөн байна гээд үзчихэж байгаа. Энэ зүйл, заалтууд маань нэгдүгээрт, тодорхой биш, ойлгомжгүй байна гээд байгаа. Тэрний яг гол аргумент нь яах вэ, энэ дээр Цэцийн дүгнэлт дээр ингээд зарим параграф эд нартай санал нийлэх, нийлэхгүй юм зөндөө байгаа. Яг мэтгэлцээний, ам мэтгэлцээний үеэр дурдсан тайлбарууд, Сонгуулийн ерөнхий хорооноос экспертийн хувьд авсан дүгнэлтүүд, учир шалтгаан нь бол зөндөө олон юм дурдагдсан.

Гэхдээ энэ дүгнэлт дээр ерөөсөө ороогүй. Энэ дүгнэлт дээр ерөнхийдөө Цэцийн гишүүд өөрсдийнхөө байр сууриас хандаад нэг талын юугаараа мэдээллүүдээ оруулаад явчихсан байна гэж би бас харж байгаа. Гол 3 үндэслэлээр энийг хүлээн зөвшөөрөхгүй ээ, Цэц Үндсэн хууль зөрчсөн гэж байгаа юм нь бол нэгдүгээрт энэ Улсын Их Хурлын гишүүний хувьд хийсэн ажлын тайлангаа сонгуулийн сурталчилгааны материалаас ямар ялгаатай байх нь хуулийн зохицуулалт байхгүй, тэгээд ойлгомжгүй байгаа нь Улсын Их Хурлын гишүүн тайлан тараах нэрээр сонгуулийнхаа сурталчилгааг хийх боломжийг бүрдүүлчихсэн байна.

Тэгэхээр гол мэдээлэл гаргагчаас ч гэсэн хэлж байгаа нь окэй тайлан тараах, мэдээллээ өгөх тэр иргэд, сонгогчидтой уулзах окэй. Тэр бол байх ёстой юм. Гэхдээ тэндээ хийж байгаа тэр мэдээлэл, тайлан чинь яг хийсэн ажлын хүрээнд байх юм уу, яг ямар шалгууртай байх юм бэ гэдэг ямар ч зохицуулалт байхгүй болохоор үүнийг Улсын Их Хурлын гишүүд буруугаар ашиглаад, илүү өөрийгөө дараагийн сонгуульд орох нэр дэвшигчийн хувьд сурталчлах ийм ажиллагаа болгоод байгаа.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Гүйцээгээд хариул хариул. Наадах чинь чухал асуудал ярьж байгаа шүү үнэхээр.

О.Номинчимэг: Ийм байгаа учраас энэний тэр тайлангийн агуулга нь юу байх юм, хэлбэр нь юу байх юм, хэмжээ, хязгаар нь юу байх юм, юу хийж болохгүй юм, ямар мэдээлэл тусгаж болохгүй юм гэдэг энэ асуудал ерөөсөө орхигдчихсон байгаа. Ерөнхий байгаа учраас энэ болохгүй байна аа гэдэг аргументыг хэлсэн.

Нөгөө талаараа энэ сонгуулийн тухай хуулийн 48.1 дээр ерөнхийдөө хууль бус сурталчилгааны асуудал байгаа. Тэгээд хууль бус сурталчилгаа буюу иргэд, олон нийтийн сонгогчдыг татах зорилгоор ийм ийм зүйлийг хийж болохгүй гээд. Сонгуулийн ерөнхий хорооноос зөвхөн энэ зүйлийг л 1 сарын 1-нээс сонгуулийн жилийн 1 сарын 1-нээс хориглосон. Энд бол бусад хүмүүстэй уулзуулаад дүүргийн иргэдийг дуудаад ингээд уулзалт зохион байгуулах, тухайн гишүүн биш хүн бол уулзах боломж нь нээлттэй байгаа гэдэг тайлбарыг өгсөн. Үнэхээр ч хуулийн зүйл,

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

заалтаараа тийм юм байна лээ. Энэ дээр зүгээр 1 аргумент нь иргэн хүн, гишүүн биш хүн ажлын тайлан тарааж болох юм уу гэдэг асуулт байсан. Ажлын тайланг яах гэж тараах юм, иргэд сонгогчдын гишүүн биш, сонгогдоогүй субъектийн хувьд бол яах вэ гэхээр сонгуульд зориулж л тараах байх аа. Тэгэхээр боломжгүй энэ иргэд сонгогчдын саналыг авах зорилгоор сонгуулийн сурталчилгааны компанит ажил эхлээгүй байхад энэ ажлыг эхлэх эхлэл болно гэсэн.

Тэгэхээр энэ дээр Цэцийн гишүүд нэлээн ноцтойгоор хандаж, тэгээд цахимаар тараах юм бол окэй юм уу, эсвэл хэвлээд тараах юм бол энэ эд хөрөнгө тараасан гэдэг хэрэгт орох юм уу? Яахаараа Улсын Их Хурлын гишүүн өөрийгөө таниулах ажлын тайлангаа, хийсэн тайлангаа танилцуулж болоод, жирийн иргэд болдоггүй юм гэсэн энэ аргументыг нэлээн тавьсан байгаа.

Хоёрдугаарх нь бол яг эндээс үүдэн гарсан тэгш бус байна аа гэж байгаа. Тэгээд иймэрхүү байдлаар зохицуулсан нь ер нь бол Улсын Их Хурлын гишүүн хүн тэгш юу, энгийн иргэн хүн сонгуульд горилогч хүний хувьд тэгш бус байдлыг үүсгэжээ гэсэн асуудал байгаа.

Гуравдугаарт бас ялгаварлан гадуурхсан байна аа гээд. Тэгэхээр яах вэ, нэлээн нарийвчилсан гаднын зөвлөмжүүдийг дурдсан асуудлууд байгаа. Зүгээр миний харж байгаагаар бол энэ эхний тэр тодорхойгүй байдал, нарийн зохицуулалт байхгүй асуудал нь Улсын Их Хурлын гишүүний байх ёстой заавал иргэддээ тайлагнах ёстой процессыг тэр чигээр нь байхгүй юм шиг ийм эцсийн дүгнэлтэд оруулсан. Тэгэхээр энийг яах вэ бид нарын хувьд хууль тогтоомжийн хүрээнд бас харах боломжтой юм гэж харж байгаа.

Д.Цогтбаатар: С.Эрдэнэболд гишүүн тодруулъя.

С.Эрдэнэболд: Яах вэ би аймаг юм уу, тийм тойргийн нэр хэлэхгүйгээр зүгээр яг хэлье л дээ. Жишээлбэл, 3 аймаг байгаа юм. Тэгэнгүүт нь “А”, “Б”, “В” гэсэн 3 аймаг байгаа юм. Тэгэнгүүт “А” аймгаас сонгогдсон хүн сая жишээлбэл 24 оны хавар “Б”, “В” аймгуудад тайлан тарааж байгаа байхгүй юу. Уг нь бол 20 оны сонгуулиар “А” аймгаас сонгогдсон байдаг. Гэхдээ Сонгуулийн хууль бол тэр нь тойрог болоод “Б”, “В” болчихсон байдаг. Тэгэнгүүт нь болох юм бол өөрийн сонгогдоогүй “Б”, “В” гэдэгтэй сурталчилгаа, тайлан гээд явчхаж байгаа юм.

Мэдээж Улсын Их Хурлын гишүүн бол Үндсэн хуульд тангараг өргөхдөө Монголын ард түмний төлөө өргөж байгаа гэдэг утгаараа үүнийг нэг талаасаа харж болно. Гэхдээ нөгөө талд нь яаж байна аа гэхлээрээ өөрийн сонгогдоогүй тойрог байсан зүйл ирээдүйд сонговол, сонгогдох тойрог нь болчхонгуут тэнд тайлан нэрээр танигдал ахиулах сурталчилгаа явуулж байгаа нь өөрөө бас шударга бус юм аа гэж. Сая жишээлбэл өнгөрсөн хугацаанд яг тойргууд дээр ийм зүйл тохиолдсон. Энэ нь эргээд залуучууд, шинэ хүмүүст маш хол.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Яах вэ боломжийнхоо хүрээнд тэгээд тайлбараа өгчихгүй юу. Номинчимэг гишүүний микрофоныг.

О.Номинчимэг: Яг яах вэ энэ л асуудал дээр иргэний нийгмийн байгууллагууд мэдээлэл гаргагч нар тавьж байгаа юм л даа. Ер нь тэгш бус гараа үүсгэж байна. Тэгээд хамгийн гол гогцоо чинь, Цэцээс ч гэсэн та дүгнэлтийг харсан бол Цэц бол мэдээж парламентын гишүүн, Улсын Их Хурлын гишүүн бол иргэд,

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

олон нийттэйгээ эргэх холбоотой ажиллах, тайлангаа тавих, уулзалт хийж, төрийн ажилд энэ санал бодлыг нь тусгах ажил явах ёстой. Энэ дээр бол энэ зорилго бол зорилгынхоо хүрээнд байна.

Гэхдээ таны хэлсэнчлэн яг сонгогчидтойгоо биш бусад ингээд сэдлээр ажлын тайлан гэхээсээ илүү өөрийгөө таниулах байдаг юм уу, сонгуулийн сурталчилгааны шинж чанартай материал тараадаг уулзалтууд хийгээд байгаа учраас энэ нь өөрөө тэгш бус байдлыг үүсгээд байна гэсэн дүгнэлт хийсэн байгаа.

Тэгээд энэ дээр бол ялт ч үгүй бид тавьж байгаа шаардлага буюу үнэхээр хийсэн ажлынхаа тайланг Улсын Их Хурлын гишүүнийхээ тайлагналыг хийх гэж байгаа бол тэрэнд нь агуулга нь юу байх юм, юу байх ёсгүй юм, ямар агуулга байх юм бол, эсвэл юу байх юм бол сонгуулийн сурталчилгааны шинжтэй болчих юм гэдэг зүйл ерөөсөө хууль тогтоомж нь ч байхгүй, нарийвчилсан тайлбарууд, практик дээр ч гэсэн энэ харагдахгүй байна аа гэдэг юмыг Цэцийн дүгнэлт хийсэн. Тухайн үеийн мэтгэлцээн дээр ч гэсэн гарсан гэсэн үг.

Д.Цогтбаатар: Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 03 тоот, дүгнэлт ёсоор бол Улсын Их Хурлын гишүүд Сонгуулийн жилд тайлан тавьж болохгүй, тайлангаа тавьж сонгогчидтой уулзаж болохгүй энэ нь Үндсэн хууль зөрчиж байна гэсэн дүгнэлт гарсан байх юм. Энэ нь нэлээн учир дутагдалтай дүгнэлт гарчихсан юм байна гэж би хараад байна л даа.

Яагаад гэхээр Үндсэн хууль ганцхан заалтаар биш Үндсэн хуулийг агуулгаар нь буюу бусад бас заалтуудаар нь авч үзэх ёстой л доо Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийн хугацаа нь 4 жил гэж байгаа юм. Гэсэн чинь энэ Цэцийн энэ дүгнэлтээр бүрэн эрхийн бүрэн эрхийн хугацааг нь 3.6 жил гэж хэлж байгаа байхгүй юу. Өөрөөр хэлбэл тэр сонгуулийн жилийн 6 сар сонгогчидтойгоо уулзаж болохгүй гэж юу яриад байгаа юм? Энэ чинь 4 жил бүрэн эрх нь хэрэгжинэ, сонгогчидтойгоо амьд холбоотой байна, уулзалт, яриа хийнэ гээд Үндсэн хуульд байгаа шүү дээ.

Тэгэхээр би энэ дүгнэлт бол нэлээн учир дутагдалтай л гарчихсан юм байна даа одоо. Тэгээд тэр ухаан нь сонгуулийн жил сонгогчидтойгоо уулзсан гишүүн Үндсэн хууль зөрчсөн болох юм уу? Харин эсрэгээрээ хүмүүс чинь давуу байдал олгож байна шүү дээ. Их Хурлын гишүүн биш хүмүүст давуу байдал олгож байна шүү дээ. Гишүүн нь болохоор уулзаж чаддаггүй. Гишүүн биш хүмүүс нь тэгвэл уулзалтаа хийгээд явах нь байна шүү дээ. Ийм логикгүй дүгнэлт гаргачхаад байгаа байхгүй юу. Тийм.

Тэгэхээр энэ дээр Үндсэн хуулийн цэц дээр яг энэ үндэслэлээр маргаан өрнөсөн юм болов уу, тайлбарууд яригдсан юм болов уу гэсэн нэгдүгээр асуулт байгаа юм Номинчимэг гишүүнээс.

Хоёрдугаарт, энэ удаагийн Улсын Их Хурал дээр нэг онцлог байгаа нь жагсаалтаар сонгогдсон гишүүд байгаа. Сая Эрдэнэболд гишүүн бас хэлж байна л даа. Өөрийнхөө сонгогдсон тойргоос өөр тойрогт жишээлбэл тайлангаа тавьж болох юм уу, үгүй юм уу гэдэг асуудалд зүй ёсны асуулт.

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

Гэтэл энийг хязгаарлчихлаа гэхэд тэр жагсаалтын гишүүд чинь тэгвэл хаа дуртайгаа танилцуулга, тайлбар хийгээд явах, дахиад давуу байдал үүсгэхэж байна шүү дээ. Тойргийнх нь тайлангаа тавьж чаддаггүй, жагсаалтын гишүүн болохоор болдог. Энэ чинь дахиад логикийн зөрчил гараад ирж байна.

Тийм учраас энэ жагсаалтын гишүүд болон тойргоос сонгогдсон гишүүд тайлангаа тавихтай холбоотой зааг, ялгаа эрхийн хязгаарлалт дээр Үндсэн хуулийн цэц дээр гомдол гаргагч, өргөдөл гаргагч, мэдээлэл гаргагч тал Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч талын хооронд яриа, мэтгэлцээн өрнөсөн үү гэсэн хоёр дахь асуулт байна.

Д.Цогтбаатар: Номинчимэг гишүүний микрофоныг өгье.

О.Номинчимэг: Энхбаяр гишүүний хөндөж байгаа асуудлаар ерөнхийдөө Цэцийн байр суурийг би ер нь бол хуралдаан, мэтгэлцээний журмаар, асуулт хариултын журмаар явсан. Түүний дагуу Цэцийн шийдвэр бол зүгээр зөрчсөн гэдэг шийдвэрээ уншиж танилцуулсан. Яг та бүхэнтэй адилхан түрүү долоо хоногт энэ бичгээр 24 хуудас энэ учир шалтгаан, яагаад ийм шийдвэрт хүрсэн гэдэг зүйлийг нь бичгээр бид нар хүлээж авсан. Тэгээд мэтгэлцээний үед бол Цэцийн гишүүдийн асуултуудаас харж байхад ер нь Улсын Их Хурлын гишүүн яагаад өөрийгөө таниулах, эсвэл энэ тайлангаа тавьж болоод байхад энгийн гишүүд тайлангаа тавьж болохгүй байгаа юм бэ л гэдэг асуулт дээр байсан. Тэгэхээр тэрнээс Улсын Их Хурлын гишүүд тайлангаа явах нь зүйтэй юм аа, зүй ёсны байх юм.

Гэхдээ хэрвээ тэгж байгаа бол бусад этгээдүүдэд ч гэсэн боломж олгооч гэсэн байдлаар асуултууд явсан. Яах вэ энэ дээр бас хөндөгдсөн асуудал гэвэл зөвхөн бид нар Улсын Их Хурлын гишүүний асуудал энэ хууль дээр тавигдсан болохоор ярьсан. Тэгэхэд энэ чинь төрийн үйл ажиллагаа тасралтгүй явах ёстой. Улсын Их Хурлын гишүүд нь тэгвэл тайлангаа тавихгүй байлаа гэхэд Засгийн газар яах юм? Засгийн газрын үйл ажиллагаа сонгууль болно уу, болохгүй юу, тэр чинь тасралтгүй явж байх ёстой. Аймаг, Нийслэлийн Засаг дарга нар ч гэсэн хийж байгаа үйл ажиллагаагаа таниулах, төрийн албаныхаагаа дуудаж уулзах гээд олон үйл ажиллагаа явдаг. Тэгээд эд нар тэгвэл илүү давуу байдал үүсэж байгаа гэж үзэх юм уу гэдэг асуултуудыг уг нь тавьсан боловч энэ асуултын хариулт Цэцийн дүгнэлтэд гараагүй. Зөвхөн энэ Сонгуулийн тухай хууль дээр тусгагдсан 2 асуудлын хүрээнд л Үндсэн хууль зөрчсөн гэж үзэж байгаа. Үзсэн байна лээ.

Хоёрдугаарт, тэр тойргийн гишүүд болон жагсаалтын гишүүд тэгвэл тайлагналын асуудал яах вэ гэдэг маргалдаан бол мэтгэлцээн бол Цэцийн дунд суудлын мэтгэлцээн дээр явагдаагүй. Энэ нь яах вэ би ойлгохдоо итгэмжилсэн төлөөлөгчийн хувьд Цэцийн гишүүд маань ерөнхийдөө Улсын Их Хурлын гишүүд тайлагнах нь бол зүй ёсны хэрэг. Мэдээлэл гаргагч ч гэсэн энийг хүлээн зөвшөөрсөн юм уг нь. Тийм ээ энэ бол бүрэн эрхийнхээ хугацаанд тайлагнах нь зүйтэй. Зөвхөн тэр тайлагнаж байгаа агуулга дотор чинь зөв хүн ажлын тайлан биш өөрийгөө сурталчлах ч байдаг юм уу, илүү давуу эрх олгосон ийм агуулгууд ороод байна. Замбараагүй бас ингэж хэмжээ хязгаарыг нь ерөөсөө нарийлж зохицуулаагүй учраас л илүү ийм тэгш бус байдал, тодорхойгүй байдал үүсгээд байна гэсэн аргумент байсан. Тэгээд энэ дээр ч илүү Цэцийн гишүүд илүү анхаарч бас асуултуудаа асууж, дүгнэлтээ гаргасан байна гэж харж байна.

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

Д.Цогтбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Энэ хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгье.

Ганбат гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Би энэ Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн холбогдох зүйлийг, хэсгийг бас Үндсэн хууль зөрчсөн эсэх маргаан дээр гарсан Цэцийн дүгнэлтийг хүлээж авах боломжгүй гэдэг дээр бас байгаа. Тэгээд сая бас гишүүдийн хэлж байгаа үндэслэлийг бас адилхан дэмжиж байна.

Энийг зөвхөн улс төрийн сонгуульд оролцох гэж байгаа, нэр дэвших гэж байгаа гэдэг юм уу ийм өнцгөөс нь битгий бас хараасай гэж бодож байгаа юм. Энэ нь өөрөө эргээд сонгогч хэнийг сонгох вэ гэдэг зүйл дээр бас нэг талдаа бас бодолцох ёстой. Өөрийнх нь өмнө нь сонгосон гишүүн ажлаа хийсэн үү, үгүй юу гэдэг зүйлийг мэдэж байж дараа нь бас сонголтоо үргэлжлүүлэх үү, эсвэл өөр хүнийг сонгох уу гэдэг зүйл хүртэл бас сонгогч талдаа байх ёстой шүү дээ.

Нөгөөтээгүүр бас энэ асуудлын цаана зүгээр гол юм бол бас тэр сонгогч талынхаа нюансыг гадна магадгүй зүгээр улс төрийн сонгуульд дараа нь оролцохгүй хүн бас тайлангаа тавьчих бололцоо байх ёстой шүү дээ. Гэтэл сонгуулийн жил ерөөсөө ингэж бас тайлан тавьж болохгүй ч гэдэг юм уу ингэхээр ер нь их тийм сонин тийм хайчинд орно л доо. Тэгээд би цаашдаа дэвшихгүй гээд бас сонгогч түмэндээ ийм юм хийсэн гээд тайлагнаад улс төрийн үйл ажиллагаагаа болиод явах гэж байгаа хүн бас боломж нь байх ёстой байхгүй юу. Тэгэхээр ийм ердийн логикоосоо бодсон ч гэсэн энэ дээр бас зайлшгүй бас Цэц шийдвэрээ эргэж анх удаа хараасай.

Тэгээд энэ Улсын Их Хурал, Цэц 2 заавал 2 туйлд гарч үзэх гээд байгаадаа биш, магадгүй энд бас хэлж байгаа өнцгөөр, бас энэ гаргасан дүгнэлтээ яг их суудлын хуралдаан магадгүй хуралдах л байх л даа Улсын Их Хурал яаж шийдэх юм мэдэхгүй байна. Авахгүй гээд шийдчих юм бол Их суудлын хуралдаан зарласан тохиолдолд бас энийгээ бас эргэж авч үзээсэй. Тэгэхгүй манайхны өнгөрсөн жил хандлагууд байгаа юм. Гаргасан шийдвэрээ хамгаална гээд сүүлдээ ингээд болж байсан текстийг ингээд институц хоорондын зүгээр ойлголцлын юунаасаа болоод бүүр өөр нюанс рүү аваачаад тэнд байгаа сонгогч болон Улсын Их Хурлын сонгуульд орох гэж байгаа хүмүүсийн эрх хязгаарлагддаг ийм нөхцөл байдал руу орчих вий гэдэг зүйл бас байгаа юм.

Тэгээд би энэ дээр бас Улсын Их Хурлын Тамгын газрын удирдлагуудаас бас энэ орж ирээд суух ёстой нэг юм байгаа юм. Энэ Цэцийн нэг хэлээд байгаа үндэслэл байгаа юм. Улсын Их Хурлаар болоод Хууль зүйн байнгын хороо Улсын Их Хурлаар энэ шийдвэрийг хүлээж авахгүй гэдэг үндэслэлээ тогтоолдоо бичээч ээ. Түүнээс биш манай үндэслэл юу вэ гэхээрээ Улсын Их Хурлын тогтоол гаргах, тогтоол хэлбэртэй байна аа гэдэг зүйлээ биччихээд хүлээж авахгүй гээд шийдчихээд байгаа байхгүй юу. Цэц юу хүсээд байна гэхээр яагаад хүлээж авахгүй болсон үндэслэлээ ингээд тоочоод бичээд шийдвэрээ гаргачихвал бид хэд бас энийг чинь харгалзаж үзэх гээд байна аа, тэгээд ийм юм яригдаад ингэсэн юм аа гэхээр та чинь бас яг бүгдийг нь төлөөлж хэлж чадах билүү, тэгээд тэр тайлбар дээр чинь бас дутуу хөтүү оччихдог юмнууд байгаад байгаа юм.

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

Тэгэхээр энийг шийдэх Дэгийн хуулийн өөрчлөлтийг яаралтай шийдээд, Байнгын хороон дээр гарсан саналуудыг эмхэлж цэгцлээд Улсын Их Хурал руу орохдоо тогтоолын төсөл ороод, тэрийгээ чуулган дээрээ албажуулаад ингээд ийм үндэслэлээр бид авч чадахгүй байна аа гэдэг зүйлээ хэлчихвэл бас Цэц бас нюанстай эргэх юм шиг байгаа юм. Тэгэхээр бас энэ зүйлүүдийг бас Улсын Их Хурал, Улсын Их Хурлын Тамгын газар маань бас анхаараад бас шийдчихвэл бас хаа хаанаа ойлголцол байна. Тэгээд би түрүүн Эрдэнэболд гишүүн болон Энхбаяр гишүүн, Номинчимэг гишүүний өгч байгаа тайлбаруудыг бас дэмжиж байгаа шүү. Ер нь бол энэ их тэгш байдлыг гэхээсээ илүүтэйгээр. Магадгүй зүгээр яг хэлбэрийн хувьд, тоо хэмжээний хувьд, цаг хугацааны хувьд жоохон зохицуулалтуудыг сайжруулаад оруулчхаж болох юм. Яг сонгуулийн сурталчилгаа эхлэхээс тэдний өмнө ч гэдэг юм уу, эсвэл сонгуулийн жил эхлэх юм бол 1 юм уу, 2 удаа ч гэдэг юм уу. Тэгэхдээ ер нь зүгээр яах вэ байнгын үйл ажиллагаатай парламент гэдэг юм уу ийм юм явж байхад бодлого, шийдвэрүүдийг иргэд сонгогчид заавал хүргэж байх ёстой.

Тэгэхээр бид хэд ийм юм болохгүй байна аа гээд бас хүргэхгүй байгаад байна гэдэг чинь бас их хэцүү. Тэгээд ер нь зүгээр сонгуулийн сурталчилгаа гэдэг дандаа.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Би бас энэ дүгнэлтийг гайхаад л байгаа юм. Ер нь цаг хугацааны хувьд сонгуулийн жилийн 1 сарын 1-нээс сонгуулийн нэр дэвшүүлэх ажиллагаа хүртэлх хугацааны асуудал яригдаж байгаа юм. Тэгэхээр энэ хугацаанд чинь тэр Их Хурлын гишүүд чинь хэн нь ч нэр дэвших, нэр дэвшигч болохыгоо мэдэхгүй байгаа байхгүй юу. Их Хурлын гишүүн болгон нэр дэвшинэ гэж ойлгож болохгүй шүү дээ. Жишээлбэл, өнгөрсөн энэ 24 оны сонгуулиар манай намаас гэхэд л 19, 20 хүн гишүүн байсан улсууд нэр дэвшээгүй л байхгүй юу. Тэгэхээр энэ дүгнэлт ингээд Их Хурлын гишүүд тайлангаа тавьж байгаа нь материал, уулзалт хийгээд байгаа нь давуу байдал болгоод байна гэж ингэж ойлгохоор бас өрөөсгөл байгаа юм.

Нөгөө талаар гишүүн биш хүн бас уулзалт хийгээд тэр чинь бас өөрийгөө нэр дэвшинэ, дэвшихгүйгээ мэдэхгүй л яваа байхгүй юу. Яг үнэнийг хэлэхэд тэр нэр дэвшүүлэх үйл ажиллагаа хүртэлх хугацаанд хэн нь ямар уулзалт хийж, ямар яриа, таниулга хийж явах нь бас энийг нээж өгөх, эсвэл хаах, хориглох, хязгаарлах нь ингээд хууль зөрчиж байна аа гэдэг асуудал яригдахаараа бас их сонин болоод байгаа юм.

Тийм учраас энэ тайлан энд сая Сайнзориг гишүүний зөв л дөө. Иргэдийг мэдээллээр хангаж өнгөрсөн 4 жилд бидний сонгосон гишүүн хэр яаж ажиллав, ямар 4 жил болж өнгөрөв, ямар хууль тогтоомж, эрх зүйн шинэчлэлийг хийв гэдэг мэдээллийг авч байж иргэд сонголтоо хийх бололцоо, боломжоор хангагдах ёстой шүү дээ. Тэгээд тэр тайлангаас нь унших ёстой шүү дээ 4 жилийн ажлынх нь тайлангаас. Уулзалт ярилцлагад нь сууж үнэлгээ, дүгнэлтээ, саналаа өгөхийн тулд бас мэдээ мэдээлэл авах эрхтэй байхгүй юу. Тэгээд энийг ингээд Үндсэн хууль зөрчсөн байна гээд ингээд хязгаарлана гэхээр бас учир дутагдалтай байгаа юм. Би зүгээр шууд Цэцийн дүгнэлт хязгаарлаж байгаа юм байна гэж ойлгохгүй байна. Зүгээр тодорхойгүй бүрхэг байна. Энийг тодорхой болго хуульдаа гэсэн ийм л байдлаар гарсан юм болов уу гэж ойлгож байна.

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

Тийм учраас бид нар энэ Цэцийн дүгнэлтийг хүлээж авсан авах эсэхээс үл хамаараад цаашдаа бас сонгуулийнхаа хуульд бас энийг тодорхой оруулж өгөх ёстой юм байна л гэж ойлгож байна. Яг уулзалт юм уу, тайлан юм уу, сэтгүүл юм уу, аль нь юм? Алийг нь юу гэж үзэх юм? Аль нь илүү давуу байдал олгоод байгаа гэдэг энэ болгоныг нарийн л тусгах ярих л асуудал үүсэж байгаа юм байна л гэж ойлгож байна. Тийм учраас би энэ дүгнэлтийг хүлээж авах боломжгүй юм аа гэсэн ийм байр суурьтай байна.

Д.Цогтбаатар: Ганбат гишүүний микрофоныг өгье.

Д.Ганбат: Энэ чинь Цэцийн дүгнэлтийг бас хүлээж авах юм уу, хүлээж авахгүйдээ бид нар бас нэлээн нюанстай хандах ёстой гэж ойлгож байна. Юу вэ гэхээр төрийн ажил тасралтгүй байх ёстой. Үндсэн хуульд ч гэсэн тэгж заачихсан байгаа. Төр гэдэг чинь юу юм бэ? Энэ Улсын Их Хурал гэж бодоод байгаа шүү дээ. Улсын Их Хурал маань Улсын Их Хурлын гишүүдээс бүрдэнэ. Төр нь яаж ажиллаж байгаагаа эцсийн эцэст ард түмэн сонгосон байгаа сонгогч дээрээ очиж тайлангаа тавьж, тэд нарын захиа даалгаврыг авч, тасралтгүй үргэлжлэх ёстой юмыг ямар нэгэн байдлаар ингэж саад учруулж болохгүй ээ. Тавьж байгаа энэ юмнуудаа нэлээн ойлгомжтой болгох нь зүйтэй л дээ. Тэрнээс биш бетон тараах гээд байгаа юм бол ерөөсөө байхгүй. Тийм, хэрэгтэй юм бас өгч чаддаггүй, тарааж чаддаггүй л байхгүй юу даа. Ард түмэнд хэрэгтэй ийм юмыг нь өгч чаддаггүй ийм л байдаг шүү дээ. Тийм. Тэрнээс бетон тараах гээд байгаа юм ерөөсөө тэнд байхгүй. Тэрнээс хийж байгаа ажлаа, зөв, зүйтэй зүйлийг нь иргэдээсээ захиас авч, энэ улс орны ажлыг тасралтгүй явуулж, буруу явж байгаа юмыг засаж залруулах ёстой.

Эцсийн эцэст ард түмний сонголт өгчхөөд байхад, хийчхээд байхад тэр ард түмнийхээ яг хүссэн хүсэл зоригоор энэ улс орны үйл ажиллагаа явахгүй байгаа юм. Сөрөг хүчин гэж байхгүй болчихсон. Сөрөг хүчин гэдэг чинь алдаа, дутагдлыг нь засдаг л байхгүй юу даа. Ийм байгаа учраас Үндсэн хууль аягүй бол ийм дүгнэлт гаргаад байж магадгүй. Тэр ардчилалтай улс орон, сая бид нар харлаа шүү дээ. Тэр 50 оноос, 50 хэдэн оноос хойш явж байгаа энэ Солонгос Улс тэр парламентын гишүүд нь парламент дээр орж ирж шийдвэр гаргах гээд байхад тэр хүчний байгууллага ард түмнийхээ нөгөө талд гарчихсан тэд нарыг оруулахгүй гээд байж байхад хашаагаа давж орж ирж байгаа шийдвэрээ гаргаж байна шүү дээ. Ингээд Солонгос орныг бас тэр ардчилсан гэдгээр нь авч үлдэж чадлаа шүү дээ. Тийм улс оронд тийм юм бий болж үүсэж байхад манайх ямар эмзэг байгаа билээ, ямар байгаа билээ. Ийм юмыг нь бас Үндсэн хуулийн цэц ч гэсэн энийг ойлгож, бодож бас энэ шийдвэрүүдээ гаргах ёстой. Бид нар ч гэсэн бас энд нь ойлгож, энийг бас олон түмэндээ тайлбарлаж таниулж хуулиа бас тасралтгүй сайжруулж засаж явах нь зүйтэй гэсэн ийм бодолтой байгаа шүү. Хүлээж авахгүй байсан нь дээр байх энэ удаа бол.

Д.Цогтбаатар: Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Би энэ дүгнэлтийг Үндсэн хуулийн цэц гаргахдаа бас энэ дүгнэлтийн улс төр, эрх зүйн үр дагаврыг бас сайн хараагүй юм болов уу гэсэн ийм итгэл үнэмшилтэй боллоо.

Нэгдүгээрт, энэ 4 жилийн хугацаанд ард түмнийхээ төлөөлөгч байна гэсэн энэ бүрэн эрхийг хязгаарлаж байна. Их Хурлын гишүүний бүрэн эрхийг 6 сараар

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

хязгаарлачхаж байна. Уулзалт хийж болохгүй гэдэг чинь юу гэсэн үг юм. Тэгэхээр чинь бусад нэр дэвшихийг горилж байгаа хүмүүс болохоор уулзалт хийх боломж давуу байдал олгож байна.

Хоёрдугаарт, бид нар Үндсэн хуулийн өөрчлөлтөөр Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын үүрэгт ажлыг хавсарч эрхлэх ийм Үндсэн хуультай байгаа. Энэ Засгийн газрын гишүүнээр хавсарч байгаа Улсын Их Хурлын гишүүдэд дахиад давуу байдал болгож байна. Яагаад гэхээр Засгийн газрын үйл ажиллагаагаа хийж байна аа, ажлаа хийж байна аа гээд л уулзаад байх нь байна шүү дээ. Нөгөө Засгийн газрын биш гишүүд нь болохоор уулзаж чаддаггүй. Дахиад давуу байдал болгож байна. Ялгамжтай байдлыг бий болгож байна. Улс төрийн үр дагавар их ноцтой болно. Амыг нь хааж чадахгүй. Улсын Их Хурлын гишүүн 4 жилийн хугацаанд та бүхнийгээ яаж төлөөлсөн юм, би ямар хууль санаачилсан юм, би хуулийн хэрэгжилт дээр яаж анхаарсан юм гэдгийгээ ярьж болохгүй гэж ер нь яг юу гэсэн үг юм? Тэгээд хаана ярих юм энэ? Тэгээд сонгогчидтойгоо уулзалт хийж болохгүй ч гэж юу гэсэн үг юм? Би бол хотоос сонгогдсон гишүүн 500 мянган хүн амтай БЗД Монгол Улсын сонгогчдын 20 хувь нь дангаараа, 20 хувийн төлөөлөл болсон тийм том газраас сонгогдсон. Жишээлбэл, тойргийн сонгогчидтойгоо уулзах гэхэд 3 сар шаардлагатай байгаа. Тойроод явахад шүү дээ 3 сар. Одоо бид нар чинь энэ бүсчилсэн бүсээ сонгодог болчихсон, 5 аймгаас сонгогдчихоод байгаа шүү дээ энэ гишүүд чинь. Яаж тэр олон сумуудаар явж амжих юм бэ? Нэг тайлангаа тавих гэж энэ чинь бараг хэдэн сар явахаар байгаа шүү дээ манай хөдөө орон нутгаас сонгогдсон гишүүд.

Нөгөө талдаа ингээд хаалаа гээд энэ их үр дүнд хүрэхгүй. Ер нь сонгууль дөхөөд ирэхээр гишүүнээр ч ажиллаж байгаа нь ч бай, гишүүн биш нь ч бай нэр дэвшихийг горилж байгаа хүн бол бас л алиална шүү дээ. Ер нь өрийг, энэ чинь өмнө нь болж байсан юмнууд яриад байгаа шүү. Ард түмнийхээ өрийг банкны зээлийн өрийг тэглэхчье. Хүнээ байдаг юм байна лээ шүү дээ таалагдах гээд. Дуу дуулж үздэг юм байна лээ шүү дээ зурагтаар, хоол хийж үздэг юм байна лээ шүү дээ бүр ингээд л хоол хийгээд л гэнэт аягүй гоё гоё хоолнууд хийгээд л, лайвдаад л. Тэгээд энэ чинь ерөөсөө бүр алиалагч болж дуусдаг юм байна лээ шүү дээ.

Тэгэхээр тэр орон зайг хааж чадахгүй шүү дээ энэ чинь. Хийсэн ажлаа хууль тогтоогчоор сонгогдсон хүнийг чи хууль тогтоогчийнхоо хувьд хийсэн ажлаа ярьж болохгүй гэхээр тэр хүн яах вэ? Нөгөө сонголт нь алиалагч болоо л гэсэн үг шүү дээ. Тэгээд энэ 126 чинь алиалагч бол энэ юу болох вэ энэ Улсын Их Хурал? Цирк ч цаашаа болно шүү дээ айн? Драма цаашаа болно шүү дээ. Триллер цаашаа болно шүү дээ. Айкшн цаашаа болно.

Д.Цогтбаатар: Алтанхуяг гишүүний микрофоныг өгье.

Н.Алтанхуяг: Ойлголтын зөрүү л үүсчих шиг болох юм. Би энэ сонгогчдод тайлан тавина гэдгийн цаана баахан юм хэвлүүлээд тараадгийг л ойлгож явдаг шүү дээ. Түүнээс биш очоод уулзах бол нээлттэй. Тэр энэ Номинчимэг гишүүн би ойлголтын зөрүү тэн дээр байгаа болов уу гэж бодох юм. Би тэгж ойлгоод юу гэж бодсон гэхээр тэгээд би тэр ойлголтынхоо хүрээнд бол Үндсэн хуулийн цэцийн шийдвэр хүлээж авах ёстой. Бид нар 4 жил Их Хурлынхаа гишүүн ард иргэддээ л тайлангаа тавьдаг байх ёстой нэгдүгээрт тойрогтоо.

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

Хоёрдугаарт, Үндсэн хууль дээр бол Улсын Их Хурлын гишүүн бүх ард түмний элч төлөөлөгч юм байгаа юм. Тэгээд одоо бид нар энийг нь ингээд яриад байгаа, хуульд оролцоод байгаа, маргаад байгаа, мэтгээд байгаа, юу яриад, юуны төлөө зүтгээд байгаа юм энэ тэр бол 4 жилийн хугацаанд сонгогчдод танигдах ёстой. 1 удаагийн, ялангуяа сонгууль дөхсөн үед сүүлийн жил 1 удаагийн хэвлэмэл материалаар аймаар зоддог юм. Тэрийг л би ойлгоод байгаа юм. Энэ бол тэр шүү. Тэр бол буруу. Бид нар ер нь 4 жил улс орныхоо хөгжлийн төлөө дуу хоолойгоо яагаад хууль санаачлаад, санаа оноогоо хэлээд, сонгогчидтойгоо уулзаад ард түмний ахуй амьжиргаа ийм байна, аж ахуйн нэгжүүд ийм байна, энийг нь ингэе, ингээд энийгээ л би бол Их Хурлын гишүүн 4 жил тасралтгүй ажиллаж байгаад 4 жил тасралтгүй тайлан тавьж байгаа гэж ойлгодог юм. Манай зарим этгээдүүд бол цагийг нь дөхүүлж байгаад айл бүрийн тоогоор юм тараадаг байхгүй юу даа. Та нар, та нар тарааж байгаагүй юм уу Энхбаяр аа? Би бол тараагаагүй л дээ. Тэр чинь аймаар их мөнгө байдаг юм.

Тэгээд ийм мөнгөний ийм ялгаварт байдал үүснэ гэж бодож би эд нарыг тэгж хийж байна уу гэж ойлгож байна. Тайлан шүү дээ. Тайлан гэдэг чинь ер нь социалист ойлголт, коммунист ойлголт шүү. Одоо хэдүүлээ тэр ойлголтоос салах хэрэгтэй. Ард иргэддээ өдөр бүхэн тайлангаа тавьж бай. Өнөөдөр энэ нооргийн асуудал ярилаа. Тайлангаа л тавьж байгаа хэлбэр шүү дээ бид нар. Асуудалд ямар байр суурь барьж байгаа юм, юуг нь зөв гэж үзэж байгаа юм, юуг нь буруу гэж үзэж байгаа юм, юуг засах нь зүйтэй гэж үзэж байгаа юм бид? Бид нарын баталчихсан хууль тогтоомж маань амьдрал дээрээ яаж хэрэгждэг юм байна. Хойшлуулшгүй нөхцөл байдал гэдгийг тэд нар юу гэж ойлгож тайлбарлаад байгаа юм. Мэдээлэл ирнэ гэхлээр чатаар ирсэн мэдээллийг шууд авангуутаа хойшлуулшгүй гэж үзэх юм уу гээд. Ийм ийм юм чинь л бол би амьд сонгогчидтойгоо харилцаж байгаа харилцаа, бид нарын үйл ажиллагаа гэж боддог юм л даа. Би энэ агуулгаараа Үндсэн хуулийн цэцийн шийдвэр ёстой зөв гарчээ авна. Нэг.

Хоёрдугаарт, ерөөсөө манай Их Хурлын гишүүд хэдүүлээ бас нэг юм ойлголцмоор байгаа юм. Хүмүүсийг байна шүү дээ сонгууль дөхүүлээд Манжуур явуулдгийг нь болиулмаар байна. Хөх хот явуулдгийг нь болиулмаар байна. Үгүй нээрээ арай ч дээ бид нар арай л ялзарчихсан байгаа байхгүй юу даа.

Тэгээд энгийн үед харин больё гээд байхгүй юу. Заавал сонгуулийн компанид ажил гэхгүй одоо бид нар хүмүүсийг тэрийг больчих л доо. Тийм магадгүй ээ хиам, талх мэдэхгүй. Яах вэ хиам, талхаа авч иддэг болгох ёстой. Тэр бол бид нарын ажил байхгүй юу. Хиам, талханд хууртаж байгаа бол бид нар ажлаа хийгээгүй л гэсэн үг. Би тэр Манжуур юу хоёрыг чинь бол нэлээн судалсан шүү дээ. Айхтар хийдэг юм байна лээ. Энэ бол ийм агуулгыг манай Үндсэн хуулийн цэц хөнджээ гэж би ойлгож би та нар бүгдээрээ үгүй гээд байх юм. Би бол Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг энэ агуулгаар нь авах ёстой. Хэдүүлээ нийгмээ, энийгээр нийгмээ цэвэрлэх ёстой. Хорио байхгүй дээ Сандагаа минь дээ. Хориотой юм бол яагаад Манжуур явуулаад байдаг юм Их Хурлын гишүүд явуулж байгаа шүү дээ. Энэ ийм асуудал, амьд асуудал харин ярьсан байна шүү манай Номинчимэг гишүүн ээ. Тэгээд та нар тодруулаадхаач тэгээд би бол дэмжих ийм л бодолтой, хүсэлтэй, бүүр хүсэл эрмэлзэлтэй байгаа шүү.

Д.Цогтбаатар: Номинчимэг гишүүнд микрофон өгье.

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

О.Номинчимэг: Яах вэ энэ хэрэг дээр бас итгэмжилсэн төлөөлөгчөөр оролцоод, тэнд бас гарсан мэтгэлцээнүүдийг сонссон хүний хувьд Улсын Их Хурлын гишүүд иргэдтэйгээ уулзалт хийх нь бүрэн эрхийн асуудал. Энэ бид нарын энэ Сонгуулийн хууль дээр хүчин төгөл, хүчингүй болсон уу, үгүй юу гээс үл хамаараад Улсын Их Хурлын тухай хууль дээрээ бид өөрсдийнхөө үйл ажиллагаагаа иргэд сонгогчдоо мэдээлэх бүрэн эрх нь байгаа. Үүнийхээ дагуу угаасаа хэрэгжүүлэх ёстой. Энийг бол Цэцийн гишүүн, Цэцэд ингээд гарчихлаа гээд хориглоххож байгаа зүйл гэж би бол бодохгүй байгаа.

Зүй нь яах вэ энэ дээр яг жоохон бүхэлд нь бас авч үзэх ёстой байсан гэдэг дээр би санал нэг байна Цэцийн гишүүд маань энэ асуудал дээр. Энэ дээр гол би Цэцийн гишүүд юун дээр илүү анхаарчхав гэхээр энэ үг, үсэг, жоохон энэ техникийн, хууль зүйн техникийн юмнууд дээр бас илүү акцент өгчхөв үү гэж харж байгаа. Тэрний юу вэ гэхээр ер нь бол хуулиа сайн харах юм бол, үг, үсгээр нь унших юм бол уулзалт хийх бол хэнд ч нээлттэй байгаа. Хууль бус сурталчилгааг хориглох буюу 48.1 дээр бол зөвхөн эд мөнгө тараах, амлалт өгөх, цайллага, дайллага, баяр наадам, спорт хийх, гадаад, дотоод аялал жуулчлал зохион байгуулах, оролцуулах Алтанхуяг гишүүн эд нар бүгдийг хориглочихсон байгаа. Энийг Улсын Их Хурлын гишүүн байна уу, энгийн иргэн байна уу бүгдэд нь адилхан хориглоно. Энэ бол Улсын Их Хурлын гишүүн зөвшөөрөөд, бусад нь зөвшөөрөөгүй асуудал биш шүү дээ. Тэгэхээр энэ уулзалт бол тэр энгийн иргэнд бол нээлттэй байгаа байхгүй юу. Энэ дээр зөвхөн тайлангийн асуудал байсан. Тайлангаа тэрийгээ хэвлэмэл байдлаар тараах уу, үгүй юуг нь л асуудал байгаа.

41.9, 44.6 дээр харах юм бол энэ үг, үсгийн ал асуудлыг нь харах юм бол Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвшихээр бол гэдгээр орчихсон байгаа. Зүй нь бол Улсын Их Хурлын гишүүн нэр дэвшинэ үү, дэвшихгүй байна уу хамаагүй тайлангаа тавих ёстой. Энэ нь бол сонгуулийн сурталчилгаа биш шүү л гэдэг асуудлыг уг нь оруулах гэж, нарийвчлах гэж, хуучин 2011 онд байсан асуудлыг цэгцлэх гэж хийсэн ажлынхаа тайлан гэдгээр тодотгож уг нь өгсөн юм байна лээ. Тэгээд энэ дээр л ерөнхийдөө жоохон ойлгомжгүй байна гэдэг юм давуу явчхав уу даа гэж харж байгаа.

Тэгэхээр уг нь Цэц энийгээ илүү боловсронгуй бол ялангуяа тэр сонгуулийн сурталчилгааны агуулга гэж юу юм? Тэгээд тэр гишүүний хийсэн ажил ажлын тайланд тэгвэл ажлын тайлангийн агуулга юугаар хязгаарлагдах юм, юу руу орчихоороо сонгуулийн сурталчилгааны төрөл рүү, хэлбэр лүү орчих юм гэдэг юмыг жоохон нарийвчилчих юм бол миний бодлоор энэ тэгш бус байдлын ялгаварлан гадуурхсан асуудал бол тийм байхгүй, тэр дүгнэлт ерөөсөө гаргах шаардлагагүй гэж харж байгаа юм.

Тэгэхээр ерөнхийдөө хууль тогтоомжоо боловсронгуй энэ чиглэл болгооч гэсэн зөвлөмжийн шинж чанартай байгаад үнэхээр ч бас үзэхээр хууль зүйн техникийн хувьд бид нар энэ 41.9 эд нар дээрээ жоохон ажил, засваруудыг хийх юм бол илүү ойлгомжтой болохоор асуудал байгаа учраас энийг нь анхаарах, анхаарах байдлаар хууль тогтоомжоо жоохон боловсронгуй болгох байдлаар ажиллачих юм бол энэ асуудал шийдэгдчихээр юм байна гэж харж байгаа.

Д.Цогтбаатар: Баярлалаа. Би хэдэн үг хэлье.

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

Хууль тогтоомж энэ түрүүн бас Алтанхуяг гишүүний хэлж байгаа юу зөв. Ямар утгаар гэхлээр хууль тогтоомжийг сайжруулах хэрэгцээ байна. Одоо яг энийг үүгээр нь авчих юм бол энэ чинь бүүр эсрэг үйлчлэлтэй болчих гээд, сайжруулах орон зай үлдээчихгүй болчих гээд байна. Би энэ дээр тэр утгаар нь хүлээж авах үнэхээр боломжгүй байна. Яагаад гэвэл эрх зүйн үр дагавар нь бидний зорьж байгаа юунаасаа хэтрээд буруу тийшээ явчих гээд байна. Надаа ингэж харагдаж байгаа юм.

Жишээлбэл, энд түрүүн Сайнзориг гишүүн ч хэлж байна лээ хүн оролцохгүй бол яах юм бэ? Энэ чинь презумпц нь оролцоно гээд тооцоод хориод байгаа байхгүй юу. Тэгсэн оролцохгүй байх гишүүнд 3 сар, 3 жил 6 сар ажиллаад л тэгээд бултчих боломж олгож байгаа байхгүй юу. Тэгэхлээр тийм юм байхгүй. Ерөөсөө гишүүн бол дараагийн гишүүн тангаргаа өргөтөл бүрэн эрх нь хүчинтэй, Үндсэн хуулиараа явж байгаа шүү дээ. Тэрийг хэн ч өөрчилж чадахгүй. Тэгэхлээр тэр үедээ тэр хүн ажлынхаа эрх, үүргийг гүйцэтгээд явж байх ёстой. Тэр утгаараа энэ чинь би энд яг цэвэр хууль л ярих гэж байгаа юм. Үндсэн хуульд байгаа өөрийнхөө заалтыг энэ тайлбар зөрчиж эхэлж байгаа байхгүй юу. Хамаагүй эрт Үндсэн хууль чөлөөлөхөөс өмнө Үндсэн хуулийн цэц чөлөөлөх гээд байна шүү дээ. Нэг.

Хоёрт, энэ дээр нэг том ялгаа гарчихсан, андуурал явж байна. Эрх, үүрэг хоёрыг хооронд нь андуурчихсан байна. Энэ чинь тайлангаа тавих үүрэгтэй байхгүй юу. Эрхтэй биш. Үүргээс нь чөлөөлж өгөх гээд байгаа байхгүй юу. Түүнээс бидний тайланг сонсох эрхтэй нь ард түмэн байхгүй юу сонгогчид. Ард түмний эрх рүү энд чинь халдчих гээд байгаа байхгүй юу. Ард түмний эрх рүү халдах эрх ерөөсөө Үндсэн хуульд ч байхгүй, биш ээ Үндсэн хуулийн цэцэд ч байхгүй. Тэгэхлээр энэ үүргийн асуудлыг үүргийнх нь хүрээнд л ярина. Эрхийн асуудлыг эрхийн хүрээнд нь л ярина. Тэгтэл жишээлбэл өрсөлдөх гэж байгаа гишүүн биш хүнд бол ард түмэнтэй очоод уулзах эрх байгаа болохоос тэд нарт үүрэг байхгүй. Бид нарт үүрэг байж байгаа гишүүдэд.

Тэгэхлээр энэ хоёрыг хооронд нь тэгж хутгаж хандаж болохгүй ээ. Үүргээс эрт чөлөөлж болохгүй. Тэр ачааг гишүүн дуустлаа үүрэх ёстой тэр ард иргэдийн өгсөн мандатыг үүрээд дуусгах ёстой гэж бодож байгаа юм.

Тэгээд сурталчилгаа гээд үзэх юм бол ийм асуудал байгаа юм. Ердийн уулзалтууд ч ер нь өөрөө сурталчилгаа байхгүй юу. Тэгэх юм бол энэ чинь 4 жилийн таны хэлж байгаа үнэн. Бүр 4 жилийн сурталчилгааг чинь сурталчилгаа гэж үзээд тэгш бус байдал гэх гэж байна шүү дээ. Тэгэхлээр бас ярих юм бол ингээд яриад явчхаж болох учраас энэ дээр ер нь цаашдаа хэдүүлээ бодох юм сайжруулах ёстой юм байна. Энийг яг үүгээр нь хүлээгээд авчих юм бол гарах сөрөг үр дагавар нь эергээсээ хамаагүй даваад явчих юм байна гэж бодож байна.

Тэгээд энэ дээр гишүүд үг хэлж дууслаа. Ингээд одоо энд чинь юу хуулийн дагуу бид нар яг тухай зүйл бүрээр нь санал хураалт, зөрчсөн гэсэн зүйл бүрээр нь санал хураалт явуулна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 82.2.2-т заасны дагуу санал хураалт явуулъя. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсэгт Монгол Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвшихээр бол хийсэн ажлын тайлангаа энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө тарааж болох бөгөөд үүнийг

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

сонгуулийн сурталчилгааны материалд тооцохгүй гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт тэгш байдал, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн гэснийг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Харин тэрийгээ ярья. Яг наадах чинь зөв.

6.3 хувиар санал дэмжигдсэнгүй.

Алтанхуяг гишүүн дэмжсэн гэж байна. Тэгэхлээр дэмжсэн гэдгээр протоколд тэмдэглэж оруулъя.

2.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсэгт Монгол Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвшихээр бол хийсэн ажлын тайлангаа энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө тарааж болох бөгөөд үүнийг сонгуулийн сурталчилгааны материалд тооцохгүй гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна гэснийг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Тэгээд энийг нь хэдүүлээ.

6.3 хувиар санал дэмжигдсэнгүй.

3.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсэгт Монгол Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвшихээр бол хийсэн ажлын тайлангаа энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө тарааж болох бөгөөд үүнийг сонгуулийн сурталчилгааны материалд тооцохгүй гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт хүнийг албан тушаалаар ялгаварлан гадуурхаж үл болно гэснийг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

6.3 хувиар санал дэмжигдсэнгүй.

4.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсэгт Монгол Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвшихээр бол хийсэн ажлын тайлангаа энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө тарааж болох бөгөөд үүнийг сонгуулийн сурталчилгааны материалд тооцохгүй гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 9 дэх заалтад Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй гэснийг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

6.3 хувиар санал дэмжигдсэнгүй.

5.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэгт энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчтой хийсэн уулзалт болон энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг тэгш

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

байдал, хууль дээдлэх төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн гэснийг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

6.3 хувиар санал дэмжигдсэнгүй.

6 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэгт энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой хийсэн уулзалт болон энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна гэснийг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

12.5 хувиар санал дэмжигдсэнгүй.

7.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэгт энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой хийсэн уулзалт болон энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт хүнийг албан тушаалаар нь ялгаварлан гадуурхаж үл болно гэснийг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

6.3 хувиар санал дэмжигдсэнгүй.

8.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэгт энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой хийсэн уулзалт болон энэ хуулиар хориглоогүй арга хэмжээнд сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 9 дэх заалтад төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй гэснийг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

12.5 хувиар санал дэмжигдсэнгүй.

Санал хураалтын дүнг танилцууллаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 3 дугаар дүгнэлтийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Номинчимэг өөрөө танилцуулчихна.

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

Тийм. Үндсэн хуулийн цэцийн ганц юу сонсчихоод та гарчих тэгэх үү? Ганцыг л одоо бид нар гялалзуулна. Тийм. Үгүй ээ.

19.49 цаг

Одоо хоёр дахь асуудалдаа оръё. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 02 дугаар дүгнэлт.

Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 02 дугаар дүгнэлтийг гишүүдэд тараасан байгаа. Цэцийн дүгнэлттэй холбогдуулан итгэмжлэгдсэн төлөөлөгч Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяраас асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү.

Уянгахишиг гишүүнээр тасаллаа. Уянгахишиг гишүүний микрофоныг өгье.

Г.Уянгахишиг: Уг маргаантай холбоотойгоор нэг тодруулж асуух юм байгаад байна. Тэгээд Цэцийн хурал дээр бас яригдсан байж магадгүй гэдэг үүднээс. Хууль дээр бол 55 насанд хүрсэн, тэгээд шүүгчээр 30 буюу түүнээс дээш ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно гэсэн энэ заалтыг Үндсэн хууль зөрчсөн байна гээд дүгнэхчхсэн байгаа тээ? Тэгэхээр энэ дээр итгэмжлэгдсэн төлөөлөгч Ж.Сүхбаатараас өгсөн тайлбар дээр болохоороо энэ нь өөрөө 55 нас хүрсэн бол өөрийн хүсэлтээр өндөр насны тэтгэвэр тогтоолгох гэдэг ийм заалт байгаа буюу зохицуулалт байгаа. Энэтэйгээ адилхан хэрэглээд явна аа гэчихсэн байгаа байхгүй юу.

Тэгэхээр миний асуух гээд байгаа асуулт юу вэ гэхээр яг 55 нас, одоо энэ чинь Хөдөлмөрийн хуулийн дагуу биш, яг Шүүхийн тухай хуулиараа явна шүү дээ ажлаас чөлөөлөгдөх нь. Тэгэхээр 55 нас хүрээд тэтгэврээ тогтоолгочихно гэдэг нь ажлаас чөлөөлөгдөх шууд үндэслэл болж байгаа юм уу? Яг энэ дээр ямар тайлбар байсан бол? Энэ талаар тодруулж асуух гээд.

Д.Цогтбаатар: Энхбаяр гишүүний микрофоныг өгье. Тэгээд дараа нь Сайнзориг гишүүн асуулт асууя сая бүртгэлд орж чадаагүй байна.

Б.Энхбаяр: Шүүгч нь бол төрийн тусгай албан хаагч байдаг. Манай улсын тухайд бол бүх насаар нь шүүгчийг томилдоггүй. Бүх насаар нь гэдэг нь өөрөө бас үхэн үхтлээ гэсэн утга бас биш. Насаар нь томилдог зохицуулалттай гэх Америк, Японд ч гэсэн насны дээд хязгаарыг зохицуулсан байдаг. Тэр дотроо энэ насны, тэтгэвэрт гарах насны онцлогийг ямар байдлаар хэрэглэх вэ гэдэг ийм аргачлалтай бас байдаг юм байна лээ.

Бидний хувьд, шүүгчийн хувьд бол нэг үндэслэлүүдийг Үндсэн хуулийн цэц дээрээс хамгаалж оролцсон. Тэр нь 30 жил ажилласан шүүгч 55 насанд хүрэх юм бол өндөр насны тэтгэвэрт гарах ёстой гэсэн ийм зүйлийг ярьж байгаа. Энэ 30 жил гэдгийг санаанаасаа зохиож гаргаж ирээгүй. Энэ одоо прокурорын байгууллагын хуульд бас ингэж хэрэгжиж явдаг. Мөн ижил ажлын ачаалал, онцлогтой байдаг цэрэг, цагдаагийн тусгай албан хаагчид мөн мэргэжлээрээ 20-25 жил ажиллавал, мөн өндөр насны тэтгэврийг нь тогтоолгодог ийм онцлогтой байдаг. Энэ нь хүний ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, өөр ажил хийх боломжийг хязгаарлаж байгаа ийм утга санаа биш гэж Үндсэн хуулийн цэц дээр байр суурь хамгаалж оролцсон.

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

Нөгөө талаасаа бид ер нь хүний өөрийн нийгмийн хөгжлийн сэтгэлгээ динамик өөрөө их хурдацтай өөрчлөгдөж байна. Нийгмийн бүх л хувьсгалт шинж хэмжээний өөрчлөлт ер нь 30 жилийн мөчлөгтэйгөөр явдаг гэж үздэг. Хүн өөрөө бас нийгмийн амьтан байдаг. Өөрөөр хэлбэл, цаг үеийнхээ бүтээгдэхүүн байдаг. Тэр утгаараа цаг үеэсээ шүүгч ч хүн бол хоцрохгүй, чирэгдэхгүй, хөгжлийн түгжээ, түгжил болохгүй, цаг үетэйгээ шинэчлэгдэж бас явах ёстой. Энэ боломжит хугацаа бас 30 жил бай бас хэтрээд хэрэггүй ээ л гэж үзэж байгаа юм. 30 жилээс хэтрээд ирэхээрээ хөгжилд садаа болдог, шинэ зүйлд садаа болдог ийм байдал байна. Хууль маань өөрөө их хурдацтай шинэчлэгдэж байна. Өнөөдөр 1992 оны баталж байсан бидний Үндсэн хууль 30 жил өнгөрчихсөн. Гэтэл энэ хугацаанд тэр үеийн, тухайн үеийн хууль тогтоогч баталж байсан хуулиуд цаг үеэсээ хоцорч байна. Гэтэл шүүгч хүн маань хуулийг хэрэглэж байгаа, хуулийг амилуулах ёстой тэр хүн байдаг. Тийм уч учраас насаар нь буг болоод бас байж болохгүй шүү дээ гэдэг утгаар хууль тогтоогчийн энэ заалтыг бол.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүний микрофоныг өгье. Уянгахишиг гишүүн тодруулъя.

Г.Уянгахишиг: Энэ дээр яг 47.6 дээр Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47.6 дээр шүүгчийн өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаар 60 нас байх ба 55 насанд хүрсэн, эсвэл шүүгчээр нийт 25 жил ажилласан шүүгч өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгож болно гээд. 2 дахь өгүүлбэр нь болохоор шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн өндөр бол насны тэтгэвэр тогтоолгоно гэхихсэн байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ 2 дахь өгүүлбэрийн тухайд л бид нар яриад байгаа шүү дээ.

Тэгэхээр 25 жил ажиллаад 55 насанд хүрчихсэн бол өөрийн хүсэлтээр тогтоолгож болж байгаа байхгүй юу. Энийг ойлгож байна. 60 нас хүрчихсэн бол 60-аас дээш бол шүүгчээр ажиллаж болохгүй нь гэдэг санаа яваад байна. Тэгэнгүүт 2 дахь өгүүлбэр өөрөө заавал байх ёстой юу, үгүй юү гэдэг дээр л ер нь Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, асуудал яригдсан гэж ойлгоод байна .../минут дуусав./

Д.Цогтбаатар: Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Харин тийм. Энэ дээр бол яг хууль тогтоогчийн бас бодлого явсан. Таны асууж байгаа энэ 47 дугаар зүйлийн тэр 6 өөрөө хоорондоо зөрчилдөөд байгаа юм биш биз дээ гэсэн санаа. Үндсэн хуулийн цэц бол шууд энэ 2 заалт зөрчилдөж байна гэж үзээгүй шийдвэрт нь, үндэслэл дээрээ тийм байхгүй. Энийг бол тэр шинэ томилгоо хийх гэж байна гэж үзсэн байгаа юм. Өөрөөр хэлбэл шүүхэд цус сэлбэх гэж хийсэн байна гэж үзсэн байгаа юм. Тийм. Хууль тогтоогч үнэхээр шүүхэд бас цус сэлбэх гэж энийг хийсэн нь үнэн. Яагаад гэхээр энэ шүүхийн шинэ реформыг хуучин хүмүүс улдан хуулийг хэрэгжүүлэхгүй байх, саад болохгүй байх.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Энхбаяр гишүүн гүйцээж хариулах уу? Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Тийм үзэл санаа хууль тогтоогчийн бодлого байсан уу гэвэл бас нэг хэсэг нь байсан. Энэ 47.6 яг одоо практик дээр хэрэгжих дээр их асуудал гарахгүй гэж үзэж байгаа юм. Яагаад гэхээр Монгол Улсын Үндсэн хуульд

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

зааснаар шүүгчээр 25 жил ажилласан, мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан хүнийг шүүгчээр томилохоор байгаа юм.

Тэгэхдээ өнөөдөр хууль, эрх эрх зүйч мэргэжлийн боловсролыг манайх 5 жилээр олгож байгаа. 18 настай хүүхэд сургуульд орно, хэдтэй эрх зүйч болох вэ? Ингээд хуульч гэдэг мэргэжлийнхээ шалгалтыг өгч, хуульчийн сертификатаа авахын тухайтад эрх зүйч мэргэжлээрээ 2 жил ажилласан байх шаардлага тавьж байгаа. Өөрөөр хэлбэл, хамгийн минимум-аар бодоход 24 хүрчихнэ гэсэн үг. Ингээд шүүгчээр ажиллахын тулд.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Микрофон гүйцээгээд өгье.

Б.Энхбаяр: Шүүгчээр ажиллахын тулд дахиад шаардлага тавигдаж байгаа. Тэгэхээр өөрөөр хэлбэл цаашдаа Монгол хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль болон Шүүхийн тухай хуульд зааснаар яг 25-тай хүн ёстой гоц ухаантан байгаад 2, 3 жил 10 жилдээ анги алгасчхаагүй л бол ер нь хамгийн багадаа 28 хүрч байж, хамгийн багадаа шүү 28 хүрч байж л шүүгч болох гээд байгаа юм.

Тийм учраас саяын энэ ярьж байгаа 30 жил ажиллаад 55 нас хүрчихсэн гэдэг энэ гаргах гэж байгаа заалт бол яг практик дээр бас ийм тохиолдол гарах нөхцөл байдал бас үүсэхгүй байх аа гэсэн ийм бодолтой байгаа. Саяын хэлж байгаа бүх насаар нь томилж байгаа, гэж байгаа Америк, Японы туршлагыг хүртэл би Үндсэн хуулийн цэц дээр хуулиудыг нь орчуулж өгсөн. Мөн Германыг өгсөн. Тухайн нөхцөл байдал дээр тухайн шүүгчийн ачаалал, тэр онцлог хэргийг хүртэл авч үздэг юм байна л даа.

Өөрөөр хэлбэл, тэтгэвэрт гарах насыг тогтоох тэр аргачлал дээрээ ямар шүүгчээр ажилласан бэ гэдгийг бас авч үздэг юм байна. Жишээлбэл, гэр бүлийн шүүгч нар их ачаалалтай байдаг юм байна. Өөрөөр хэлбэл, дандаа гэр бүлийн маргаан, тэнд тийм хэрүүл гэхэд хаашаа юм тийм хэрэг рүү ордог учраас маш их тийм мэргэжлийн сэтгэл зүйтэй байх ёстой. Өөрөөр хэлбэл, хохирогчийн тэр сэтгэл зүйд автаад байх байхгүй, дархлаатай байх ийм шаардлага тавигддаг юм байна.

Эрүүгийн хэргийн шүүгч нар тэр хүн амины маш онц ноцтой хэрэг учралыг үздэг учраас өөрөө хувь хүнийхээ хувьд мөн хохирогч болж байдаг юм байна. Тийм учраас яг практик дээр авч үзэхэд уучлаарай яг одоо практик дээр шүүгчийн ажлыг хүнд ажилд тооцдог. Маш хүнд ажилд. Ер нь тэтгэвэрт гараад бас их уддаггүй гэж үздэг юм байна. Тийм учраас бид шүүгчээ бас бодох ёстой болчихоод байгаа байхгүй юу.

Д.Цогтбаатар: Одоо 1 шүү дээ тээ. Уянгахишиг гишүүний микрофоныг өгье.

Г.Уянгахишиг: Яах вэ ерөнхий санааг нь ойлгоод байна л даа. Тэгэхээр тэртээ тэргүй хэрэглэгдэхгүй заалт гэж бодож байгаа бол байх шаардлагагүй нэгдүгээрт тийм ээ. Саяын тооцооллоор байх тэгээд л эхний өгүүлбэрээрээ байж байхад болж байна шүү дээ.

Хоёрдугаарт, Яагаад Үндсэн хууль зөрчсөн ч гэдэг юм уу, яагаад ялгавартай байдал бий болгож байна гэдгийг хараад байна гэхээр 1 дүгээр өгүүлбэр дээрээ 60 нас хүрсэн бол гээд байж байгаа юм. Тэгээд 55 нас хүрсэн бол өөрийн хүсэлтээр

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

болно гэж байгаа юм. Тэгчхээд 2 дахь өгүүлбэр дээр ч 5 жил илүү ажиллачихсан бол заавал тэтгэвэртээ гар аа гэдэг нөхцөл тавьчихаад байгаа байхгүй юу. Тэгээд тийм учраас энэ дээр бол нийгмийн баталгаа гэж харж байгаа юм бол би олон жил ажиллачихсан 25 жилийг гүйцээчихсэн юм аа тийм болохоор би тэтгэвэртээ гаргамаар байна аа тэтгэврээ тогтоолгомоор байна аа гэж байгаа бол 1 дүгээр өгүүлбэр хангалттай.

Гэтэл 2 дугаар өгүүлбэр чинь өөрөө ч 5 жилийн илүү туршлагатай. Тэгэхдээ ч 60 нас хүрээгүй 55-д.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Харин тэрийг чинь л Үндсэн хууль зөрччихсөн байна гээд энд гаргачхаад байна шүү дээ. Тийм тэгвэл та дэмжиж байгаа юм байна шүү дээ? Тийм яг үнэн. Харин тийм. Зөв зөв. Гүйцээгээд үгээ хэлье.

Г.Уянгахишиг: Тийм, тийм учраас энэ заалтыг өөрөө Үндсэн хууль зөрчсөн байна буюу буцаагаад яг 60-тай 25 жил ажилласан, эсвэл 55 насанд хүрсэн хүн өөрийн сайн дураар тогтоолгож болно гэдэг заалтыг хүчээр заавал тогтоолгох ёстой болгож, заалт болгож нэмж оруулсан нь өөрөө энэ ялгаатай байдлыг үүсгэж байгаа гэдэг энэ Үндсэн хуулийн дүгнэлтийг дэмжиж байгаа гэсэн үг. Тийм.

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Би Үндсэн хуулийн дүгнэлтийг бас хүлээж авах шаардлагагүй буюу бас эргээд энэ бас нюанстай л гэдэг зүйлийг хэлэх гэсэн юм. Шүүхийн хуулийг явж байхад бас яг түрүүн Энхбаяр гишүүн бас өөрийн чинь хариулт Уянгахишиг гишүүний асуултад хариулж байгаад хэлчихлээ. Бас энэ олон талаас нь бодож үзсэн юм. Ерөөсөө ингээд яг тэтгэвэрт гараад энэ их оюуны ажил хийж байсан, стресст дунд, бухимдал дунд явж байсан хүмүүс бас их уддаггүй ээ. Тэгээд ер нь ийм статистикаа гаргачихсан байдаг байсан. Би энийг хуулийн хувийн хэргээс авч үзээгүй учраас бас шууд тэд гээд хэлж чадахгүй байна. Маш тэтгэвэрт гарснаасаа хойш 3, 4 жилийн хугацаанд ялангуяа эрчүүд нь гэж байгаа юм. Ингээд бас нэлээн ажил амьдралын стрессээс болдог юм уу ингээд хорвоог орхихихдог.

Тийм учраас ер нь энэ ойлголтыг 30 жил гэдгээр бас авч үзэх нь бас энэ хүнд хүчир ажил хийж байгаа хүмүүст зүйтэй гэдэг үүднээс энэ тухайн үедээ бас энэ томьёоллыг ярилцаж хийж байсан. Эхнийх мэдээж боломж байна. Хоёр дахь бас тухайн хүнээ буюу бодож байгаа ийм зүйлүүд байгаа.

Хоёрдугаарт, бид тухайн үедээ энэ тэтгэвэрт гараад байж байгаа шүүгчийн асуудлыг тэр чигт нь тэтгэвэрт гараад энэ системээс явуулах тухай ерөөсөө яриагүй байхгүй юу. Туршлагатай шүүгч нараар шүүхийн дэргэдэх тэр судалгааны академи энэ тэр рүүгээ илүү их залах нь чухал юм байна. Тэндээ ашиглах нь чухал юм байна. Арбитр дээр ажиллах бололцоог нь бас уян хатан байдлаар өгч болох юм байна. Тэгээд нэгдүгээрт хуульчийн нөөц манайд байдаг. Тэгээд энэ оюуны юу учраас бас энэ сонголт, энэ Үндсэн хуулийн заалтын хүрээ хязгаарыг бас ингэж ойлгох нь зүйтэй гэж энэ бас шүүхийн хуулийг тухайн үедээ бас тал талын төлөөлөлтэй боловсруулах ажлын хэсгээс үзсэн юм.

Тийм учраас энэ ингээд батлагдаад явсан байх. Тэгэхдээ яах вэ энэ хууль ямар ч хэрэгжээд алдаа мадаг байхгүй байхад нэг зүгээр сонирхол байна уу даа. Би зүгээр яах вэ бодлоо хэлж байгаа шүү. Манай Лодойсамбуу бодлоо хэлж байна

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

гээд байдаг юм байна лээ. Энэ яах вэ зүгээр Улсын дээд шүүх дээр хэдэн нөхдүүд тэтгэвэрт гарахгүй л гэж л үзэж байна л даа. Яах вэ 5, 6 нөхдүүдийн тэтгэвэрт гарах насны юм яригдаж байгаа юм байна лээ. Дахиад 5 жил сунах тэр л арга чаргаа хайж байна. Тэгээд би зүгээр эцсийн дүндээ энд их тийм шүүхийн хүний нөөцөд сүртэй нөлөөлөөд байх юм байхгүй. Харин ч бид шүүгчээр ажиллаж байгаа тэр хүнийг дараагийн тэтгэврийн дараах амьдралаа зохиох тэр бололцоог нь олгож байгаа ийм л зүйлүүдийг ярьсан. Яах вэ зүгээр энэ тусгай хүчний байгууллагууд тэтгэвэрт гараад бас уддаггүй гээд, прокурор бас мөн энэ үзүүлэлтийг бас ярьдаг.

Тийм учраас энийг бас энэ талаас нь бодож бас хийсэн шүү. Тэрнээс биш их тийм Уянгахишиг гишүүний хэлж байгаа шиг эхний хэлж байгаа шиг эхний 47 дугаар зүйлийн яг таны уншаад байгаа байхад хангалттай сайн, дурынхаараа байхад хангалттай гэж ерөөсөө хэлж боломгүй байгаа юм. Тэгээд би бас ийм учраас энийг бас Цэцийн дүгнэлтийг хүлээж авах шаардлага байхгүй юм болов уу. Хууль хэрэгжээд явж байгаа. Хуулийг нэгэнт л хэвшүүлэх ёстой шүү дээ. Тэгэхгүй ингээд яг үгүй.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Энэ дээр манайхан нэг юмыг бодоорой. Наад хууль чинь Сайнзориг гишүүн ээ өөрөө Австралид төгссөн тээ? Наадах чинь баруунд байгаа шүүгчид яг ид ажлынх нь үед аваачаад цавчиж байгаа байхгүй юу. Яг ид туршлага нь хуримтлагдаад, шийдвэрээ гаргах ийм боломжтой болоод ирэнгүүт. Тэгэхдээ өөрийг чинь сая хэлж байна шүү дээ. Ингээд энийг ингээд боловсон хүчний нөөц хангалттай. Одоо ингээд тэтгэвэрт нь гарчихсаны дараа академид авчихна эд нар гээд та тэрийг өнөөдөр өөрөө урьдчилж хаана тэр хүмүүс очих вэ. Энэ бол энэ хуулийн хүрээнд бид нарын ярих асуудал ч биш. Тэрийг бид шийдэж ч мэдэхгүй. Энэ дээр миний харж байгаагаар хамгийн гол асуудал байна Сайнзориг гишүүн ээ. Юу гэвэл байна шүү дээ одоо энэ чинь 25 настай хүн бол явчихад энэ ингээд болж байгаа бол 30 настай болоод ирэнгүүт тэр ялгавар шууд өөрөө ажиллаад эхэлж байгаа байхгүй юу. 30 жил нь хүрээгүй байхад таныг шууд гар гээд байгаа байхгүй.

Тэгээд хуулийг чинь угаасаа энэ дээр цэвэр хууль ярихад тэр бөгөөд гэж байгаа чинь тэр хоёр хоёулаа хэрэгжих ёстой ийм заалт. Түүнээс алтернатив утгатай биш байгаад байгаа байхгүй юу. Тэгэхлээр би энэ дээр юу гэж бодож байна гэхлээр энэ Үндсэн хуулийн цэцийн энэ дүгнэлт бол үндэслэлтэй л байна гэж би үзээд байгаа юм. Тэгээд Үндсэн хуулийн энэ цэцийн дүгнэлтийг бид нар энэ дээр, тэр яг шүүгчдийн, тэгээд өшөө Шүүхийн тухай хууль дээрээ шүүгчид бүх насаараа байна гээд өөрөө бас заалттай байж байгаа байхгүй юу. Манай хуулиуд ч гэсэн өөрөө дотроо ийм зөрчилтэй байгаад байгаа юм. Тэгээд энийг би Үндсэн хуулийн цэцийг үндэслэлтэй байна л гэж үзэж байна.

Асуултаа таслаагүй байгаа юм уу? Тэгвэл одоо ингээд үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү энэ асуудлаар.

Уянгахишиг гишүүнээр тасаллаа. Үг хэлье. Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Үндсэн хуулийн юу, Шүүхийн тухай хууль 2021 оны 1 сард батлагдаж, 2021 оны 3 сараас хүчин төгөлдөр үйлчилж өнөөдөр 4 дэх жилдээ болж байна. Энэ хугацаанд Үндсэн хуулийн цэцэд Шүүхийн тухай хууль Үндсэн хууль зөрчиж байгаа асуудлуудаар нийтдээ 10 гаруй удаагийн өргөдөл, гомдол очиж, тэр бүрийд Үндсэн хууль зөрчөөгүй байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

дүгнэлтүүд гарч, шүүхийн шинэтгэл тодорхой хугацаагаар амилах боломжийг бий болгож ирсэн. Үндсэн хуулийн цэцэд хүндэтгэлтэй хандаж байгаа. Энэ байр сууриа ч гэсэн Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцох хугацаандаа илэрхийлж хэлж явсан байдаг. Үндсэн хуулийн цэц дээр миний бие Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцох хугацаандаа нэг улс төрийн байр суурийг илэрхийлснээ хууль тогтоогч та бүхэнд бас хэлье гэж бодож байна.

Яагаад гэхээр Цэцийн хуралдаан шууд дамжуулагддаггүй юм байна. Протокол нь бас гардаггүй юм байна. Тэгээд Улсын Их Хурлын хууль тогтоогч өөрөө энийгээ хамгаалж байгаа тэр байр сууриуд олон нийтэд тэр дотроо хуулиа баталсан хууль тогтоогч нарт ерөөсөө хүрэхгүй байдаг учир дутагдал бас байна. Энэ дотор илэрхийлсэн байр суурь бол бид шүүхийн хараат бус байдал, бие даасан байдлыг хангах дээр хууль тогтоогч баталгаатай, туйлбартай зогсож байгаа. Тэр дотроо манай Хууль зүйн байнгын хороо шүүгчийн нийгэм, эдийн засгийн баталгааг хангах, томилогдсон этгээдээс хараат бус байх, шүүгч, шүүгчдээсээ хараат бус байх, шүүхийн дотоод ардчиллын бэхжүүлэх зэрэг тодорхой шинэтгэлүүдийг үе шаттай хийж яваа. Энэ үзэл санаанд хууль тогтоогчдын зүгээс бас их хариуцлагатай, бодитой дэмжлэгүүдийг үзүүлж ирсэн.

Нөгөө талд энэ шүүхийн хараат бус байдлыг хангах чиглэлд хууль тогтоогч цаашдаа анхаарах 1 асуудал байгааг би зориуд тэмдэглэсэн. Тэр нь Монгол Улсын Дээд шүүхийн шүүгчдийн тоог бид нар Үндсэн хуульд бичээгүй байгаа. Улсын Их Хурлын гишүүдийн тоо Үндсэн хуульд байдаг, Үндсэн хуулийн цэцийн гишүүдийн тоо Үндсэн хуульд байдаг. Улсын Дээд шүүхийн шүүгчдийн тоо Үндсэн хуульд байдаггүй. Тэр ч утгаараа Үндсэн хуулийн хуульд Дээд шүүхийн шүүгчдийн тоог өөрчлөх байдлаар Шүүхийн дээд байгууллагын хараат бус байдлыг алдагдуулж ирсэн, халдаж ирсэн улс, төр эрх зүйн түүх манайд бий. 16 шүүгчтэй байсныг нь 8 болгож байсан. 8 болгож байгаад үгэндээ оруулж байсан түүх байдаг.

Гэтэл дараа нь мөн Элбэгдорж Ерөнхийлөгчийн үед 16 шүүгчтэй байнгуут нь өөрийнхөө үгэнд оруулахын тулд 8-аар нэмж байгаад, 25 болгож байгаад, өөрөө 8 шүүгч томилоод тэгээд Ерөнхий шүүгчийг өөрийн атгад оруулах улс төр бас явж байсан. Тийм ч учраас миний бие Үндсэн хуулийн цэцэд хэлсэн үгэндээ цаашид Үндсэн хуулийн цэц харин Улсын дээд шүүхийн шүүгчдийн тоог өөрчлөх замаар хууль тогтоогч шүүхийн хараат бус байдалд халдах боломжийг хаах ёстой шүү гэдэг санаагаа бас хэлсэн байгаа. Энийг бас хууль тогтоогч эрхэм гишүүд та бүхэн хууль дараагийн дараагийн юман дээр бас бодолцоосой гэж ингэж хүсэж байна.

Д.Цогтбаатар: Уянгахишиг гишүүний микрофоныг өгье.

Түрүүн асуулт асуухдаа бас халт ер нь бол дурдаад хэлсэн. Тэгээд гишүүдийн тайлбарыг сонсож байна. Эндээс бид нар нэг юмыг аягүй сайн ойлгомоор байна. Юу гэхээр жишээлбэл, 30 жил ажиллачихсан ядардаг юм аа ч гэдэг юм уу, тэр хүнийг бодож байна ч гэдэг юм уу хэрвээ тэр бол өөрөө сонголттой боломж өгсөн заалт байх ёстой. Тэрнээс биш чи ядарчихсан, чи яв аа, би чамайг бодож байна аа гээд ийм хүчээр заалт оруулах нь өөрөө бас зөв биш байхгүй юу.

Тийм учраас би эхний өгүүлбэр байхад хангалттай юм байна гэж хэлээд байгаа нь тэр. Өөрөөр хэлэх юм бол эхний өгүүлбэр юу вэ гэхээр 55 нас хүрсэн, эсвэл 25 жил ажиллачихсан бол өөрийнхөө хүсэлтээр тэтгэврээ тогтоолгож болж

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

байна. Хамгийн гол нь энэ боломж хөгжөөд байгаа гээд байгаа 2 дахь өгүүлбэр чинь өөрөө ч 30 жил ажиллачихсан тэгээд 55 нас хүрчихсэн бол шууд тэтгэвэр тогтоолгоно гэдэг ийм зайлшгүй хэрэгжих шинжтэй заалт болж орж ирчхээд байгаа байхгүй юу.

Тийм учраас хэрвээ яг л саяын хэлж байгаа гишүүдийн санаа бодол агуулагдаж байгаа бол 1 дүгээр өгүүлбэр хангалттай. Харин 2 дугаар өгүүлбэр буюу 55 нас хүрсэн 30 гээд тэр нь ингээд заримдаа сонсоод байхаар тодорхой хүмүүст зориулагдсан ч юм шиг юм яриад байна шүү дээ. Тэгэхээр ийм байж болохгүй. Энэ чинь өөрөө ялгаварлал үүсгэж байна, эрх тэгш байх гэдэг тэр яг зарчим чинь алдагдаж байгаа санаа бүүр энэ саяын тайлбарууд дээр сонсогдоод байгаа байхгүй юу. Тийм учраас би бол Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт зөв гарчээ л гэж харах гээд байна.

Д.Цогтбаатар: Эрдэнэболд гишүүний микрофоныг өгье.

С.Эрдэнэболд: Ер нь энэ аливаа шийдвэр гаргахын тулд статистик ингээд судалгаануудыг яг л үндэслэлтэй л харж л хийхгүй болохоор бид нар чинь бүгдээрээ антропологич ч юм шиг ингээд янз бүрийн судлаачдын аягүй их зардал, цаг хугацаа зарцуулж хийх ажлыг өөрсдийн ажиглалт гэж бодсон зүйлээрээ хууль тогтоох ч гэдэг юм уу, энэ шийдвэр гаргах явцад яриад байна. Тэр тусмаа энэ Хууль зүйн байнгын хороон дээр энэ их зохимжгүй гэж үзээд байгаа юм. Жишээлбэл, ямар жишээ байдаг вэ гэхлээр АНУ-ын ерөнхийлөгч болж байгаа улс төрчид жирийн хүнээс хурдан хөгширдөг гэсэн ийм хүмүүсийн яриаг нотолж үзэх гээд, судалж үзэх гээд судалгаа гарахаар тийм биш байдаг нь нотлогддог ч гэдэг юм уу.

Тэгэхээр бид нар яг ингээд нийгэмд болж байгаа үйл явдлуудыг юу гэдэг юм хүний нас нь юу гэдэг юм ялангуяа эрэгтэйчүүд дараа нь богино настай байдаг ч гэдэг юм уу. Яг ийм зүйл заавал судалгааны үндсэн дээр энэ бид нар хариуцлагатай хэлж байх ёстой л доо. Өнөөдөр яах вэ ингээд аль аль талд нь шийдвэр гараад явчихна. Цаашдаа Улсын Их Хурлын гишүүд аливаа шийдвэр гаргахдаа хувь хүний үзэл бодлоо илэрхийлэхдээ зайлшгүй судалгаан дээр суурилж хэлэх ёстой зүйлийг ингээд шууд хувь хүний итгэл үнэмшил гэдэг нэрийн доор хэлээд байх нь шийдвэр гаргалтад аягүй хэцүү.

Тийм учраас бол асуудлыг зөв, буруу гэхээсээ илүүтэйгээр эд бүгдээрээ ер нь аль болохоор энэ статистик бэйсед/based/ буюу судалгаанд суурилсан тэр тусмаа энэ тооцоолол эд нар дээр суурилсан юм хэлэхгүй болохлоор энэ чинь ингээд олон нийт өргөн нэвтрүүлгийн телевизээр шууд гарч байгаа, өө эд нар чинь асуудалд хандахдаа ингэж ханддаг юм байна шүү дээ гэсэн ийм хөнгөмсөг байр суурийг бас Их Хурлын гишүүд маань илэрхийлмээргүй л байгаа юм. Энэ санааг л хэлэх гэсэн юм.

Д.Цогтбаатар: Дэмжиж үг хэллээ.

Би түрүүн өөрийнхөө байр суурийг хэлчихсэн. Энэ дээр яг ид ингээд үнэхээр барууны шүүгчид би энэ Каприо гээд шүүгчийг харж байдаг байхгүй юу. Үнэхээр энэ хүн бол бүр ингээд бүх насаараа шүүгч хийчихсэн, аягүй ахмад хүн. Тэгэхдээ тэр хүний үнэхээр хуримтлуулчихсан туршлага, тэр гаргаж байгаа шийдвэрүүд бол аягүй үндэслэлтэй нарийн байдаг. Хүн чинь бүх насны мэдлэг, боловсрол, нэмээд

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

туршлага хоёр нийлж байж л тэр шударга ёсны юу чинь хамтарч гарч байдаг учраас энэ дээр би энэ Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг дэмжиж байгаа. Тэгээд энэ дэмжиж байгаа үүднээсээ би бас үгээ хэлж байгаа юм.

Нөгөө талаасаа энэ хууль дээрээ, Шүүхийн хууль дээрээ өөрөө шүүгчийг бүх насаар нь томилно гэгчихсэн заалт байж байгаа шүү угаасаа. Яагаад гэвэл шүүхийг хараат бус байдлаас гаргахын тулд юу их хэрэгтэй гэхлээр шүүгчдийг дандаа л солихыг хүсдэг байхгүй юу. Дарга нар хүрч ирчхээд л дандаа солихыг хүсдэг. Тэгэнгүүтээ хамгийн түрүүн сольдог аргууд ер нь төрийн албанд юу байдаг вэ гэхлээр тэтгэвэрт гаргана гэдэг юугаар ингээд л дараагийнхаа өөрийнхөө хүнийг тавиад явдаг байхгүй юу. Тэгтэл тийм эрсдэлээс шүүгчид ангид байх ёстой. Тэр утгаараа л би энэ Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг энэ сууриар нь нэлээн харж шийдсэн байна аа гэж үзэж байгаа юм. Тэгээд дэмжиж байгаа.

Тэгээд санал хураалт явуулъя.

Санал хураалтыг түр зогсооё.

Ингэе энэ асуудал дээр хэдүүлээ ул суурьтай хандана. Би бүх бас Байнгын хорооныхоо гишүүдийг энд оролцож явах ёстой гэж бодож байна. Яагаад гэвэл энэ улсын шүүхийн хараат бус байдлын тухай асуудал яригдаж байгаа юм шүү.

Тийм учраас энд шүүхийн ерөнхий тогтолцоогоо бүхэлд нь харж байж шийдвэр гаргах ёстой. Тийм учраас одоо би хурлыг хойшлуулж байна. Тэгээд дараа нь бид нар энэ дараагийн долоо хоногоос хурал хуралдахад энэ асуудлаа нэгэнт хэлэлцээд эхэлчихсэн явж байгаа юм чинь. Тэгнэ тэгнэ тийм. Тийм бүр дуусгаад тэгээд дараагийн долоо хоногоос асуудлаа оруулж ирье.

Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад хурлын ирц хангалттай биш байгаа учраас хурлыг дараагийн долоо хоног хүртэл хойшлууллаа. Санал хураахад хангалттай ирц байхгүй учраас.

20.22 цаг

**ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Д.ОТГОНДЭЛГЭР